



УДИРДАГЫН  
АКАДЕМИ

**УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН  
БОДЛОГО, “ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО-2030”-ЫН  
ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ ШАЛГУУР  
ҮЗҮҮЛЭЛТИЙН СУДАЛГАА:  
ДУТУУ БАЙГАА ШАЛГУУР  
ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ БОЛОВСРУУЛАХ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

034

Улаанбаатар хот  
2022 он

## **УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, “ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО-2030”-ЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН СУДАЛГАА: ДУТУУ БАЙГАА ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ БОЛОВСРУУЛАХ**

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрхийг хуулийн дагуу хамгаалсан болно. Бүтээлийг бүтнээр буюу хэсэгчлэн хувилах, нийтлэх, электрон системд оруулах болон бусад ямар нэг хэлбэрээр олшруулахыг хориглоно.

### **СУДАЛГААНЫ БАГ**

#### **Багийн ахлагч:**

Доктор, дэд профессор Ж.Нарантуяа

#### **Зөвлөх:**

Академич Г.Чулуунбаатар

#### **Судлаачид:**

Докторант Ё.Батсүх

Магистр П.Бямбасүрэн

Докторант Б.Ганцоож

Магистрант С.Дарьмаа

"Мөнхийн Үсэг" ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

## **АГУУЛГА**

<b>ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ</b> .....	<b>V</b>
<b>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ</b> .....	<b>VI</b>
<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b> .....	<b>VIII</b>
<b>ӨМНӨХ ҮГ</b> .....	<b>IX</b>
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ</b> .....	<b>1</b>
1.1. Судалгааны суурь мэдээлэл.....	1
1.2. Судалгааны асуудал .....	5
1.3. Судалгааны зорилго, асуулт, зорилтууд.....	9
1.4. Судалгааны ач холбогдол, шинэлэг байдал .....	11
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО-2030</b> .....	<b>12</b>
2.1. Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого, Тогтвортой хөгжлийн зорилго-2030, түүний шалгуур үзүүлэлтүүд.....	12
2.2. “Шийдвэр гаргалт”-ыг Тогтвортой Хөгжлийн Зорилгын шалгуур үзүүлэлт 16.7.2-ын хүрээнд хэрхэн ойлгох тухайд.....	17
2.3. Судалгааны үзэл баримтлал: ТХЗ-ын Монгол Улсад тооцож байгаа шалгуур үзүүлэлтүүдийг хэмжих арга зүйд хийсэн харьцуулсан тойм шинжилгээнд хамаарах ойлголтууд, тодорхой кейс буюу “Шийдвэр гаргалт нь олон нийтийг тэгш оролцуулсан, иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй”-г иргэдийн санаа бодлоор судлах ТХЗ- 16.7.2-ын шалгуур үзүүлэлтийн ойлголтын нарийвчилсан тодорхойлолт/операционализац.....	25
2.3.1. ТХЗ-ын Монгол Улсад тооцож байгаа шалгуур үзүүлэлтүүдийг хэмжих аргачлалд хийсэн харьцуулсан тойм шинжилгээний үзэл баримтлал ....	25
2.3.2. Шийдвэр гаргалт нь олон нийтийг тэгш оролцуулсан, иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй эсэхийг иргэдийн санаа бодлоор тодорхойлох ТХЗ- 16.7.2-ын шалгуур үзүүлэлтийн үзэл баримтлал.....	32
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ</b> .....	<b>37</b>
3.1. Судалгааны дизайн: үндэслэл, судалгааны арга .....	37
3.2. Эх олонлог, түүвэр .....	42
1. Түүврийн хүрээ .....	44
2. Түүврийн домэйн.....	44
3. Түүврийн хэмжээ.....	44
4. Түүврийн хуваарилалт .....	45
5. Түүврийн сонголт .....	46
6. Нөөц нэгж.....	46
7. Судалгааны үр дүн, түүврийн жин болон алдаа тооцох .....	46
3.3. Судалгааны найдвартай ба оновчтой байдал .....	47
3.4. Судалгааны ёс зүй.....	55
3.5. Өгөгдөл шинжилгээ .....	55
<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ДЭЛХИЙН ТХЗ-ЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН МОНГОЛ УЛС ДАХЬ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХАРЬЦУУЛСАН ТОЙМ ШИНЖИЛГЭЭ</b> .....	<b>58</b>
4.1. ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон эх сурвалжуудын харьцуулалт .....	58
4.2. Харьцуулсан тойм шинжилгээнд ашиглах субстантив контент шинжилгээний үзүүлэлтийг тодорхойлох нь .....	64
4.3. Харьцуулсан тойм шинжилгээний үр дүн .....	65

4.3.1. “Шалгуур үзүүлэлтийн нийцэл” буюу нэгдүгээр үзүүлэлтийн шинжилгээний үр дүн .....	65
4.3.1.1. Шалгуур үзүүлэлтийн “Алсын хараа-2050” бодлогын зорилготой логик уялдаа /шууд/ холбоотой эсэх .....	65
4.3.1.2. Шалгуур үзүүлэлтийн төрөл .....	67
4.3.1.3. Шалгуур үзүүлэлтийн нэршлийн орчуулгын нийцтэй байдал .....	69
4.3.2. “Мэдээлэл цуглуулах аргачлал” буюу хоёрдугаар үзүүлэлтийн шинжилгээний үр дүн .....	72
4.3.3. “Шалгуур үзүүлэлтийн өгөгдөл/утга” буюу гуравдугаар үзүүлэлтийн шинжилгээний үр дүн .....	77

**ТАВДУГААР БҮЛЭГ. ДЭЛХИЙН ТХЗ-ЫН МОНГОЛ УЛСАД ТООЦОХГҮЙ  
БАЙГАА ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ШАЛТГААНЫГ ТОДОРХОЙЛОХ  
СУРВАЛЖИЛГЫН АРГААР ХИЙСЭН СУДАЛГАА..... 82**

5.1 Ерөнхий тойм.....	82
5.2 Сурвалжилгын өгөгдлийн шинжилгээний дүн.....	85

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ. “ТООЦООГҮЙ БОЛОН ДУТУУ ТООЦОЖ БАЙГАА ШАЛГУУР  
ҮЗҮҮЛЭЛТЭЭС” КЕЙС БОЛГОЖ СОНГОЖ АВСАН ТХЗ 16.7.2 ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН  
ТУРШИЛТ СУДАЛГАА..... 93**

6.1. ТХЗ-ын 16.7.2 кейс шалгуур үзүүлэлтийг туршсан судалгааны өгөгдөл боловсруулалт.....	93
6.2. Туршилт судалгааны гол үр дүн.....	101

**ДОЛООДУГААР БҮЛЭГ. КЕЙС БОЛГОН СОНГОЖ АВСАН ТХЗ 16.7.2-ЫН ШИЙДВЭР  
ГАРГАЛТ НЬ ОЛОН НИЙТИЙГ ТЭГШ ОРОЛЦУУЛСАН, ИРГЭДИЙН САНАЛЫГ  
ТУСГАСАН ҮР ДҮНТЭЙ ГЭДЭГТ ИРГЭД ИТГЭХ САНАА БОДЛЫН ТҮВШИНГ  
ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ТОГТООХ СУДАЛГАА..... 104**

**НАЙМДУГААР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ, САНАЛ ..... 116**

**ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ ..... 127**

**АРАВДУГААР БҮЛЭГ. ХАВСРАЛТ..... 131**

Хавсралт 1. “Алсын хараа-2050”-д тусгагдсан ТХЗ-ын Зорилго 16-тай уялдаатай зорилтууд .....	131
Хавсралт 2. Шалгуур үзүүлэлтийн хэмжилтийн арга зүйг үнэлэх үзүүлэлт ба тэдгээрийн утга .....	135
Хавсралт 3. НҮБ-аас боловсруулсан шалгуур үзүүлэлтүүдийн дэд үзүүлэлтийг Монгол Улсад өөрчилсөн үзүүлэлтүүд .....	139
Хавсралт 4. НҮБ-аас боловсруулсан шалгуур үзүүлэлтүүдийг өөр шалгуур үзүүлэлтээр орлуулсан үзүүлэлтүүд .....	143
Хавсралт 5. Дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт.....	145
Хавсралт 6. Үндэсний статистикийн хорооны тооцсон түүврийн дизайн.....	153
Хавсралт 7. Сурвалжилгын төлөвлөгөө .....	156
Хавсралт 8. Жишээ: Сурвалжилгын өгөгдөлд үндсэн утгын шинжилгээ (thematic analysis) хийсэн нэгтгэл .....	158
Хавсралт 9: Сурвалжилгын аргаар илэрсэн тооцох боломжгүй байгаа шалгуур үзүүлэлтийн шалтгаан /14 байгууллагын хувьд/ .....	160

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн улс
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖҮХ	Жендэрийн үндэсний хороо
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг Эрхлэх газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МД	Мэдээллийн дугаар
МУ	Монгол Улс
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
ӨНЭЗС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТБ	Төрийн байгууллага
ТЗБ	Төрийн захиргааны байгууллага
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ТХҮБ	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
УИХ	Улсын Их хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ФЭЗХ	Философи, эрх зүйн хүрээлэн
ХАА	Хөдөө аж ахуй
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ШУА	Шинжлэх ухааны академи
ШҮ	Шалгуур үзүүлэлт
ШҮЛБ	Шалгуур үзүүлэлтийн логик бүтэц
ШҮХЛБ	Шалгуур үзүүлэлт хоорондын логик бүтэц
ЭЗХАХОУБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн олон улсын байгууллага
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
OECD	Organisation for Economic Co-operation and Development
KMO	Kaiser – Meyer - Olkin
MNG	Mongolia
SDG	Sustainable Development Goals
UNDP	United Nations Development Programme
UNECE	United Nations Economic Commission for Europe
UNSD	UN Statistics Division

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Монгол Улс 2016 оноос хойш ТХЗ-ын нийт шалгуур үзүүлэлтийн мэдээллийн бэлэн болсон байдал оноор .....	2
Хүснэгт 2.	Монгол Улсад тооцон гаргаж буй үзүүлэлтийн мэдээллийн бэлэн байдал.....	5
Хүснэгт 3.	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтийн тоо .....	14
Хүснэгт 4.	Шийдвэр гаргах үйл явцын үе шатууд .....	18
Хүснэгт 5.	ТХЗ-ын Шалгуур үзүүлэлт 16.7.2-ын “Гадаад үр дүн” үндсэн ойлголтыг хэмжих операционализиаци .....	36
Хүснэгт 6.	Шалгуур үзүүлэлтийг хэмжих арга зүйг үнэлэх үзүүлэлт.....	38
Хүснэгт 7.	Сурвалжилгын төлөвлөгөө боловсруулахад туслах суурь мэдээлэл .....	38
Хүснэгт 8.	Сурвалжилгын төлөвлөгөө.....	39
Хүснэгт 9.	Түүврийн хэмжээ.....	45
Хүснэгт 10.	Түүврийн хэмжээ бүс болон аймгаар.....	45
Хүснэгт 11.	Вашингтон Группийн 6 асуулт.....	47
Хүснэгт 12.	Асуултад хариулах хугацааг туршсан байдал, судалгаанд оролцогчдын мэдээлэл .....	50
Хүснэгт 13.	Фактор шинжилгээ хийх нөхцөл хангасан байдал (КМО болон Бартлеттийн тест).....	51
Хүснэгт 14.	Асуултаудын бүлэг/бүрэлдэхүүн/фактор .....	52
Хүснэгт 15.	Rotated component matrix.....	53
Хүснэгт 16.	Олон нийтийг тэгш оролцуулсан шийдвэр гаргалт бүрэлдэхүүний найдвартай байдлын шинжилгээ .....	54
Хүснэгт 17.	Олон нийтийг тэгш оролцуулсан шийдвэр гаргалт бүрэлдэхүүний найдвартай байдлын коэффициентын дундаж.....	54
Хүснэгт 18.	Иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй гаргалт бүрэлдэхүүний найдвартай байдлын шинжилгээ .....	54
Хүснэгт 19.	Иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй шийдвэр гаргалт бүрэлдэхүүний найдвартай байдлын коэффициентын дундаж .....	55
Хүснэгт 20.	Үндсэн асуултауд, хэмжих шкал (Ликертийн 5 шкал) .....	56
Хүснэгт 21.	Баримт бичигт туссан шалгуур үзүүлэлтүүдийн тоо .....	59
Хүснэгт 22.	Нэмэлт өөрчлөлт оруулсан 5 шалгуур үзүүлэлт.....	60
Хүснэгт 23.	НҮБ-аас боловсруулж гаргасан шалгуур үзүүлэлтийн түвшин/ангилал .....	61

Хүснэгт 24. НҮБ-аас тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн түвшин ба Монгол Улс дахь шалгуур үзүүлэлтүүдийн бэлэн байдал хоорондын харьцуулалт.....	62
Хүснэгт 26. ТХЗ-ын Монгол Улсад тооцож байгаа шалгуур үзүүлэлтийн "Алсын хараа-2050" бодлогын зорилготой логик уялдаа /шууд/ холбоотой эсэхийг тодорхойлсон байдал.....	67
Хүснэгт 27. Шалгуур үзүүлэлтийн төрөл .....	68
Хүснэгт 28. Шалгуур үзүүлэлтийн орчуулгын нийцтэй байдал.....	69
Хүснэгт 29. НҮБ болон Монгол Улсын ШҮ-ийн тооцох арга зүйн зөрүүтэй байдал .....	72
Хүснэгт 30. НҮБ болон Монгол Улсын боловсруулсан шалгуур үзүүлэлтийн тооцох арга зүй болон дэд үзүүлэлт нь яг тохирч байгаа боловч, өгөгдлөө цуглуулахдаа зөрүүтэй байдаг үзүүлэлтүүд.....	75
Хүснэгт 31. НҮБ-ын болон Монгол Улсын аргачлалаар мэдээлэл цуглуулах давтамжийн харьцуулалт .....	76
Хүснэгт 32. Үндсэн болон дэд шалгуур үзүүлэлтийн 2016-2020 оны статистик утгыг боловсруулсан байдал.....	78
Хүснэгт 33. ШҮ-ийн утгыг 2016-2020 онд тооцсон байдал.....	78
Хүснэгт 34. ШҮ нь дэд үзүүлэлттэй эсэх.....	79
Хүснэгт 35. Дэд ШҮ-ийн утгыг 2016-2020 онд тооцсон байдал .....	80
Хүснэгт 36. НҮБ болон Монгол Улсын ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн зөрүүтэй байдал .....	81
Хүснэгт 37. Сурвалжилгын аргаар илэрсэн тооцох боломжгүй байгаа шалгуур үзүүлэлтийн шалтгаан /14 байгууллагын хувьд/ .....	83
Хүснэгт 38. Сурвалжилгын өгөгдлийн шинжилгээнээс илэрсэн утга .....	85
Хүснэгт 39. ТХЗ хариуцсан хүний нөөц, удирдлага, зохион байгуулалт дэд утгын хүрээнд илэрсэн утга санаа .....	86
Хүснэгт 40. Үндсэн асуултуудын дундаж үнэлгээ, харьцуулалт (Mean) .....	102
Хүснэгт 41. Үндсэн асуултууд, хэмжих шкал (Ликертийн 5 шкал) .....	103
Хүснэгт 42. Түүвэрт хамрагдсан оролцогчдын хүн ам зүйн статистик.....	104
Хүснэгт 43. Үндсэн асуултууд, түүний хэмжилтийн үр дүн .....	106

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Монгол Улсад хамаарах ТХЗ, зорилт, шалгуур үзүүлэлтүүдийн тоо .....	4
Зураг 2. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – Монгол Улсад .....	13
Зураг 3. Олон нийтийг тэгш оролцуулсан, тэдний саналыг тусгасан үр дүнтэй шийдвэр гаргалтын гадаад үр дүн .....	24
Зураг 4. Үр дүнгийн хэлхээ холбоо буюу логик бүтэц.....	26
Зураг 5. Үр дүнгийн хэлхээ холбоо буюу логик бүтцийн пирамид хэлбэр .....	28
Зураг 6. ТХЗ -ын Зорилт 16.7 .....	33
Зураг 7. Судалгааны үе шат, ерөнхий дизайн.....	42
Зураг 8. Судалгаанд оролцогчдын нас (хувь).....	95
Зураг 9. Судалгаанд оролцогчдын хүйс (хувь) .....	96
Зураг 10. Хоёр асуултад эерэг хариулт өгсөн оролцогчдын дундаж хувь үндэс, угсаагаар (хувь) .....	97
Зураг 11. Судалгаанд оролцогчдын эерэг хариултын дунджийг боловсролын түвшнээр (хувь).....	98
Зураг 12. Судалгаанд оролцогчдын нэг сарын орлого (хувь) .....	99
Зураг 13. Судалгаанд оролцогчдын хоёр асуултын эерэг хариултын дундаж ажил эрхлэлтээр (хувь).....	100
Зураг 14. Төр засаг иргэдийнхээ санаа бодлыг анхааран сонсох боломжийг бүрдүүлсэн эсэх талаар судалгаанд оролцогчдын үнэлгээ (хувь).....	101
Зураг 15. Төр засгийн шийдвэрт иргэдийн санаа бодол хэр зэрэг нөлөөлдөг талаарх судалгаанд оролцогчдын үнэлгээ (хувь) .....	102
Зураг 16. Манай төр засаг иргэдийнхээ санаа бодлыг анхааран сонсох боломжийг хэр зэрэг бүрдүүлсэн гэж Та бодож байна? .....	107
Зураг 17. Манай төр засгийн шийдвэрт иргэдийн санаа бодол хэр зэрэг нөлөөлдөг гэж Та бодож байна? .....	108
Зураг 18. Хоёр хариултын дундаж хувь, хүйсээр.....	109
Зураг 19. Хоёр хариултын дундаж хувь, насны бүлгээр .....	110
Зураг 20. Хоёр хариултын дундаж хувь, байршлаар.....	110
Зураг 21. Хоёр хариултын дундаж хувь, орлогын бүлэглэлтээр.....	111
Зураг 22. Хоёр хариултын дундаж хувь, боловсролын түвшнээр .....	112
Зураг 23. Судалгаанд хамрагдсан хүн амын эзлэх хувь, хөгжлийн бэрхшээлийн байдлаар .....	113
Зураг 24. Хоёр хариултын дундаж хувь, үйлдлийн чадварын хүндрэлээр .....	113
Зураг 25. Хоёр хариултын дундаж хувь, үйлдлийн чадварын хүндрэлийн төрлөөр.....	114
Зураг 26. Хоёр хариултын дундаж бүсээр.....	115
Зураг 27. Харьцуулалтын шинжилгээний үр дүн .....	118



## ӨМНӨХ ҮГ

НҮБ-аас санаачилсан Тогтвортой хөгжлийн зорилго-2030-ыг 2016 оноос хойш дэлхий нийтээр хэрэгжүүлэхээр олон улсын өмнө үүрэг хүлээж, нэгдсэн улс орнуудын нэг нь Монгол Улс билээ. НҮБ-аас боловсруулж гаргасан нийт 248 шалгуур үзүүлэлтийн /2022 оны 6-р сарын 09-ний байдлаар/ 132-ыг нь Монгол Улсад тооцож байна. “Алсын хараа-2050” бодлогын баримт бичгээс түлхүүр үгнүүдээр нэг бүрчлэн хайлт хийхэд ТХЗ-ын 248 шалгуур үзүүлэлтийн 95 нь буюу 38.3%<sup>1</sup> нь Монгол Улсын “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигтэй шууд уялдаа холбоотой байна. Иймд дэлхийн ТХЗ-ыг хэрэгжүүлнэ гэдэг нь Монгол Улсын урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэх нэг арга зам болох нь харагдаж байна.

Энэ судалгаанд НҮБ-аас дэвшүүлсэн шалгуур үзүүлэлтүүд болон Монгол Улсын шалгуур үзүүлэлтүүдийг харьцуулж авч үзэхээс гадна өнөөгийн байдлаар тооцож байгаа шалгуур үзүүлэлтийн ангилалд байгаа ТХЗ-ын **16.7.2-ыг** тусгайлан кейс болгон судалсан. 16.7.2 гэсэн шалгуур үзүүлэлтийг бид судалснаараа НҮБ-ын боловсруулсан мета өгөгдлийн арга зүй, аргачлалын дагуу манай нөхцөлд шууд ашиглаж, тооцох боломж бүрэн байгааг **судалгаагаар харуулсан**. Манай улс дэлхийн ТХЗ-ыг Монголд тохирох байдлаар нутагшуулах боломж нь нээлттэй, нутагшуулахын тулд **“ялгаатай”** байх нь ойлгомжтой гэж үзэж байгаа ч үнэхээр хэрэгжүүлэх боломжгүй арга зүй, аргачлал байна гэж үзсэн тохиолдолд л түүнийг орлуулах үндэслэлийг ул суурьтай, нарийн боловсруулах нь зүйн хэрэг юм. Харин олон улсад удаа дараа туршигдаж, боловсруулсан арга зүй, аргачлалыг манай нөхцөлд шууд ашиглаж, тооцох боломж бүрэн байгаа тохиолдолд нь түүнийг нь баримталбал олон улсад харьцуулагдах нөхцөл бүрдэнэ гэж үзлээ.

Бидний судалгаагаар тооцож буй 133-аас НҮБ-аас боловсруулсан арга зүйгээс ялгаатай нийт 33 шалгуур үзүүлэлт байгааг тодорхойллоо. Монгол Улсын хувьд мэдээлэл гарах боломжгүй байгаагаас шалтгаалан 102 шалгуур үзүүлэлт тооцохгүй байгаа нь тухайн үзүүлэлтийн **суурь түвшин нь** гарах боломжгүй байна гэсэн үг. Иймээс **зорилтот түвшнээ тодорхойлохын тулд суурь түвшний судалгаа хийх хэрэгцээ байгаа нь** харагдаж байна. Иймд төрийн байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа чухал болохыг энэ судалгаа харуулсан юм. Учир нь төрийн байгууллагууд хамтран ажиллаж,

<sup>1</sup> Монгол Улсын “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигтэй шууд уялдаа холбоотой гэж тооцогдсон 95 үзүүлэлтийг НҮБ-аас гаргасан 248 шалгуур үзүүлэлтэд харьцуулж хувиар илэрхийлсэн.

судалгаа, шинжилгээг хамтран хийснээр ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг НҮБ-ын мета өгөгдөлд зөвлөсөн аргачлалын дагуу тооцох боломжтойг бидний судалгааны кейс болгож сонгож авсан 16.7.2 шалгуур үзүүлэлтийн судалгаа харууллаа. НҮБ-ын санал болгосон **16.7.2-ын арга зүйг Монгол Улсад шууд ашиглаж, тооцох боломжтой ба улмаар олон улсын хэмжээнд зөвлөсөн арга зүйг баримталснаар суурь тооцооллыг гаргаж ирэхээс гадна дэлхий нийтэд харьцуулагдах нөхцөл байдал бүрдэж байгаа** юм. Иймээс Удирдлагын академийн судлаачид энэ арга зүйгээр ҮСХ-той хамтран ажиллаж, Монгол Улсад **энэ шалгуур үзүүлэлтийн суурь түвшинг дэлхийн олон оронд туршигдсан олон улсын аргачлалаар** тодорхойлсноороо ач холбогдолтой боллоо гэж дүгнэж байна.

Ийнхүү тус судалгаа нь зөвхөн судалгааны ажил болоод зогсохгүй цаашид Удирдлагын академийн Улс төрийн орчин, Төрийн бодлого, Бодлогын шинжилгээ, Судалгааны арга зүй хичээлийн чиглэлээр жишээ болгон ашиглах, төрийн захиргааны ажилтнууд шийдвэр гаргалт, шийдвэр гаргалтын гадаад үр дүнгийн тухай онол, практикийн мэдээллийн сурвалж болгон ашиглахаас гадна, багш, судлаачид, суралцагчдад судалгаа хийхэд нь аргагүйн эх сурвалжийн нөөц болох боломжтой юм.

Энэ судалгаанд хамтран ажиллаж ирсэн Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо, Судалгаа шинжилгээ, түүврийн хэлтсийн дарга О.Норовсамбуу, Бодлого, гадаад харилцааны хэлтсийн дарга Г.Ялалт, Бодлого, гадаад харилцааны хэлтсийн ТХЗ хариуцсан ажилтан Ж.Болортуяа, судалгааны явцад дэмжин тусалж ирсэн Удирдлагын академийн захирал Д.Сүрэнчимэг, Удирдлагын академийн Судалгааны төвийнхөн болон хэлэлцүүлэг бүрд албан ёсны санал, шүүмжийг харамгүй өгч ажилласан профессор Ш.Батсүх, профессор Я.Бямбасүрэн болон бусад эрдэмтэн судлаач багш нартаа гүн талархал илэрхийлж байна. Мөн судалгаанд шаардлагатай өгөгдөл, мэдээллийг цуглуулахад дэмжлэг туслалцаа үзүүлсэн яамдын холбогдох ажилтнууд, судалгаанд оролцож, өөрсдийн санаа бодлоо нээлттэй хуваалцсан төрийн захиргааны албан хаагчдад Судалгааны багийнхан чин сэтгэлээс талархаж буйгаа илэрхийлье.

Судалгааны багийн ахлагч  
Жүгдэрийн Нарантуяа

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ

## 1.1. Судалгааны суурь мэдээлэл

Анх 2012 онд Рио Де Жанейро хотод дэлхийн улс орнуудын төрийн тэргүүнүүдийн уулзалтын үеэр НҮБ-ын “Тогтвортой хөгжил” бага хурлаар “Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр”-ийг санаачлан, улмаар 2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 70 дугаар чуулганаар уг хөтөлбөрийг баталсан байна. Тус чуулган “Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр”-ийн хүрээнд Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ын **17 зорилго, 169 зорилтыг** баталж, 2016 оны 1дүгээр сарын 1-нээс албан ёсоор **дэлхий нийтээр хэрэгжүүлж** эхэлсэн ба дэлхийн улс орон эдгээр зорилготой холбоотой мэдээллийг илгээж, нэгтгэдэг болжээ. Энэ ТХЗ-ыг 2015 онд хэрэгжилтийн хугацаа нь дууссан “Мянганы хөгжлийн зорилтууд”-ын үргэлжлэл гэж үздэг ба ТХЗ нь **нийгэм, эдийн засаг, байгаль орчин** гэсэн гурван тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх **дэлхий нийтийн урт хугацааны бодлогын баримт бичиг** юм. Ийнхүү ҮСХ-ноос 2021 онд гаргасан тайланд 2017 оны 3 сард НҮБ-ын Статистикийн комиссын 48-р чуулганаар ТХЗ-ын хэрэгжилтийг дүгнэх 244 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон ба 2020 оны 3 дугаар сард хуралдсан НҮБ-ын Статистикийн Комиссын 51 дүгээр чуулганаар ТХЗ-ын 244 шалгуур үзүүлэлтийн хүрээнд зарим өөрчлөлтийг оруулж, давтагдсан тоогоор нийт 247, давтагдаагүй тоогоор 231 үзүүлэлт баталсан байна хэмээн тусгажээ (ҮСХ, 2021).

Харин Монгол Улсын Их хурал 2016 оны 2 дугаар сард Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 (ТХҮБ-2030) тогтоолыг баталсан ба уг “ТХҮБ-2030” - үзэл баримтлалын 4 бүлэг, 44 зорилт энэхүү НҮБ-аас баталсан “ТХЗ-2030” хөтөлбөртэй уялдаж байсан байна. ТХЗ-ын үндэсний үзүүлэлтийг тодорхойлох, суурь болон хүрэх зорилтот түвшинг тодорхойлох арга зүйг боловсруулах 9 ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2016 оны 44-р захирамжаар байгуулан ажиллажээ (ҮСХ, 2022 <http://sdg.1212.mn>). Үндэсний статистикийн хороо (ҮСХ) нь ТХЗ-ын хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтүүдийн гарах бэлэн байдалд хийсэн судалгаа, мөн НҮБ-тай хамтарсан болон ҮСХ-ноос бие даасан гээд нийт 5 удаагийн үнэлгээний судалгааг хийсэн байна (<http://sdg.gov.mn/Home/Availability>). **ҮСХ-ноос албан ёсны статистикийн мэдээлэл болон захиргааны статистикийн мэдээллийг ашиглан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг төсөл хэлбэрээр урьдчилсан байдлаар 2015-2017 оноор тооцон гаргажээ.** УИХ-ын 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 38 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т “Тогтвортой хөгжлийн үзүүлэлтийн

хүрээг тодорхойлж, арга зүйг боловсруулж, мөрдөх” гэж заасныг хэрэгжүүлэх үүднээс ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлалыг бий болгох зайлшгүй шаардлага буй болжээ. 2019 оны хагас жилээр Монгол Улсын Засгийн газар ТХЗ-2030-ын хэрэгжилтийн тухай Үндэсний сайн дурын илтгэлийг бичиж, НҮБ-д танилцуулсан баугтайланд хэрэгжилтийг хянах 244 шалгуур үзүүлэлтээс Монгол Улс одоогийн байдлаар хэрэгжилтийг хянах 118 үзүүлэлтийг тооцох аргачлал, мэдээллийн эх үүсвэрийг бий болгоод байна хэмээн дурдсан бол ҮСХ-ны 2019 оны жилийн эцэст хийсэн ТХЗ-ын хэрэгжилтийн үнэлгээгээр 132 шалгуур үзүүлэлтийг Монгол Улс тооцож байгаа тухай хөндсөн (ҮСХ, 2022). ТХЗ-ын үндэсний шалгуур үзүүлэлтийн аргачлалыг боловсронгуй болгох, зорилтын хүрэх түвшинг тодорхойлох зорилгоор олон салбарын төлөөлөл орсон 8 дэд ажлын хэсгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 29 дүгээр тушаалаар байгуулжээ. Түүнчлэн “Засгийн газар дангаар ТХЗ-ыг хэрэгжүүлэх боломжгүй учир “төрийн нэгдмэл бодлого, зохицуулалттай байх” (“all-of-government”) “бүх нийтийн оролцоог хангах, цогц байх” (“all-of-society”) зарчмыг баримталж, засаг захиргааны бүх түвшинд, хувийн хэвшил, иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллагууд, ялангуяа, эмзэг бүлгийн хүн амын бүлгүүдийн идэвхтэй оролцоог хангаж, хамтран ажиллахад цаашдын арга хэмжээг чиглүүлэх нь чухал ач холбогдолтой юм” (Монгол Улсын ЗГ, 2019, Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт:18-19) гэж онцолсон байна. Монгол Улс 2016 оноос хойш ТХЗ-ын нийт шалгуур үзүүлэлтийн хэдийг нь бэлэн болгосон бэ гэдгийг он оноор нь тогтоовол дараах байдалтай байна (Хүснэгт 1-ээс харна уу).

### Хүснэгт 1. Монгол Улс 2016 оноос хойш ТХЗ-ын нийт шалгуур үзүүлэлтийн мэдээллийн бэлэн болсон байдал оноор

Он	Түвшин 1-д харьяалагдах шалгуур үзүүлэлтийн тоо	Тухайн жилд бэлэн болсон Шалгуур үзүүлэлтийн тоо	Түвшин 1-д харьяалагдах шалгуур үзүүлэлтийн эзлэх хувь	Мэдээлэлгүй дутуу шалгуур үзүүлэлт
2016	60	60	26.3%	
2017	113	53	48.5%	
2018	118	5	50.6%	
2019	132	14	56.7%	<b>112</b> (Tier II ) (Tier III )
2020	-	-	-	-
2021	-	-	-	<b>102</b>

Эх сурвалж: Судалгааны баг


Дээрх хүснэгтээс харахад Монгол Улс 2019 оноос хойш бэлэн болгосон шалгуур үзүүлэлтийн тоог нэмээгүй байна. Иймээс яагаад хариуцсан байгууллагууд шалгуур үзүүлэлтийн тооцооллоо бэлэн болгож чадаагүй вэ гэсэн асуултыг тодруулах хэрэгцээ гарч ирж байна. **Монгол Улсад хамгийн сүүлд 2021 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн ҮСХ-ны даргын тушаалаар “Тогтвортой хөгжлийн зорилгын мэдээлж буй шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлал” батлагдсан байна.** Энэхүү аргачлалын зорилгыг “тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтүүдийг тооцох олон улсын нийтлэг арга зүйд нийцүүлэн өөрийн улс орны онцлогийг тусгасан нэгдсэн ойлголт, арга зүйн мэдээллээр статистикийн мэдээлэл гаргагч болон хэрэглэгчийг хангахад оршиж байна” хэмээн тодорхойлж байгаа боловч өөрийн улс орны онцлогийг тусгасан гэх ойлголтын далд утга нь НҮБ-аас боловсруулж гаргасан шалгуур үзүүлэлтийн үзэл баримтлал, утга, агуулга, хэмжилтийн арга зүйд өөрчлөлт оруулсан эсэх, хэрэв оруулсан бол ямар шалтгаанаар, ямар зарчмаар яаж өөрчилсөн нь анхаарал татахуйц байж болох юм. Гэхдээ энэхүү аргачлалд ҮСХ-ноос тооцон тархааж байгаа ТХЗ-ын 129 шалгуур үзүүлэлтийн тооцох аргачлалыг НҮБ-ын Статистикийн хэлтсийн ТХЗ-ын мета өгөгдөл болон холбогдох салбарын аргачлалыг ашиглан боловсруулсан тухай дурджээ (ҮСХ, Тогтвортой хөгжлийн зорилгын мэдээлж буй шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, 2021, хууд. 3).

Аргачлал нь тухайн үзүүлэлтийн зорилт, тодорхойлолт, ойлголт, тооцох арга зүй, мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа, хариуцах байгууллага, тайлбар, лавлагаа гэсэн хэсэгтэй. Тайлбар хэсэгт олон улсын аргачлалаас зөрүүтэй тохиолдол болон тухайн үзүүлэлтийг орлуулсан бол ямар үзүүлэлтээр орлуулж тооцсон талаар тусгасан. ТХЗ-ын 17 зорилго тус бүрт хамаарах зорилтуудыг хянах шалгуур үзүүлэлтүүдийг бодлогын түвшинд хариуцах, мөн мэдээллийг хариуцан гаргаж ажиллах яам, агентлаг, төрийн байгууллагууд, их дээд сургууль, судалгаа шинжилгээний байгууллага, иргэний болон бизнесийн холбоо, хоршоолууд зэрэг институцуудыг зааж өгсөн байна. Улмаар зорилт тус бүрт хамаарах шалгуур үзүүлэлтийг зарим тохиолдолд өөр өөр байгууллага хариуцахаас гадна тэдгээр нь тус бүрдээ биеэ даасан судалгаа шаардахуйц өргөн агуулгатай болох нь харагдаж байна. Иймээс нийт 17 зорилго, 169 зорилт, 247 шалгуур<sup>2</sup> үзүүлэлтийг нэг дор нэг судалгаагаар хийх тухай ойлголт байх боломжгүйгээс гадна энэ олон байгууллага, иргэний нийгэм, бизнесийн байгууллага, их дээд сургууль, судалгааны байгууллагууд уялдаатай ажиллаж, тодорхой зорилт, шалгуур үзүүлэлт дээр ажиллаж, судалж гаргахаар заасан байна. 2017 оны байдлаар ҮСХ-ны судалгаагаар Монгол Улсаас одоогийн байдлаар 1). бэлэн байгаа мэдээлэл, 2). мөн гаргах боломжгүй, 3). мэдээллийн эх үүсвэр байхгүй гэсэн гурван ангиллаар ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг

2 НҮБ-аас 2022 оны 06 сарын 9-ний өдөр гаргасан эх сурвалжид 11.5.2 гэх шалгуур үзүүлэлтийг 11.5.2 болон 11.5.3 гэж хоёр шалгуур үзүүлэлт болгон хуваасан тул Зорилт 11 нь 15 шалгуур үзүүлэлттэй болсон. Үүнээс үүдэн нийт 248 шалгуур үзүүлэлттэй болсон.

жагсааж байсан бол (ҮСХ, [http://sdg.1212.mn/Home/Not\\_indicators](http://sdg.1212.mn/Home/Not_indicators)), 2022 оны байдлаар ҮСХ нь ТХЗ-ын мэдээллийн бэлэн байдлыг гаргахдаа дэлхийн ТХЗ-оос 16 зорилго, 159 зорилт, 234 үзүүлэлт нь Монголд хамааралтай гэж тодорхойлжээ (Зураг 1-ийг харна уу). Үүнээс 132 үзүүлэлтийн мэдээллийг холбогдох газар, төрийн 17 байгууллагаас цуглуулан авч нэгтгэн тархаасан ба 84 үзүүлэлтийг ҮСХ албан ёсны статистикийн мэдээллийн эх үүсвэрээс тооцож байна. Монгол Улсад хамааралгүйд ТХЗ-ын 14-р зорилго буюу далай, тэнгис, далайн нөөц баялгийг хамгаалах, тогтвортой ашиглах гэсэн зорилго, түүний 10 зорилт, мөн 13 хамааралгүй үзүүлэлтэд 3, 2, 5-р зорилгын 1-р үзүүлэлтүүд болон 14-р зорилгын 10 үзүүлэлтийг багтаасан байна.

### Зураг 1. Монгол Улсад хамаарах ТХЗ, зорилт, шалгуур үзүүлэлтүүдийн тоо



Эх сурвалж: ҮСХ, Тогтвортой хөгжлийн зорилтын мэдээллийн бэлэн байдал, 2022

Гэхдээ ҮСХ-ноос тодорхойлсон энэхүү тоо нь эцсийн шийдвэр биш бөгөөд бодлогын түвшинд буюу Эдийн засаг хөгжлийн яам үндэсний үзүүлэлтийн хүрээг хэрхэн шийдэхээс шалтгаална. Тухайлбал, ҮСХ-ны ТХЗ-ыг хариуцсан холбогдох хүмүүстэй уулзаж ярилцахад “ЭЗХЯам нь Далай тэнгистэй холбоотой асуудал чухал. Далайд гарцгүй хэдий ч далайд гарч далайн баялгийг ашиглана гээд хамааралтай гэж үзээд оруулбал бид нар тэрэнд шаардлагатай мэдээллийг гаргах үүрэгтэй” хэмээн тайлбарлаж байв. Ийнхүү ҮСХ-ны сүүлчийн мэдээллээр Монгол Улсад хамааралтай давтагдсан байдлаар 234 шалгуур үзүүлэлт байгаа ба тэдгээрээ **тооцож байгаа, тооцох боломжгүй байгаа** гэж хоёр ангилан гаргаад байна (Хүснэгт 2 -оос харна уу).

## Хүснэгт 2. Монгол Улсад тооцон гаргаж буй үзүүлэлтийн мэдээллийн бэлэн байдал

Зорилгын дугаар	Нийт үзүүлэлтийн тоо	Тооцож байгаа үзүүлэлт	Монгол Улсад хамааралгүй	Тооцох боломжгүй байгаа үзүүлэлт
Зорилго 1	13	8	-	5
Зорилго 2	14	7	-	7
Зорилго 3	28	17	2	9
Зорилго 4	12	9	-	3
Зорилго 5	14	9	1	4
Зорилго 6	11	6	-	5
Зорилго 7	6	5	-	1
Зорилго 8	16	14	-	2
Зорилго 9	12	6	-	6
Зорилго 10	14	5	-	9
Зорилго 11	<b>14<sup>3</sup></b>	7	-	7
Зорилго 12	13	3	-	10
Зорилго 13	8	4	-	4
Зорилго 14	10	0	10	-
Зорилго 15	14	5	-	9
Зорилго 16	24	17	-	7
Зорилго 17	24	10	-	14
Нийт	<b>247</b>	<b>132</b>	<b>13</b>	<b>102</b>
Хувиар	<b>100</b>	<b>53.4</b>	<b>5.3</b>	<b>41.3</b>

Эх сурвалж: YCX, Тогтвортой хөгжлийн зорилтын мэдээллийн бэлэн байдал, 2022-д суурилав

Эндээс харахад ТХЗ-2030 шалгуур үзүүлэлтийн мэдээллийг бүрдүүлэхээр зохих байгууллагууд ажилласаар байгаа ба Үндэсний үзүүлэлтүүдийн хүрээг УИХ-аар эцэслэн батлахыг хүлээн, эцсийн үр дүн гараагүй байна.

### 1.2. Судалгааны асуудал

**Судалгааны асуудлаа нарийвчлан тодорхойлох зорилгоор**, ЗГХЭГ-ын захиалгат судалгааны сэдэвт агуулагдаж буй "дутуу байгаа шалгуур үзүүлэлт боловсруулах" хэмээх ойлголтыг энэ судалгаанд хэрхэн ойлгож, тодорхойлох нь хамгийн чухал байлаа. Энэ ойлголт нь шууд утгаараа Монгол Улсад огт байхгүй байгаа шалгуур үзүүлэлтийг боловсруулж гаргах, эсвэл огт тооцогдоогүй байгаа шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж, улмаар арга зүйг нь боловсруулах

3 НҮБ-аас 2022 оны 6 дугаар сарын 09-ний өдөр гаргасан эх сурвалжид 11.5.2 гэх шалгуур үзүүлэлтийг 11.5.2 болон 11.5.3 гэж хоёр шалгуур үзүүлэлт болгон хуваасан тул Зорилт 11 нь 15 шалгуур үзүүлэлттэй болсон нийт 248 шалгуур үзүүлэлт, Монгол Улсад тооцогдож байгаа 133 шалгуур үзүүлэлт болсон.

гэсэн утгыг агуулж байгаа юм. Гэтэл НҮБ-аас гаргасан эх сурвалжид дэлхий нийтээрээ тогтвортой хөгжлийн нийт 248 шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэхээр тодорхойлоод, улмаар арга зүйг нь боловсруулчихсан, харин үүнээс ҮСХ-ны тодорхойлсноор 133 шалгуур үзүүлэлтийг Монгол Улс тооцож байгаа, 13 шалгуур үзүүлэлт Монгол Улсад хамааралгүй, 102 шалгуур үзүүлэлт нь тооцох боломжгүй байна. Иймээс тооцох боломжгүй 102 шалгуур үзүүлэлтийг “дутуу байгаа шалгуур үзүүлэлт” гэж ойлгохуйц уншигдаж байна. Гэтэл 2022 оны 2 дугаар сарын 4-ний байдлаар НҮБ-аас гаргасан ТХЗ-ын бүх шалгуур үзүүлэлт нь үндсэндээ түвшин 1 (Tier I ) болон түвшин 2 (Tier II ) гэсэн ангилалд багтсан байна. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл, НҮБ-ын өнцгөөс авч үзвэл ТХЗ-ын бүх шалгуур үзүүлэлтүүдийн концепц нь тодорхойлогдсон, олон улсын түвшинд арга зүй болон стандарт нь батлагдсан гэдгийг илтгэж байгаа юм. НҮБ-ын зүгээс шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо Түвшин 1-ийн шалгуур үзүүлэлт гэдэгт концепц нь тодорхойлогдсон, олон улсын түвшинд батлагдсан арга зүй, стандарттай ба улс орнууд мэдээллээ доод тал нь 50% нь байнга нийлүүлдэг, харин Түвшин 2-т байгаа шалгуур үзүүлэлт гэдэг нь концепц нь тодорхойлогдсон, олон улсын түвшинд арга зүй болон стандарт нь батлагдсан боловч улс орнуудаас мэдээлэл нь тогтмол нийлүүлэгдэхгүй байгааг, эсвэл аргачлал, стандартыг туршиж байгаа шалгуур үзүүлэлтийг хамааруулжээ. Эндээс авч үзвэл **дутуу байгаа шалгуур үзүүлэлт гэдэг нь** үндсэндээ Түвшин 2 (Tier II)-т хамаарагдах шалгуур үзүүлэлтүүд мэт харагдаж байна.

Иймээс тус судалгаанд сэдвийн **“дутуу байгаа шалгуур үзүүлэлт боловсруулах”**<sup>4</sup> гэсэн ойлголтыг МУ-ын Хөгжлийн бодлогын үзэл баримтлал, Үр дүнд суурилсан менежментийн (Global Affairs Canada, 2018) хүрээнд тайлбарлагддаг шалгуур үзүүлэлтийн тухай ойлголтын тодорхойлолтод үндэслэн дараах шалтгаанаар **“тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт”** гэсэн ангилалд хамааруулан нэрлэж, судалгааны бүхий л шатанд баримталсан. Үүнээс шалгуур үзүүлэлт гэж юуг хэлэх вэ, шалгуур үзүүлэлт боловсруулах гэж юуг хэлэх вэ гэсэн үндсэн ойлголтын тухай 2-р бүлэгт, үүнээс 2.1 болон 2.3.1 гэсэн хэсгүүдэд дэлгэрэнгүй тайлбарласан болно. Үүний учир нь,

**Нэгдүгээрт,** Монгол Улсад тооцох боломжгүй 102 шалгуур үзүүлэлтийг яагаад тооцож болохгүй байгаа эсвэл тооцож байгаа 133 шалгуур үзүүлэлтээс яагаад, юунаас шалтгаалан заримыг нь орлуулах, ойролцоо утга бүхий үзүүлэлтээр хэмжиж байгааг шинжлэх нь чухал гэж үзлээ.

**Хоёрдугаарт,** тооцож байгаа боловч **олон улсын аргачлалаас ялгаатай** боловсруулж тооцсон шалгуур үзүүлэлтийг хамруулан судлах хэрэгцээ байна гэж харлаа. Учир нь, ТХЗ-ын Монгол Улсын тодорхойлсон шалгуур үзүүлэлтийг хэмжих арга зүй, аргачлал, бүрдэл хэсэг нь НҮБ-ын тодорхойлсонтой харьцуулж

<sup>4</sup> Энэ судалгаанд сэдвийн “дутуу байгаа шалгуур үзүүлэлтийг боловсруулах” гэдгийг цаашид “тооцоогүй, дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт” гэсэн нэршлээр явна.



үзэхэд **яагаад ялгаатай** байгаа нь **үндэслэлтэй байх нь зохистой**. Энд “**ялгаатай**” гэдгийг тодорхойлохдоо НҮБ-ын боловсруулсан мета өгөгдлийн арга зүй, аргачлалыг манай нөхцөлд шууд ашиглаж, тооцох боломж харагдаж байгаа боловч өөр, ойролцоо утгаар орлуулан тооцсон тохиолдлыг хэлнэ. Учир нь манай улс дэлхийн ТХЗ-ыг Монголд тохирох байдлаар нутагшуулах боломж нь нээлттэй, нутагшуулахын тулд “**ялгаатай**” байх нь ойлгомжтой гэж үзэж байгаа ч үнэхээр хэрэгжүүлэх боломжгүй арга зүй, аргачлал байна гэж үзсэн тохиолдолд л түүнийг орлуулах үндэслэлийг ул суурьтай, нарийн боловсруулах нь зүйн хэрэг юм. Харин олон улсад удаа дараа туршигдаж, боловсруулсан арга зүй, аргачлалыг манай нөхцөлд шууд ашиглаж, тооцох боломж бүрэн байгаа тохиолдолд нь түүнийг нь баримталбал олон улсад харьцуулагдах нөхцөл бүрдэнэ гэж үзлээ.

**Гуравдугаарт**, Монгол улсын хувьд хамааралгүй гэж үзсэн 13 шалгуур үзүүлэлтийг “**тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт**” гэсэн ангилалд оруулсангүй.

Иймээс, “**тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт**” гэсэн **ангилалд** НҮБ-аас боловсруулсан нийт 248 шалгуур үзүүлэлтээс **нэгдүгээрт**, тооцох боломжгүй байгаа шалгуур үзүүлэлтүүд, **хоёрдугаарт**, тооцож байгаа боловч олон улсын аргачлалаас ялгаатай боловсруулж тооцсон шалгуур үзүүлэлтийг тус тус хамруулж байгаа болно. Энэ хоёр чиглэлээр “**тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт**”-ийг тодорхойлохдоо ТХЗ-2030-ын зорилтуудыг хянах шалгуур үзүүлэлт, түүний мэдээллийн эх сурвалж (үүсвэр), мэдээллээ цуглуулах арга зүй, мэдээллийн давтамж, суурь болон зорилтот түвшин зэрэг **хэмжилтийн арга зүйн ойлголтуудыг бүрэн биш тодорхойлсон, эсвэл тодорхойлоогүй дутуу орхигдуулсан байхыг ойлгоно**.

Иймд дээр дурдсанаар 2016 оноос хойш төрийн захиргааны төв байгууллагууд, төрийн бусад байгууллага, их дээд сургууль, судалгаа шинжилгээний байгууллага, иргэний болон бизнесийн холбоо, хоршоолууд зэрэг институциудэд хариуцуулсан “**тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт**”-ийн тоо өнөөг хүртэл буурахгүй байгаа нь ямар шалтгаантай болохыг судлах нь энэ судалгааны гол асуудал хэмээн үзэж байна.

1.1-д дурдсан үнэлгээний судалгаануудаас гаргасан жагсаалтаас Удирдлагын академийн сургалт, судалгааны чиглэлд хамгийн ойр хамаарахуйц, мөн үүрэг хүлээж, хамтран ажилладаг байгууллагад хамаарах үзүүлэлтүүдийг шүүн тоймлож, анализ хийж, матрикт оруулан үзэхэд, 234 шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой яам, агентлаг, байгууллагууд хуваан авч, хариуцаж байгаагаас Монгол Улсын Төрийн албаны зөвлөл (ҮСХ-ны гаргасан мэдээллээр), ЗГХЭГ-т (ЭЗХЯ-ны гаргасан мэдээллээр) хамаарч байгаа ТХЗ-Зорилго 16-гийн 16.7.2 гэсэн шалгуур үзүүлэлт нь бидний судлах чиглэлд шууд хамаарахуйц буюу мөн “**тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур**

**үзүүлэлт”-гэсэн ойлголтод багтаж байгаа тул кейс болгон нарийвчлан судалж үзэх нь чухал хэмээн үзлээ.**

Бидний үзэж байгаагаар кейс болгон судлах **16.7.2** -ыг ҮСХ-ноос тогтмол зохион байгуулдаг “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны хавсралт (модуль) Ардчилсан засаглал судалгаагаар 2018 оноос эхэлж, асуулгаар хэмжиж эхэлсэн байна. Уг судалгаанд **“Та [...] -ийн шийдвэр гаргалт нь хүртээмжтэй, хариуцлагатай хэрэгжиж чаддаг эсэхийг хэрхэн үнэлдэг вэ?”** гэсэн нэг асуултаар Засгийн газар, Ерөнхийлөгч, улс төрийн намууд, нийслэл/аймаг, дүүрэг, хороо, багийн ИТХ болон засаг даргын тамгын газар, дээд шүүх, замын цагдаа, газрын албад, татварын байгууллагууд, төрийн өмчит сургууль, цэцэрлэгүүд, эмнэлгүүд гээд төрийн 30 гаруй байгууллагыг жагсаан нэрлэж, маш сайнаас маш муу гэсэн үнэлгээгээр үнэлэхээр оруулжээ. Гэхдээ энэ асуулгын хэмжилтийн асуулт нь дараах шалтгаанаар **16.7.2**-ыг **“тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт”** гэж тодорхойлж байгаа тул судалж, сайжруулах шаардлагатай болохыг илтгэнэ. Үүнд:

1. Юуны түрүүнд шалгуур үзүүлэлт 16.7.2-т заасан шийдвэр гаргалтын тухай ойлголтод концептуализаци хийгдээгүйгээс одоо хэрэглэж байгаа асуулт нь зорилтот концепцоо илэрхийлэхгүй байна. Учир нь 2018 онд НҮБ-аас уг шалгуур үзүүлэлтийн мета өгөгдөл, тооцох аргачлал нь боловсруулагдаагүй байсан учраас дээрх асуултаар орлуулан прокси үзүүлэлтийг тооцсон. НҮБ нь ТХЗ-ын 16.7.2 шалгуур үзүүлэлтийн мета өгөгдлийн арга зүйг 2019 онд боловсруулж, 2020 оноос ашиглаж эхэлсэн. Тиймээс НҮБХХ-ийн Ослогийн Засаглалын төвөөс дэвшүүлсэн шаардлагыг хангасан мэдээлэл цуглуулах бүрэн боломж байгаа тул тэр шаардлагын хүрээнд дахин тооцох хэрэгтэй. Түүнчлэн тус тусдаа хоёр өөр хэмжээсийг илэрхийлж буй үгсийг нэг асуултад багцлан нэгтгэхдээ, шууд үгээр нь оруулсан байна. Гэтэл “16.7.2-ын үзүүлэлт нь шийдвэр гаргалтын тухай концепц, түүний чанарыг илэрхийлэх “inclusive-олон нийтийг тэгш оролцуулсан” болон “responsive-иргэдийн санаа бодлыг тусгасан үр дүнтэй” гэсэн хэмжээсээр хэмжигдэх ба эдгээр үгс нь нийгмийн шинжлэх ухааны абстракт ойлголтууд тул улам нарийсгаж, тодруулж, иргэдийн асуулгад санаа бодлыг нь асуухаар өдөр тутмын ярианы үг хэллэг оруулан боловсруулахыг зөвлөсөн (Orkin, M., 2017:6).
2. Тухайн одоо хэрэглэгдэж байгаа ганц асуулт нь найдвартай болон оновчтой байдлыг хэрхэн хангасан нь тодорхойгүй. Мөн НҮБ-аас тавьж буй концепцоо илэрхийлж байх ёстой орчуулгын шаардлага хангаагүй. *Inclusive participation in decision-making, responsive decision-making* гэсэн хэмжээсийн ойлголтуудыг хүртээмжтэй, хариуцлагатай гэж орчуулсан нь утга санааг төөрөгдүүлсэн.
3. 16.7.2 шалгуур үзүүлэлт нь одоо байгаа тогтолцоо нь хүмүүс үгээ хэлэх боломжийг хэр их өгдөг, тогтолцоо нь шийдвэр гаргахдаа хүмүүсийн

санаа бодлыг хэр сонсож, нааштай хүлээж авдаг тухай **иргэдийн санаа бодлыг тодорхойлоход чиглэгдсэн байхад** одоо хэрэглэж байгаа дээрх асуулт нь **иргэдээр төрийн институциудыг үнэлүүлэхээр боловсруулагдсан** байна. Жишээ нь, “Ерөнхийлөгчид итгэл хүлээлгэж байгаа иргэдийн үнэлгээг 2017-2020 оноор авч үзэхэд, ерөнхийлөгчид итгэдэггүй гэж хариулсан иргэдийн эзлэх хувь 2017 онд 29.0, 2018 онд 35.3, 2019 онд 29.0, 2020 онд 18.8 хувь, дунд зэрэг гэж хариулсан иргэдийнх 2017 онд 39.7, 2018 онд 38.8, 2019 онд 41.3, 2020 онд 42.2 хувь, итгэдэг гэж хариулсан иргэдийнх 2017 онд 22.7, 2018 онд 18.1, 2019 онд 23.0, 2020 онд 35.2 хувьтай байна.” (Ардчилсан Засаглал Судалгаа, 2021:9) гэж үр дүндээ тайлагнасан байна.

4. Мөн шийдвэр гаргалтын гадаад үр дүнг хэмжих хоёр хэмжээс болох inclusive/олон нийтийг тэгш оролцуулсан, responsive/иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй гэсэн үзүүлэлтүүдийг хамтатган нэг багцад оруулснаас үр дүнг нь ялган салгаж харах боломжгүй байдал харагдаж байна.
5. ҮСХ-ны зохих хүмүүстэй ярилцаж байхад тэд “Та бүхний түрүүний ярьсан 16.7.2 гэсэн үзүүлэлт чинь сайжруулах шаардлагатай байгаа үзүүлэлт. Тэрнийг судлах хэрэгтэй” гэсэн санаа хэлж байсан (2022 оны 3 дугаар сарын 02-ны өдөр ҮСХ дээр хийсэн уулзалтын ярилцлагаас).

Иймээс кейс болгон авсан Зорилт 16.7-ын хүрээнд **“тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт”** болох 16.7.2-ыг ч судалж, зөв суурь мэдээлэл буй болгох шаардлага байгаа нь тодорхой харагдаж байна. Иймээс 16.7.2-ын шалгуур үзүүлэлтэд заасан *“Шийдвэр гаргалт нь олон нийтийг тэгш оролцуулсан, иргэдийн санаа бодлыг тусгасан үр дүнтэй гэж боддог хүн амын эзлэх хувь, хүйсээр, насны бүлгээр, хөгжлийн бэрхшээлтэй хүн амаар, хүн амын бүлгээр”* тодорхойлох нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийг илтгэх нэгэн хэсэг төдийгүй Монгол Улсын Засгийн газар, олон улсын өмнө хүлээсэн үүрэг хариуцлага юм.

Иймд хоорондоо холбоо бүхий дээрх хоёр асуудлыг судлах мэдлэг болон мэдээллийг нөхөх орон зай байна.

### 1.3. Судалгааны зорилго, асуулт, зорилтууд

#### Судалгааны зорилго:

Дэлхийн ТХЗ-2030-ын шалгуур үзүүлэлтийн хэмжих аргачлалыг Монгол Улсын ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулж, **“тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт”**-ийн шалтгааныг тодруулах, мөн кейс болгож сонгож авсан 16.7.2-ыг бүрэн тодорхойлох судалгааг НҮБ-ын тооцох арга зүйн зөвлөмжийг ашиглан хийнэ.

Эл зорилгыг дараах гурван судалгааны асуултын хүрээнд судалж, тогтоохоор дэвшүүлж байна.

### Судалгааны асуулт:

1. НҮБ-ын боловсруулсан шалгуур үзүүлэлтийг хэмжих арга зүй, аргачлалаас Монгол Улсын тооцож байгаа шалгуур үзүүлэлтийн хэмжих арга зүй, аргачлалд ямар ялгаа байна вэ?
2. ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн бэлэн байдлыг хангах зорилгоор холбогдох төрийн байгууллагуудад 2016 оноос хойш хариуцуулсан боловч өнөөг хүртэл **“тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт”** буурахгүй байгаагийн шалтгаан нь юутай холбоотой байна вэ?
3. **“Тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт” ангилалд** кейс болгож сонгож авсан 16.7.2 -ын хувьд дараах асуултыг дэвшүүлсэн.

-Олон нийтэд хамаарах бүх түвшний шийдвэр гаргалт нь олон нийтийг тэгш оролцуулсан, иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй байдаг гэж боддог Монгол Улсын хүн амын итгэх хувь нь хүйсээр, насны бүлгээр, байршлаар, хөгжлийн бэрхшээлтэй хүн амаар, боловсролын түвшин, орлогын бүлгээр хэд байна вэ?

Дээрх судалгааны зорилго, асуултын хүрээнд дараах **зорилтуудыг** тавьж ажиллалаа.

Үүнд:

- Дэлхий дахинаа хэрэгжиж буй тогтвортой хөгжлийн зорилго, Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын тухай ойлголт, тэдгээрийн уялдаа болон түүнтэй холбоотой бусад нэр томъёоны онолын үзэл баримтлалыг судалж, тодорхойлох;
- “Монгол Улсын хувьд дутуу байгаа ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн шалтгааныг илрүүлэх зорилгоор Монгол Улсад тооцож байгаа 133 шалгуур үзүүлэлтийн хэмжилтийн арга зүйд харьцуулсан тойм шинжилгээ хийх, тооцохгүй байгаа 102 шалгуур үзүүлэлтийг хариуцсан холбогдох төрийн байгууллагуудаас яагаад тооцох боломжгүй байгаа вэ? энэ нь шалгуур үзүүлэлтийн хэмжилтийн арга зүйтэй холбоотой юу? гэдгийг сурвалжилгын аргаар тодруулах;
- Монгол Улсад тооцож байгаа боловч **“тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт”** гэсэн ангилалд багтаж буй ТХЗ-ын кейс шалгуур үзүүлэлт 16.7.2-т агуулагдсан шийдвэр гаргалтын тухай ойлголт, түүний онолын үзэл баримтлал, шийдвэр гаргалт нь олон нийтийг тэгш оролцуулсан, үр дүнтэй байдаг гэдэгт Монгол Улсын иргэд ямар бодолтой байгааг Монгол Улсын Үндэсний Статистикийн хороотой хамтран судалж, тодорхойлох;

- Судалгааны үр дүнд суурилан, цаашид энэ судалгааны үр дүн нь ашиглагдах боломжтой байгууллагууд буюу ТАЗ, НҮБ-ын ТХЗ-ыг хариуцсан газар болон Үндэсний Статистикийн хороонд танилцуулах.

#### 1.4. Судалгааны ач холбогдол, шинэлэг байдал

Энэхүү судалгаа нь дэлхий дахинаа НҮБ-ын гишүүн улс орнууд хамтран зорьж, хэрэгжүүлж буй Тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд ТХЗ-2030-ын Түвшин 1 (Tier I), Түвшин 2 (Tier II)-т хамаарах Монгол Улсад тооцож байгаа шалгуур үзүүлэлтүүдийг хэмжих арга зүйд харьцуулсан тойм шинжилгээ хийж, тодорхой кейс буюу **"тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт"** ангилалд багтах ТХЗ-16-гийн хүрээнд буй 16.7.2-ын шалгуур үзүүлэлтийн хэмжилтийн арга зүйг бүрэн тодорхойлох судалгааг НҮБ-ын тооцох арга зүйн зөвлөмжийг ашиглан анх удаа туршилтаар хийх гэж байгаагаараа шинэлэг юм. Энэ утгаараа 16.7.2 буюу "шийдвэр гаргалт нь олон нийтийг тэгш оролцуулсан, иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй байдаг гэдэгт итгэдэг иргэдийн эзлэх хувь" хэмээх шалгуур үзүүлэлтийн суурь түвшинг тогтоох судалгааг Монгол Улсын хэмжээнд анх удаа хийх тул энэ чиглэлд шинэ мэдлэг, шинэ мэдээллийг бүтээхэд хувь нэмэр оруулна.

ТХЗ-ын шалгуур үзүүлэлт 16.7.2-т агуулагдсан шийдвэр гаргалт нь олон түмний оролцоотой, иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй байдаг гэдэгт Монгол Улсын иргэд хэр зэрэг итгэлтэй байгааг ҮСХ-той хамтран судалж, тодорхойлох гэж байгаа нь шинэлэг юм.

*Нэр томьёоны орчуулгын тухайд:* Энэ судалгаанд хэрэглэгдэх монгол хэлнээ хэвшиж амжаагүй, хүмүүст нэг ойлголт болж тогтоогүй зарим гадаад нэр томьёог ойлголтын зөрүү үүсгэхгүй үүднээс хаалтад англиар давхар хадаж өгнө.

# ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО-2030

## **2.1. Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого, Тогтвортой хөгжлийн зорилго-2030, түүний шалгуур үзүүлэлтүүд**

2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар “Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр”-ийн хүрээнд Тогтвортой хөгжлийн (ТХЗ) 17 зорилго, 169 зорилт батлагдсанаас хойш Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг 2015 оны 11-р сард баталсан. Улмаар уг хуулийг 2020 оны 5 дугаар сарын 07-ны өдөр “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хууль болгон шинэчлэн найруулсан билээ. Эл хуульд зааснаар “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” гэж Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, дэлхий нийтийн хөгжлийн түгээмэл хандлагыг өөрийн орны онцлогт тохируулан тусгасан, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, хүний хөгжлийг хангах, эдийн засаг, нийгэм, засаглалын хөгжлийг ахисан түвшинд хүргэхэд чиглэсэн урт хугацааны зорилго, зорилт, хүрэх үр дүн, үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтийг тусгасан баримт бичгийг (4.1.4.) хэлнэ хэмээн заажээ.

Энэхүү хууль нь Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилготой ба дараах зарчим нь энэ судалгаанд баримтлах үндэслэл болж байгаа юм. Үүнд:

1. Үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;
2. Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн байх;
3. Нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;
4. Тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх;
5. Тэнцвэртэй байх;
6. Нөөц, эх үүсвэрт үндэслэсэн байх;
7. Ил тод, нээлттэй байх;
8. Судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
9. Зорилго, зорилт хэмжигдэхүйц байх;
10. Шалгуур үзүүлэлт нь зорилготой нийцэж байх.

2017 оны 3 дугаар сард НҮБ-ын Статистикийн комиссын 48-р чуулганаар ТХЗ-ын хэрэгжилтийг дүгнэх 244 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон ба ТХЗ-ын хэрэгжилтийг гаргахад албан ёсны статистик мэдээлэл, яамд, төрийн

бусад байгууллагуудын захиргааны мэдээлэл болон бусад мэдээллийн эх үүсвэрийг ашиглахаар заажээ. 2016 оны 2 дугаар сард УИХ-ын тогтоолоор Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 (ТХҮБ-2030)-ыг баталж, 3 үе шаттайгаар 15 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр заасан байв. Улмаар УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор 2020 оны 5 дугаар сарын 13-нд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг” баталснаар “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баримт бичгийг хүчингүй болсонд тооцсон. Чингэхдээ эл баримт бичигт дэвшүүлсэн зорилтууд шинээр баталсан “Алсын хараа-2050”-д тусгалаа олсон гэж үзжээ (Чулуунбаатар Г., Батсүх Ш., Ганцоож Б., 2021, хууд. 78). Үндсэн баримт бичигт дэвшүүлсэн зорилт бүрийн хэрэгжүүлэх хугацааг гурван үе шаттай байхаар тодорхойлсныг Д.Сүрэнчимэг тоймлон харуулсныг Зураг 2-оос харна уу.

## Зураг 2. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – Монгол Улсад



Эх сурвалж: Д.Сүрэнчимэг, 2020. Тогтвортой хөгжлийн боловсрол институтчилэл, түншлэл. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ-ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА” ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨГӨӨН дээр хэлэлцүүлсэн илтгэл.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явцад 5 жил тутам хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, Монгол Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосон. Мөн хяналт, шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг боловсруулах, 5 жил тутам үнэлгээ хийх, хэрэгжилтийг зохион байгуулах байнгын бүтэц, тогтолцоог бий болгох тухай УИХ-ын шийдвэрийн түвшинд баталгаажуулсан. Энэ утгаараа (Чулуунбаатар Г., Батсүх Ш., Ганцоож Б.,

2021, хууд. 78) дүгнэснээр “өмнөх шийдвэрүүдтэй харьцуулахад энэ удаагийн УИХ-ын шийдвэр нь зарим нэг онцлогтой” ба “урт хугацааны бодлогын хэрэгжилт бодитой үр дүнд хүрэх магадлалыг эрх зүйн хувьд илүү нэмэгдүүлсэн” гэж үзэж байна.

Өнгөрсөн хугацаанд төр, засгаас баталж хэрэгжүүлсэн урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн алинд нь ч гэсэн ардчилал, засаглалын хүрээ буюу нийгмийн улс төрийн харилцааг боловсронгуй болгох замаар улс орны хөгжлийг үр нөлөөтэй байх нөхцөлийг бүрдүүлэх тухай асуудал бие даасан бүлэг, бүрэлдэхүүн хэсгийн хэмжээнд томъёологдож, тодорхой зорилго, зорилтууд болон үйл ажиллагааг төлөвлөж ирсэн байна (Чулуунбаатар Г., Батсүх Ш., Ганцоож Б., 2021, хууд. 76). Эдгээр судлаачдын тэмдэглэснээр “манай улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд ямагт НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан байдалтай байгаа явдал мөн” (мөн тэнд).

Ингээд “Алсын хараа-2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт энэ судалгаанд тодорхой кейс болгон судлах Тогтвортой Хөгжлийн Зорилгын Зорилт 16-тай уялдах зорилтуудыг шинжилж үзэхэд дараах зорилтууд холбоотой тусгагдсан байна (Хавсралт 1-ийг харна уу).

Дэлхий дахинаа хэрэгжүүлэхээр зорьж буй ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилт нь манай улсын 2016 оноос хойш хийгдсэн 5 удаагийн үнэлгээний судалгаагаар Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ын 4 бүлэг, 44 зорилттой уялдаж байгааг тодорхойлсон байна (sdg.gov.mn, 2022). Мөн нийгэм, эдийн засаг, байгаль орчны эдгээр зорилтуудын хэрэгжилтийг дүгнэх 248 шалгуур үзүүлэлтээс<sup>5</sup> ҮСХ-ноос гаргасан нэгтгэлээр Монгол Улсад хамааралтай 16 зорилго, 159 зорилт, 234 үзүүлэлт байгаа ба хамааралгүй 13 шалгуур үзүүлэлт байгааг тодорхойлжээ. Дэлхий нийтээрээ хүрэхийг зорьж буй эдгээр 248 шалгуур үзүүлэлт нь дор дурдсан 17 чиглэлээр хэрэгжиж байна (Хүснэгт 3-аас үзнэ үү).

### Хүснэгт 3. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтийн тоо

Зорилго	Зорилгын нэр	Зорилт	Шалгуур Үзүүлэлт
1	Ядуурлыг устгах	7	14
2	Өлсгөлөнг зогсоох	8	13
3	Эрүүл мэндийг дэмжих	13	27
4	Чанартай боловсролыг дэмжих	10	11

5 2022 оны 6 сарын 9-ны байдлаар НҮБ-ын сайтанд байршуулсан шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтад өмнөх 11.5.2-т заасан шалгуур үзүүлэлтийг 11.5.2 болон 11.5.3 хэмээн хоёр шалгуур үзүүлэлт болгон задалснаас үүдэн нийт 248 шалгуур үзүүлэлт болсон.



5	Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах	9	14
6	Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах	8	11
7	Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх	5	6
8	Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох	12	17
9	Инновац болон дэд бүтцийн нэмэгдүүлэх	8	12
10	Тэгш бус байдлыг бууруулах	10	11
11	Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	10	15
12	Хариуцлагатай хэрэглээг дэмжих	11	14
13	Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах	5	8
14	Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах	10	10
15	Хуурай газрын эко системийг хамгаалах	12	14
16	Энх тайван, шударга ёсыг цогцлоох	12	23
17	Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх	19	25
Бүгд		<b>169</b>	<b>248</b>

Эх сурвалж: Мэдээллийг нэгтгэсэн судалгааны баг

Эдгээр ТХЗ-оос Монгол Улсад хамаарах 16 зорилгын тойм шинжилгээ хийх хэрэгцээ байгаа ба “Зорилго 16” буюу түүнд хамаарах 16.7.2 гэсэн шалгуур үзүүлэлт нь эл судалгааны төвлөрөх асуудал болж буйг өмнөх Удиртгал хэсэгт тодруулсан билээ. Тэгвэл “шалгуур үзүүлэлт” гэсэн ойлголт нь “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан тоон болон чанарын үзүүлэлт” хэмээн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.22-д тодорхойлжээ.

2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” батлахдаа тус тогтоолын 1-д “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусган үе шаттайгаар хэрэгжүүлэх;” хэмээсэн нь 2015 оны 11-р сард баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 6.2-т заасан 15-20 жилийн хугацаанд хэрэгжүүлэх Монгол Улсын урт хугацааны хамгийн том бодлогын баримт бичиг буюу Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал мөн гэдгийг тодорхойлж өгсөн. Ийнхүү хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон тогтвортой хөгжлийн үзэл баримтлал цаг хугацааны хувьд бараг давхцаж батлагдсан нь Монгол Улс нэг талаас олон улсын ТХЗ-ыг хэрэгжүүлэхийн тулд түүнийгээ давхар хуульчилж өгсөн хэмээн ойлгож болно. Түүгээр ч үл барам 2016 оноос хэрэгжиж эхэлсэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг дагаж 2016 оны 5 дугаар сарын 09-ний өдөр “Хөгжлийн бодлогын

баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ыг Засгийн газрын 249 дүгээр тогтоолоор баталсан байдаг. Энэхүү журам нь ТХЗ-ыг хэрэгжүүлэх дунд болон богино хугацааны бодлогуудыг хэрхэн боловсруулах, бодлогын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтийг хэрхэн тодорхойлох, шалгуур үзүүлэлтүүдийн шаардлагуудыг Үр дүнд суурилсан бодлого, менежментийн үзэл баримтлалд үндэслэн тогтоож өгсөн байдаг. Тухайлбал, тус журмын 58.5-д “*төсөлд шалгуур үзүүлэлтийн суурь түвшин, суурь он, зорилтот түвшин болон он, мэдээллийн эх сурвалжийг тодорхойлсон байх бөгөөд шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар илэрхийлнэ*” гэж заахдаа 58.5.1-д бодлогыг хэрэгжүүлсний **үр дүнд гарах өөрчлөлт** нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын зорилт, шалгуур үзүүлэлттэй уялдсан байна хэмээн тусгаснаар Монгол Улсын хэмжээнд батлагдан гарч байгаа аливаа бодлогын баримт туссан шалгуур үзүүлэлтэд тавигдах шаардлага олон улсын ТХЗ-ын шалгуур үзүүлэлтэд тавигдаж буй шаардлагад мөн адил нийцэх хэрэгтэйг давхар онцолж өгсөн боловч 2021 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн Засгийн газрын 119 дүгээр тогтоол уг журмыг шинэчлэн баталж, өөрчилсөн байдаг. Хэдийгээр бодлогын баримт бичиг боловсруулах журмын агуулгыг шинэчилсэн боловч 249 дүгээр тогтоолоор батлагдсан журамд туссан үзэл санааг ялангуяа шалгуур үзүүлэлт, түүний суурь түвшин, зорилтот түвшин гэх мэт ойлголтуудыг 2020 онд шинэчлэн найруулж баталсан Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулинд тусгаж оруулсан байдаг. Өөрөөр хэлбэл, өмнө нь журмын хэмжээнд үйлчилдэг байсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлттэй холбоотой ойлголтууд өнөөдөр хуулийн хэмжээнд үйлчилж, үйлчлэх хүч нь нэмэгдсэн гэж ойлгож болно.

Түүнээс гадна 2016 онд Олон улсын хөтөлбөрийн үр дүнг сайжруулах зорилгоор Канадын засгийн газраас Үр дүнд суурилсан удирдлагыг нэвтрүүлэх гарын авлага боловсруулсан байдаг. Тус гарын авлагад аливаа хөтөлбөрийн үр дүнг шалгуур үзүүлэлтээр дамжуулан хэмжихдээ хэд хэдэн зүйлийг анхаарах шаардлагатайг онцолсон нь Манай улсын 2016 оноос хойш хэрэгжсэн болон өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн үзэл санаатай нийцэхээс гадна зарим зүйлүүдийг тодотгож онцолсон байдаг. Тухайлбал, аливаа хөгжлийн бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагааг хэмжих шалгуур үзүүлэлтийг боловсруулахдаа

1. Төрөл /тоон болон чанарын шалгуур үзүүлэлт үү?
2. Суурь түвшин болон хугацаа
3. Зорилтот түвшин болон хугацаа
4. Мэдээллийн эх сурвалж /шалгуур үзүүлэлтийн тухай өгөгдлийг олж авах боломжтой хувь хүн, байгууллага эсвэл баримт бичиг/, түүний төрөл /анхдагч уу эсвэл хоёрдогч өгөгдөл үү?/
5. Мэдээлэл цуглуулах арга зүй
6. Мэдээллийн давтамж

7. Хариуцагч /шалгуур үзүүлэлтийн тухай өгөгдлийг цуглуулах үүрэг бүхий этгээд/<sup>6</sup> гэх мэт бүрэлдэхүүнийг заавал тодорхой байлгах тухай тусгасан байна (Global Affairs Canada, 2016, pp. 57-64).

Эдгээр тодорхойлолт нь тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтийн агуулгатай нийцэж байгаа бөгөөд бидний судалгааны үзэл баримтлалын суурь болох нарийвчлан хэлбэл, тус судалгааны чухал асуудал болох Монгол Улсад **“тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт”**-ийг хэмжих арга зүйд харьцуулсан тойм шинжилгээ хийхэд, тодорхой кейс буюу ТХЗ-16-гийн хүрээнд буй 16.7.2-ын шалгуур үзүүлэлтийг хэмжих арга зүйг тодорхойлж, суурь мэдээллийн судалгаа хийхэд чухал үүрэгтэй юм. Мөн судалгааны арга зүйн үүднээс дараах хэсгүүдэд хийгдэх судалгааны ойлголтын нарийвчлал буюу операционализацийн тодорхойлолтод гол түлхүүр нь болно.

## 2.2. “Шийдвэр гаргалт”-ыг Тогтвортой Хөгжлийн Зорилгын шалгуур үзүүлэлт 16.7.2-ын хүрээнд хэрхэн ойлгох тухайд

Тогтвортой Хөгжлийн Зорилгын шалгуур үзүүлэлт 16.7.2-т “Шийдвэр гаргалт нь хүртээмжтэй, хариуцлагатай байдагт итгэдэг хүн амын эзлэх хувь, хүйсээр, насны бүлгээр, хөгжлийн бэрхшээлтэй хүн амаар, хүн амын бүлгээр”<sup>7</sup> хэмжихээр заасан байдаг (sdg.gov.mn, 2022). Тэгвэл шийдвэр гаргалт гэдгийг энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэрхэн ойлгож болох вэ?

2017 онд SAGE-аас хэвлэн гаргасан “Улс төрийн зан төлөвийн тайлбар толь”-д (Elbanna, Said, 2017. Decision Making. The SAGE Encyclopedia of Political Behavior) шийдвэр гаргалтын тухай дараах байдлаар тайлбарласан байна. Тухайлбал, “Шийдвэр гаргалт гэдэг нь шийдвэр гаргагчид ямар нэг асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага байна гэж хүлээн зөвшөөрсөн тэр мөчөөс өрнөж эхлэхээс, түүнийг хэрхэн шийдэх гэж буй үйлдлээ зарлах хүртэл үргэлжлэх дараалсан үйл явдлыг нэгтгэсэн динамик болоод интерактив үйл явц юм. Эндээс харахад шийдвэр гаргах, шийдвэрийг гүйцэтгэх хоёр нь хамааралтай хэдий ч салангид өөр концепцууд юм. Шийдвэр гаргалтын үйл явц нь рационал, зөн мэдрэмж болон улс төрийн үйл явцад суурилдаг” гэжээ. Эл тодорхойлолтыг энгийн үгээр илэрхийлбэл шийдвэр гаргалт нь тулгарсан асуудлыг шийдэхэд чиглэсэн үйл явдлуудын өрнөл бүхий өөрчлөмтгий үйл явц гэж харагдаж байна.

Менежментийн шинжлэх ухааны нэр томъёоны тайлбар тольд (2020:67) Шийдвэр гаргалтыг “тухайн асуудлын шийдэлд хүрэхийн тулд судлах, төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, хянах үйл явцыг нэгтгэн урьдчилан бодож

6 Жич: Хариуцагч гэдгийг аливаа бодлого, хөтөлбөрт туссан үйл ажиллагааг хариуцаж хийх этгээдээс ялгаатай буюу мэдээлэл цуглуулах судалгаа хийх этгээд гэдгийг ойлгох хэрэгтэй.

7 Үндэсний Статистикийн Хорооны орчуулгаар. Цаашид энэ орчуулгыг хянан өөрчилсөн болно

боловсруулах үйл явц” гээд *шийдвэр* гэсэн ойлголтыг нь “Асуудлыг шийдэж болох боломжуудаас хийх сонголт” гэж тайлбарлажээ. Мөн Менежментийн (Цэнд Н, Батхүрэл Г, Шуурав Я, Пүрэвдагва Х, Цэцэгмаа Ц., 2013:361-374) сурах бичигт *шийдвэр* гэж “Хэрэгжүүлэх боломжтой хэд хэдэн хувилбаруудаас хийх сонголт юм” гээд харин *шийдвэр гаргалт* гэдэг нь “Асуудлыг шийдвэрлэх олон хувилбар дундаас аль оновчтойг нь сонгон авах үйл ажиллагааг шийдвэр гаргалт гэдэг” хэмээн тодорхойлсон байна.

Түүнчлэн *шийдвэр гаргах үйл явц* нь “Асуудлаа тодорхойлж, шийдэх хувилбаруудыг боловсруулах, үнэлэх, сонголт хийх, сонгосон хувилбараа хэрэгжүүлж, үр дүнг тооцох” (Цэнд Н, Батхүрэл Г, Шуурав Я, Пүрэвдагва Х, Цэцэгмаа Ц., 2013:366) гэсэн тодорхой үе шатуудтай байж болохыг доорх хүснэгтээс харна уу.

#### Хүснэгт 4. Шийдвэр гаргах үйл явцын үе шатууд

Үйл ажиллагаа	Үйл явц	Тодорхойлолт
<b>Асуудал шийдэх үйл ажиллагаа</b>	Асуудлыг тодорхойлох	Уг асуудал бий болсон шалтгааныг нь тодорхойлно гэсэн үг. Өөрөөр хэлбэл, уг асуудалд нөлөөлсөн хүчин зүйлийг тогтоож байгаа явдал юм.
	Асуудлыг шийдэх хувилбаруудыг боловсруулах	Уг шинжээч хүн асуудлыг тодорхойлох алхмын үр дүнд дүн шинжилгээ хийх төдийгүй өөрийн туршлага болон чадвар дээр үндэслэж уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар таамаглал дэвшүүлдэг. Энэ дэвшүүлж байгаа таамаглал нь асуудлыг шийдэх хувилбар гэж үздэг.
	Хувилбаруудыг үнэлэх	Хувилбаруудыг үнэлэхдээ тооны болон чанарын гэсэн хоёр хэмжүүрийг хэрэглэдэг. Шинжилгээний явцад түгээмэл байдаг бөгөөд тоон хэмжүүрээр хувилбарыг үнэлэх явдал түгээмэл байдаг бөгөөд тоон үзүүлэлт нь хэмжих төдийгүй ойлгоход хялбар байдаг.
	Хувилбаруудаас сонголт хийх	Сонголт хийх үйл ажиллагаа нь хувилбар бүрийн давуу болон сул талыг харьцуулан аль оновчтой гэсэн хувилбарыг сонгон авч байгаа хэрэг юм.
<b>Бодит үйл ажиллагаа</b>	Сонгосон хувилбараа хэрэгжүүлж, үр дүнг тооцох	Нэгэнт сонгосон хувилбар буюу асуудлын шийдийг хэрэгжүүлэх нь удирдлагын шийдвэр гаргалтын эцсийн алхам юм.

Эх сурвалж: Цэнд, Н. (2013). Менежмент сурах бичиг., Улаанбаатар

Харин бодлого боловсруулах үйл явцад иргэдийн оролцоо нь санал өгөх, бодлого гаргагчдад захидал, цахим мэдээ бичих, өөр хоорондоо бодлогын асуудлаар ярилцах зэргээс илүү өндөр түвшинд байх бололцоотой юм. (Жон Юл ли, Чад Андерсон. 2012:166). Учир нь заримдаа иргэдээс төрийн алдаа гэж үзсэн зүйл нь өөрсдийнхөө үйл ажиллагаанд нөлөөлөх зорилготой төрийн үйл ажиллагааны үр нөлөөг бууруулах, үйл ажиллагаанд ямар нэг хязгаарлалтгүй шахам байх гэсэн зохион байгуулалттай бүлгүүдийн нөлөөлөл байдаг гэж Жон Юл нар тайлбарлажээ. Тэдний үзсэнээр "Төрийн бодлогыг өөртөө үйлчлүүлэх гэсэн сонирхлын бүлгүүдээс сэргийлэх хамгийн сайн арга бол иргэд өөрсдөө оролцох явдал юм". Иймээс ч шийдвэр гаргах үйл явц нь ямар шийдвэр гаргах вэ гэдэгт төдийгүй эцсийн дүндээ нийгэмд үзүүлэх нөлөөлөл нь ямар байх вэ гэдгийг хүртэл тодорхойлоход чухал нөлөөтэй. "Ардчилсан оронд төрийн бодлого нь олон нийтийн таалалтай нийцсэн, иргэдийн хэрэгцээг хангахад чиглэж байдаг гэж үзэж болох юм" (мөн тэнд. 2012:167). Байерли, Кейфорд (Жон Юл ли, Чад Андерсон. 2012:168) нар олон нийтийг бодлогод оролцуулах таван зорилго байдаг гэж тодорхойлсон байна. Үүнд,

1. Олон нийтийн үнэлэмжийг шийдвэрт тусгах;
2. Эдгээр шийдвэрийн агуулгын чанарыг дээшлүүлэх (жишээ нь хувилбарыг санал болгох, бодлогын суурь болж буй төсөөллийн алдааг илрүүлэх гэх мэт);
3. Өрсөлдөгч янз бүрийн сонирхлуудын зөрчлийг шийдвэрлэх (өрсөлдөх бус хамтран ажиллах замаар шийдвэр гаргахын чухлыг илэрхийлэх замаар);
4. Байгууллага, түүний үйл ажиллагаанд итгэх илтгэлийг буй болгох (нийтийн асуудлыг шийдвэрлэх чадварыг нь дээшлүүлэх замаар);
5. Олон түмнийг сургах, мэдээлэл хүргэх (*асуудлын талаарх олон нийтийн ойлголтыг сайжруулах, боломжит шийдлийн талаар нэгдсэн санаа бодлыг бүрдүүлэх*) орж байна.

Дээрх менежментийн тодорхойлолтуудыг эхний улс төрийн зан төлөвтэй холбоотой тодорхойлолттой харьцуулж, шалгуур үзүүлэлт 16.7.2-ын хүрээнд авч үзэхэд *шийдвэр гаргалт бол ард олонд тулгарсан асуудлыг шийдэхийн тулд санаатай болон санамсаргүйгээр хүн амын бүлгүүд дунд зохион байгуулагдах олон үйл явдал, үйл ажиллагааг хянан шинжилж, иргэдээс шаардаж, илэрхийлж буй олон санал, сонголт, боломжуудыг судалж үзээд ард түмэнд хамгийн нийцтэй зөв хувилбарыг сонгож, албажуулан тусгах тухай ойлголт* гэж харагдаж байна. Харин *шийдвэр гаргалт* хэмээх ойлголт нь НҮБХХ-ийн Ослогийн баримт бичигт (UNDP Oslo Governance Centre, 2020) тайлбарласнаар шалгуур үзүүлэлт 16.7.2-т далд утгатайгаар шингэсэн ба *шийдвэр гаргалт* нь бүх төрлийн шийдвэр гаргалтын тухай ярьж байгаа биш зөвхөн олон түмний засаглалын хүрээнд **/public governance/** гарч буй шийдвэр гаргалтад хамаарна гэжээ.

“Шинэ загварын Паблик удирдлагын тухай гол санаа нь 2000-аад оны эхээр Джанет болон Роберт Денхардт нарын санал болгосноор Америкчуудыг иргэнийх нь хувьд засгийн газрын үйл ажиллагаанд болон удирдлагын үйл явцад идэвхтэй оролцох учиртай гэсэн байр сууринаас хандсан юм” хэмээн Я.Долгоржав (2021:34) онцолсон байдаг. Тэрээр цааш нь “иргэд олон түмний идэвх, оролцоонд тулгуурласан **Public Governance**-ийн концепц нь орчин үед / XXI зууны эхнээс/ хүмүүсийг эдийн засгийн энгийн нэгэн нэгж бус, удирдлагад идэвхтэй оролцогч гэж үзэж буй юм” (мөн тэнд) гээд **Public Governance** гэсэн ойлголтыг “ард олны засаглал” мөн олон түмний оролцоотой хэмээн Монгол хэлнээ буулгасан байна. Ийнхүү ард олны засаглалыг ойлгоходоо “улс төрийн шийдвэр гаргах үйл явц хийгээд улс, орон нутгийн хэмжээний төсөл, хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд төрийн байгууллагаас гадна иргэд, иргэний нийгмийн бололцоот бүх субъект, бүтцүүдийг оролцуулах явдал” гэж үзжээ (Долгоржав, 2021:36).

Иймээс олон нийтийн засаглалын ойлголттой ардчилал, ялангуяа *шууд ардчилал, иргэний оролцоо* гэсэн ойлголтууд нягт холбоотой. Стиглиц бичихдээ “улс төрийн дуу хоолойгоо хүргэх боломжууд, мөн улс төрийн тогтолцооны мэдрэмжтэй байх хувь хэмжээ нь ардчиллын төрх байдал, сонгуулийн эрх, чөлөөт хэвлэл мэдээлэл болоод иргэний нийгмийн байгууллагууд гэх мэт улс орон бүрийн институцийн шинж чанаруудаас хамаарна” (Stiglitz, Sen et al., 2009) гэжээ. Шууд ардчиллыг хоёр утгаар ойлгодог тухай Ш. Батсүх, Я. Долгоржав, Б. Ганцоож нарын “Шууд Ардчилал-Иргэдийн Оролцоо” судалгааны тайланд (2014:17) доорх тайлбарыг өгчээ. Үүнд:

**Шууд ардчилал** гэж - **нэгдүгээрт**, ард нийтийн санал асуулгад тулгуурлан эрх мэдлийг шууд ард түмэн хэрэгжүүлдэг нийгмийн зохион байгуулалтын хэлбэр, **хоёрдугаарт**, иргэдийн оролцоотойгоор шийдвэр гаргадаг улс төрийн арга ба энэ арга нь төлөөллийн ардчиллын тогтолцооны нэг хэсэг байж болдог. Энд иргэдийн оролцоо гэдгийг “улс төрийн шийдвэр гаргах үйл явц болон томоохон төсөл, хөтөлбөрүүдийг төлөвлөх явцад иргэдийг оролцуулахыг хэлдэг” (мөн тэнд). Батсүх Ш, Долгоржав Я, Ганцоож Б. (2014:33) нар иргэдийн жирийн оролцоог шийдвэр гаргаж оролцдог оролцооноос ялгаж авч үзсэн байна. Тус судлаачид цааш нь тайлбарлахдаа “Хэдийгээр манай улс төлөөллийн ардчилал бүхий орон гэгдэх боловч Үндсэн хуулиараа шууд ардчилалд өргөн боломж олгосон орны тоонд зүй ёсоор ордог.

Шууд ардчилал, иргэдийн оролцооны асуудал сүүлийн жилүүдэд ихээхэн яригдах болсон нь **нэгдүгээрт**, засаглалын үзэл баримтлалын хүрээнд оролцоог чухалчилдагтай, **хоёрдугаарт**, иргэдийн олонх улс төрийн нам болон улс төрчдийн гаргаж буй улс төрийн шийдвэрт сэтгэл хангалуун бус байдагтай, **гуравдугаарт**, иргэдийг төлөөлж бүх түвшинд мандат авсан улс төрчид ихэнх тохиолдолд иргэдийг бүрэн төлөөлж чадахгүй байна гэж үзэж буйтай холбоотой юм. Шууд ардчилал, иргэдийн оролцоо нь төлөөллийн ардчилалд

суурилсан өнөөгийн улс төрийн тогтолцоог халах буюу орлох гэхээсээ илүү түүний сул тал, дутагдлыг засаж залруулах зорилготой” хэмээжээ.

Монгол Улсад 2000 оны эхэн үеэс “Шууд Ардчилал-Иргэдийн Оролцоо”-г хөгжүүлэхэд анхаарч олон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжсэн байна. Тухайлбал, Глоб Интернэшнл, Нээлттэй Нийгэм Хүрээлэн, Мерси Кор Монгол Олон улсын байгууллага, Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн, Швейцарын Хөгжлийн Агентлаг болон НҮБХХ, Азийн Сан, Үндэсний Хөгжлийн Хүрээлэн, Удирдлагын Академи зэрэг олон байгууллага төсөл хэрэгжүүлж, үр дүнг хэвлэн нийтэлж, төрийн олон бодлого хэрэгжиж иржээ (дэлгэрэнгүйг Батсүх Ш., Долгоржав Я., Ганцоож Б., 2014:29-аас харна уу. Мөн Чулуунбаатар Г., Батсүх, Ш., Ганцоож, Б., 2021). Түүнчлэн Г.Чулуунбаатар, Я.Долгоржав, Ш.Батсүх, Б.Ганцоож, Я.Бямбажав, Ч.Тамир зэрэг олон судлаачид шууд ардчилал, иргэний оролцооны тухай судалгаа хийж, гарын авлага, бүтээл, зөвлөмжүүд гаргасан байна. Нэг үгээр хэлбэл, Монгол Улсад ардчиллын илэрхийлэл болох иргэн болон иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн оролцооны тухай хангалттай олон тодорхойлох судалгаа хийгдсэн байна. Иймээс нэгэнт Монгол хэлнээ **шууд ардчилал, иргэдийн оролцооны тухай материал хангалттай хуримтлагдсан тул бидний энэ судалгааны үндсэн асуудал нь шууд ардчилал, иргэдийн оролцоо, иргэдийн оролцооны хэлбэр, оролцуулж буй үйл ажиллагаа, оролцуулсан тухай, оролцуулах тухай эрхзүй, бодлого, түүний агуулга, судалгаанд төвлөрөөгүй.** Учир нь Монгол Улсад **иргэдийн оролцооны тухай онолын болон судалгааны материал хангалттай хуримтлагдсан**, ардчиллын илэрхийлэл болох иргэн болон иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн оролцооны тухай олон тодорхойлох судалгаа хийгдсэн байна. Иймээс судалгааны үндсэн асуудал болох **одоогийн тогтолцооны шийдвэр гаргалтын үр дүнг иргэдийн өөрсдийнх нь санаа бодлоор судлахад** оршиж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Тэгвэл эл бодлого, үйл ажиллагааны үр нөлөө иргэдийн санаа бодолд яаж тусч, тэдний итгэл үнэмшилд ямар өөрчлөлт гарч буйг ТХЗ-ын Зорилт 16-гийн хүрээнд шалгуур үзүүлэлт 16.7.2-оор хэмжиж болох тухай НҮБХХ-өөс 2017 оноос эхлэн судалж, олон улсад хийгдэж ирсэн судалгааны дүнгүүдэд суурилан тодорхой арга зүйн зөвлөмж гаргажээ. Тухайлбал, Европын нийгмийн судалгаа (European Social Survey, 2012-2013, 2016-2017), дэлхийн үнэт зүйлийн судалгаа (World Values Survey, 2012), Африкийн барометр (Afro-barometer, 2012-2013), Африк, Араб, Азийн (Afro, Arab, Asian & Latino, 2009) барометруудийг шинжлэн, гаргаж ирсэн хэмжээст асуултуудаар 2017 оноос хойш дэлхийн янз бүрийн орнуудад үе шаттайгаар доод тал нь 500 респонденттой туршилт судалгааг тухайн орнуудын Статистикийн хороотой хамтран хийсэн байна (Tier 3-016-07-02).

Ийнхүү ард олны засаглалыг илэрхийлэх гол үзүүлэлт нь гарч буй шийдвэрүүдийн үйл явц хэрхэн өрнөж ирсэн ба улмаар уг үйл явцын дүнд гарсан шийдвэрүүдэд олон түмний дуу хоолой тусгалаа олдог гэдгийг иргэд нь хэрхэн бодож явдаг буйн илрэл хэмээн үздэг байна.

НҮБХХ-ийн Ослогийн Засаглалын төвд шалгуур үзүүлэлт 16.7.2-оор санал өгсөн Оркины тайлбарласнаар (Orkin, M., 2017:3) *доош чиглэсэн*, мөн *дээш чиглэсэн* шийдвэр гаргалтын аль аль нь иргэд ба нийгмийн байгууллагууд хоорондын *хэвтээ чиглэлийн* шийдвэр гаргалтад нөлөөтэй байдаг. Хууль, дүрэм журам, бодлого хэлбэрээр хэрэгжиж буй дээрээс доош хүн амд чиглэсэн шийдвэр гаргалтууд нь “зарчим, үйл явц, үр дүн”-г ялгаж байгаа ба иргэдээс авч буй асуулгууд нь үр дүнг илэрхийлэх анхдагч эх сурвалж болдог ба зарчим, прогрессыг нь хэмжихүйц үзүүлэлт гэж ч үзэж болно. Иймээс ч ЭЗХАХОУБ нь иргэдийн улс төрийн үр нөлөөний талаарх мэдрэмж, иргэний оролцоо, төрийн үйлчилгээний сэтгэл ханамж, итгэл зэрэг асуудлуудыг иргэдээс асуухад төвлөрч байдаг юм. Тэрээр цааш нь “шалгуур үзүүлэлт 16.7.2 нь шийдвэр гаргагчид болон хүн амын хуваарилалт нь ойролцоо байх тусам тухайн орны гүйцэтгэл илүү байдаг гэж тайлбарлагдана” гэж үзсэн байна. Иймд Верб, Сидни, Норман нарын хэлснээр (Verba, Sidney and Norman Nie, 1972) “шийдвэр гаргахад хэдий чинээ цөөнх оролцоно төдий чинээ бага ардчилалтай; шийдвэр гаргахад хэдий чинээ олонх оролцоно төдий чинээ илүү ардчилал байна” гэж онцолжээ. Ийм учир шалтгааны улмаас 16.7.2-ыг засаглалын доош чиглэсэн шийдвэр гаргалтуудаас гадна сонгуулийн дээш чиглэсэн үйл явц, мөн иргэн-иргэний нийгмийн хэвтээ оролцоонд хамаарах Зорилго 16-гийн бусад зорилтуудтай холбож үзжээ.

Шийдвэр гаргалтыг дотор нь олон нийтийг тэгш оролцуулсан<sup>8</sup> ба иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй шийдвэр гаргалт<sup>9</sup> гэж хоёр ангилан үзнэ. Энэ хоёр төрлийн шийдвэр гаргалтын тухай ойлголтыг дараах байдлаар тодорхойлдог (SDG indicator Metadata, 2021). Үүнд:

**Нэгдүгээрт**, *олон нийтийг тэгш оролцуулсан шийдвэр гаргалт* гэдэг нь олон нийтэд үгээ хэлэх боломж олгох буюу тэд өөрсдийн шаардлага, үзэл бодол болон сонголтуудынхаа талаар *шийдвэр гаргагчдад дуу хоолойгоо хүргэх боломжоор хангагдаж буй* шийдвэр гаргалтын үйл явцыг хэлнэ.

**Хоёрдугаарт**, *иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй шийдвэр гаргалт* гэдэг нь улс төрчид болон улс төрийн институц хүмүүсийн шаардсан шаардлага, үзэл бодол болон *сонголтуудыг сонсож, үүний дагуу ямар нэг үйлдэл хийж буй шийдвэр гаргалтын үйл явцыг хэлнэ.*

8 Inclusive participation in decision-making -ҮСХ-ны орчуулгаар хүртээмжтэй шийдвэр гаргалт гэж байгаа гэхдээ цаашид дээр бичсэн “олон нийтийг тэгш оролцуулсан” гэсэн орчуулгаар явна -

9 Responsive decision-making -ҮСХ-ны орчуулгаар хариуцлагатай шийдвэр гаргалт гэж байгаа гэхдээ цаашид дээр бичсэн “иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй шийдвэр гаргалт” гэсэн орчуулгаар явна -



Эндээс харахад олон нийтэд хамаарах төр засгийн бүх түвшний шийдвэр гаргалтад иргэд ямар бодол, үнэмшилтэй байгааг хэмжих үзүүлэлт нь ТХЗ-16-р зорилгын 16.7.2-ын шалгуур үзүүлэлт бөгөөд энэ нь тогтвортой хөгжлийн бодлогын “бүх түвшинд хурдан шуурхай, бүх талын оролцоог хангасан, оролцооны аргад тулгуурласан, төлөөллийн шийдвэр гаргалт”<sup>10</sup> бүхий нийгмийг хэр зэрэг цогцлоож байгааг хянах нэг хэмжүүр болохыг тогтоожээ.

НҮБХХ-ийн Ослогийн Засаглалын баримтад (UNDP, Oslo Governance Centre, 2020) тайлбарласнаар **шалгуур үзүүлэлт 16.7.2-ын үндсэн концепц нь “гадаад үр дүн”<sup>11</sup>-г хэмжихэд чиглэгдэж** байгаа аж. “Гадаад үр дүн гэдэг нь олон түмний хэрэгцээ шаардлага, сонголтуудад хариу үйлдэл хийж буй улс төрийн тогтолцоо, тухайлбал, бодлого боловсруулах үйл явц болон төр засгийн шийдвэрүүдэд хувь хүний итгэж буй итгэл үнэмшил юм” (Lane 1959; Converse 1972; Balch 1974) хэмээн үздэг байна. Хүн амын дунд гадаад үр дүнг ямар байгааг хэмжих нь чухалд тооцогддог. Учир нь эл түвшинг тодорхойлсноор иргэд нь төр засгийн болон төрийн үйл ажиллагаанд итгэж буй эсэх нь харагдах болно (Finkel, 1985; Quintilier & Hooghe, 2012 in UNDP Oslo Governance Centre, 2020). Гадаад үр дүн хэдий чинээ сайн байна төдий чинээ иргэдийн улс төрийн оролцоо, тухайлбал сонгуулийн оролцоо, хүн ардын амьдралын сэтгэл ханамжийн түвшин өндөр байдаг (Flavin and Keane, 2011 in UNDP Oslo Governance Centre, 2020) болохыг судалгаагаар тогтоожээ.

Гадаад үр дүнг мөн “улс төрийн гадаад үр дүн”<sup>12</sup> гэж нэрлэдэг (UNDP, IAEG-SDG March 2019; OECD How’s Life? 2017: Measuring Well-Being –Chapter on Governance and Well-Being; UNDP Oslo Governance Centre, 2020). “Улс төрийн гадаад үр дүн” гэсэн ойлголтыг тодорхойлохдоо улс төрчид болон улс төрийн институциуд иргэдийн санаа бодлыг **хэр хэмжээнд сонсож, хариу үйлдэл хийж байгааг нь хүмүүсийн санаа бодлоор судалж гаргахыг хэлнэ** гэжээ (Aparna Basnyat, UNDP Oslo Governance Centre, 2020). “Улс төрийн үр дүн/нөлөө” гэсэн ойлголтыг хэмжих асуулгын асуултуудыг аль 1950-аад онд анх удаа АНУ-д шалгаж, баталгаажуулснаас хойш хэдэн арван жил ашигласаар байгаа аж (Tier 3-016-07-02). Камбел, Гүрин, Миллер (Campbell, Gurin and Miller 1954: 187 in Ann-Kristin Kölln, Peter Esaiasson, Sedef Turper, 2015) нар улс төрийн үр нөлөө гэдгийг анх 1954 онд тодорхойлохдоо “хувь хүний улс төрийн үйлдэл нь улс төрийн үйл явцад үр нөлөө үзүүлдэг, үзүүлж чадна гэсэн

10 ҮСХ-ны орчуулгаар

11 external efficacy/system responsiveness – англиар ч синоним /ижил утгатай үг/ утга бүхий хоёр өөр үгээр илэрхийлэгддэг энэ нэр томъёог гадаад үр дүн, экстернал үр дүн, системийн мэдрэмжтэй байдал, тогтолцооны хариу үйлдлийн чадвар гэсэн хэд хэдэн хэллэгээр орчуулдаг ч бүгд ижил утгатай үгс / синоним/ юм. Энэ судалгаанд цаашид гадаад үр дүн гэдэг нэр томъёогоор ашиглах болно

12 political efficacy – улс төрийн үр дүн. Улс төрийн үр дүн гэдэг нь дотроо улс төрийн дотоод үр дүн (internal political efficacy) ба улс төрийн гадаад үр дүн (external political efficacy) гэсэн 2 хэмжээстэй байдаг. ТХЗ-16.7.2 гэсэн шалгуур үзүүлэлт нь улс төрийн гадаад үр дүнг хэмждэг гэж үздэг ба товчоор гадаад үр дүн (external efficacy/system responsiveness) гэж нэрлэгддэг (Metadata-16-07-02.pdf, SDG indicator 16.7.2 - UN Statistics Division).


мэдрэмжийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, төрөөс зохион байгуулж буй үйл хэрэгт оролцож иргэний үүргээ гүйцэтгэх нь үр дүнд хүрдэг гэсэн хувь хүний тэрхүү мэдрэмж, сэтгэгдлийг хэлнэ. Энэ нь иргэн хүн хувь хүнийхээ хувьд улс төрийн болоод нийгмийн өөрчлөлтийг хийх боломжтой байдаг бөгөөд улс эх орондоо өөрчлөлт авчрахад хувь нэмэр би оруулж чадна гэсэн мэдрэмж юм” хэмээжээ.

Европт жил бүр хийгддэг Европын Нийгмийн Асуулга (European Social Survey) -д “улс төрийн үр дүн” гэсэн концепцыг асуулгынхаа үндсэн асуулт болгон ашигласаар (since ESS Round 8, 2016) иржээ. Мөн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн олон улсын байгууллага улс төрийн гадаад үр дүнг “төр засгийн явуулж буй зүйлд хувийн бодлоо хэлэх” гэдэг үзүүлэлтээр мониторинг хийсээр иржээ (OECD, How’s Life? 2017:Measuring Well-Being, p.182). Энд “үр дүн” гэсэн нэр томъёог бодлогын өнцгөөс тодорхойлбол “бодлогыг хэрэгжүүлснээр хүний хөгжил, нийгэм, байгаль орчин, эдийн засаг, засаглалын хүрээнд бий болох эерэг өөрчлөлтийг” (4.1.18) хэлнэ гэж Монгол Улсын “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуульд заажээ. Улс төрийн гадаад үр дүн нь дараах дөрвөн үзүүлэлтийг илэрхийлнэ. Үүнд:

1. Улс төрийн үр нөлөө
2. Нийгмийн үйл хэрэгт оролцох бүрэн эрхт төлөөлөл
3. Засаглалын тогтолцооны цэвэр эрүүл байдлыг бүхэлд нь хэмжих түлхүүр
4. Оролцоотой төлөөллийг илэрхийлэх 16.7.1-ийн шалгуур үзүүлэлтийг нөхөж өгөхөд мөн чухал үүрэгтэй гэж үздэг байна.

Дээрх ойлголтуудын онолын тодорхойлолтуудад суурилан иргэдийн оролцоотой гадаад үр дүнтэй шийдвэр гаргалтыг шалгуур үзүүлэлт 16.7.2-ын хүрээнд зураглан харуулбал (Зураг 3-аас үзнэ үү) дараах байдалтай харагдаж байна.

### **Зураг 3. Олон нийтийг тэгш оролцуулсан, тэдний саналыг тусгасан үр дүнтэй шийдвэр гаргалтын гадаад үр дүн**



Эх сурвалж: Судалгааны баг

Монгол Улсад "Ардчилсан засаглал судалгаа"-ны асуулгыг 2018 онд "Тогтвортой хөгжлийн зорилго"-ын шалгуур үзүүлэлтүүдээр баяжуулан шинэчилж, ҮСХ-ны даргын 2018 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн А/98 тоот тушаалаар батлуулан мэдээлэл цуглуулалтад ашиглаж байгаа (Ардчилсан засаглал судалгааны 2017-2020 оны үр дүн, 2021:3) аж. Энэ модуль асуулгад 16.7.2-той холбоотой нэг асуултыг иргэдээс асууж байгаа ба энэ тухай өмнөх "Удиртгал" хэсэгт тайлбарласнаас гадна тус дизайны судалгааны үзэл баримтлалын бүлэгт тусгайлан дурдах болно. Ардчилсан засаглал судалгаа нь Улсын Их Хурлын 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 13 дугаар тогтоолд **Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг хянах үзүүлэлт, арга зүйг боловсронгуй болгох, хэрэгжилтийг үзүүлэлт бүрээр дүгнэх, хяналт тавих, төрөлжсөн болон тусгайлсан мэдээллийн санг улсын хэмжээнд бий болгох зорилгоор** Засгийн газар, Үндэсний статистикийн хороо, Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, Хүний эрхийн үндэсний комисст тухайн үед үүрэг болгосон. Ийнхүү Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ноос тогтмол зохион байгуулдаг "Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа"-ны хавсралт (модуль) судалгаагаар цуглуулахаар ҮСХ-ны даргын 2008 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 10/100 тоот тушаалаар судалгааны үзэл баримтлалыг батлан хэрэгжүүлсээр иржээ.

**2.3. Судалгааны үзэл баримтлал: ТХЗ-ын Монгол Улсад тооцож байгаа шалгуур үзүүлэлтүүдийг хэмжих арга зүйд хийсэн харьцуулсан тойм шинжилгээнд хамаарах ойлголтууд, тодорхой кейс буюу "Шийдвэр гаргалт нь олон нийтийг тэгш оролцуулсан, иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй"<sup>13</sup>-г иргэдийн санаа бодлоор судлах ТХЗ- 16.7.2-ын шалгуур үзүүлэлтийн ойлголтын нарийвчилсан тодорхойлолт/операционализац**

Нэгэнт судалгааны асуудал, асуулт, зорилгын хүрээнд **нэгдүгээрт**, харьцуулсан тойм шинжилгээ хийх; **хоёрдугаарт**, **"тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт"**-ийн ангилалд багтах ТХЗ 16.7.2-ыг кейс болгон туршилтаар бүрэн судлах гэсэн судалгааны хоёр үндсэн чиглэл гарч ирсэн тул эдгээр нь тус тусдаа чиглэсэн үзэл баримтлалд суурилах нь ойлгомжтой билээ. Иймд доорх хэсэгт тэдгээрийг тус тусад нь авч хэлэлцсэн болно.


**2.3.1. ТХЗ-ын Монгол Улсад тооцож байгаа шалгуур үзүүлэлтүүдийг хэмжих аргачлалд хийсэн харьцуулсан тойм шинжилгээний үзэл баримтлал**

НҮБ-ын ТХЗ-ын нийт 248 шалгуур үзүүлэлтийн 136 шалгуур үзүүлэлт нь түвшин 1-д, 91 шалгуур үзүүлэлт нь түвшин 2-д, 1 шалгуур үзүүлэлтийн түвшин

13 Энэ хэсгээс эхлэн цаашид 16.7.2 үзүүлэлтийн ҮСХ-ны хүртээмжтэй/inclusive, хариуцлагатай/responsive гэсэн орчуулгыг утгыг нь бүрэн илэрхийлэх зорилгын үүднээс inclusive гэсэн үгийг олон нийтийг тэгш оролцуулсан, responsive гэсэн үгийг нь иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй шийдвэр гаргалт гэж монгол хэлнээ буулган цаашид хэрэглэнэ.

нь тодорхойгүй, 4 шалгуур үзүүлэлтийн дэд үзүүлэлтүүд нь өөр өөр түвшинд харьяалагдаж байна. Харин Монгол Улсын хувьд Үндэсний статистикийн хорооны зүгээс 133 шалгуур<sup>14</sup> нь тооцож байгаа ч **заримыг нь орлуулах, ойролцоо утга бүхий шалгуур үзүүлэлтээр хэмждэг, 102 шалгуур үзүүлэлт нь тооцох боломжгүй**, 13 үзүүлэлтийг Монгол Улсад хамааралгүй хэмээн тодорхойлсон. Эндээс олон улсын түвшинд концепц нь тодорхойлогдсон, арга зүй болон стандарт нь аль хэдийн батлагдсан ТХЗ боловч Монгол Улсад зарим шалгуур үзүүлэлтийн хэмжилтийн арга зүй нь олон улсынхаас ямар ойлголтын хувьд ялгаатай байна вэ? гэх асуултад зайлшгүй хариулахад харьцуулсан тойм шинжилгээ хийх хэрэгцээ гарч байна. Өөрөөр хэлбэл ТХЗ болон түүний шалгуур үзүүлэлтүүдийн эрэмбэ буюу логик бүтэц /уялдаа холбоо, хэлхээ/ хэмээх ойлголтоор дамжуулан ТХЗ-ыг амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлогыг тухайн улс орон бүр өөрийн онцлогт нийцүүлэн нутагшуулах боломжтой тухай НҮБ-ын ТХЗ-ын үзэл баримтлалд тусгасан тухай өмнө дурдсан билээ. Эл утгаараа Монгол Улс эхний ээлжинд тогтвортой хөгжлийн **16 зорилготой** холбоотой **133 шалгуур үзүүлэлтийг нэвтрүүлсэн нь** зарим шалгуур үзүүлэлтийн хувьд арга зүй нь олон улсын түвшинд батлагдсан концепц арга зүйгээс ялгаатай байж болох юм. Энэхүү ялгаатай байдал нь дэлхий нийтээрээ үр дүнд чиглэсэн бодлогоос Монгол Улс хэр зэрэг хазайж байгааг олж харах, нөгөөтэйгүүр бид юунаас болж ялгаатай байгаагаа тодотгох боломж бүрдэнэ. Үүнийг “Үр дүнд суурилсан менежмент” болон “Өөрчлөлтийн онолын үзэл баримтлалтай” уялдуулан авч үзвэл шалгуур үзүүлэлтийг олон улсад илүү үр дүнд чиглэсэн байхаар тодорхойлсон байхад Монгол Улсын хувьд өөрийн онцлогт нийцүүлэн нутагшуулах гэх нэрийн дор үр дүнд биш орц, гарцад чиглэсэн байдлаар шалгуур үзүүлэлтийн агуулгыг өөрчилсөн байж болох талтай гэсэн үзэл санаанд үндэслэсэн болно. Иймээс аливаа төсөл, хөтөлбөр, бодлогыг үр дүнд хүргэхийн тулд үр дүнгийн хэлхээ холбоо /**result's chain**/ буюу орцоос үр дүн хүрэх үе шатыг 6 түвшинд авч үздэг байна (Зураг 4-өөс харна уу).


#### Зураг 4. Үр дүнгийн хэлхээ холбоо буюу логик бүтэц



14 Хэдийгээр НҮБ-ын зүгээс 2022 оны 6 сарын 9-ны байдлаар өмнөх 11.5.2-т заасан шалгуур үзүүлэлтийг 11.5.2 болон 11.5.3 хэмээн хоёр шалгуур үзүүлэлт болгон задалж, 11.5.3-т заасан шалгуур үзүүлэлтийн түвшинг тодорхойлоогүй боловч Монгол Улсын хувьд уг үзүүлэлтийг эрх бүхий байгууллагаас 6 сарын 9-нөөс хойш тооцож байгаа эсэхийг тодорхой онцлоогүй учраас өмнөх 11.5.2-т заасан шалгуур үзүүлэлтийг тооцож байгаа гэсэн ангилалд нь хамааруулж тооцсон тул Монгол Улсын хувьд 133 шалгуур үзүүлэлтийг тооцож байгаа гэх ангилалд хамруулсан болно.

Энэхүү үр дүнд суурилсан удирдлагын гол үзэл баримтлал нь алсыг харж, зөвхөн үйл ажиллагааны явц болон гарцад төвлөрөх биш харин бодит үр дүн буюу урт хугацааны үр нөлөө, өөрчлөлтөд чиглэсэн бодлогод анхаарахыг чухалчилдаг. Ийнхүү удирдлага нь үр дүнд чиглэсэн шийдвэр гаргахын тулд мэдээлэл, нотолгоог цуглуулж, тэдгээрт суурилан нотолгоонд суурилсан шийдвэр гарах боломжтой болно гэсэн үг. Тиймээс ч нотолгоо нь үнэн зөв, алдаа мадаггүй байх шаардлагатай ба үүний тулд үр дүнд чиглэсэн мониторинг болон үнэлгээ чухал байдаг. Эцсийн эцэст үр дүнд суурилсан удирдлага нь урт хугацааны үр дүнд хүрч, хүн ардынхаа, тэр тусмаа ядуу болон эмзэг бүлгийн иргэдийн амьдралыг сайжруулахад л чиглэх тухай юм. Ийм ч учраас үр дүнд суурилсан удирдлагын энэ үзэл санааг НҮБ, ЭЗХАХОУБ болон төрийн болоод төрийн бус олон улсын олон байгууллага дэвшүүлэх болжээ. Энэхүү үр дүнгийн хэлхээ холбоог зарим бүтээлүүдэд логик загвар, логик бүтэц, логик уялдаа холбоо, үзэл баримтлалын хүрээ, төсөл хөтөлбөрийн логик гэх мэт олон янзаар томъёолсон байдаг (Global Affairs Canada, 2016, хууд. 22). Хэдий тийм боловч үр дүнгийн хэлхээ буюу логик бүтэц гэх энэхүү орцоос эцсийн үр дүн хүртэлх 6 түвшин нь ялангуяа урт хугацааны үр дүн нь аливаа төсөл, хөтөлбөр, бодлогын эцсийн гол үр дүн бөгөөд *"нэг буюу хэд хэдэн завсрын буюу дунд хугацааны үр дүнд хүрэх замаар бий болгож байгаа хамгийн дээд түвшний өөрчлөлт юм"* хэмээн тодорхойлсон нь агуулгаараа дунд хугацааны үр дүн нь урт хугацааны үр дүн рүү чиглэдэг буюу агуулгаараа багтдаг гэсэн утга санааг илэрхийлж байна. Үүний нэгэн адилаар дунд хугацааны үр дүн нь богино хугацааны үр дүнг агуулдаг, богино хугацааны үр дүн нь хэд хэдэн гарцын үр дүнд буй болдог гэсэн логик агуулга бүхий хоорондоо уялдаа холбоотой бүтцийн /загвар/ үзэл санааг илэрхийлж байна. Энэхүү үзэл санаа нь аливаа төсөл, хөтөлбөр, бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагааны /арга хэмжээ/ түвшинд хөрвөж бууж, зорилго, зорилт, үйл ажиллагаа хоорондын логик уялдаа холбоо буюу логик бүтцийг тодорхойлж өгдөг. Ингэснээр нэгдүгээрт, тухайн зорилго, зорилтыг хэмжиж буй шалгуур үзүүлэлтүүдийг үр дүнгийн хэлхээ холбоо буюу логик бүтцийн тусламжтайгаар тодорхойлох боломжтой. Хоёрдугаарт, шалгуур үзүүлэлтүүд хоорондын эрэмбэ буюу ач холбогдлын түвшинг тодорхойлох боломжтой. Гуравдугаарт, аливаа төсөл, хөтөлбөр, бодлогын зорилго, зорилт хоорондын логик уялдаа холбоонд үндэслэн гаргасан шалгуур үзүүлэлт хоорондын логик хэлхээ холбоог шалгуур үзүүлэлт хоорондын логик бүтэц (ШҮХЛБ) хэмээн нэрийдэж, ШҮХЛБ-ийн түвшинг дээд буюу эцсийн үр дүнг илэрхийлэх түвшин, дунд буюу завсарын үр дүнг илэрхийлэх түвшин, доод буюу эхний үр дүнг илэрхийлэх түвшин хэмээн 3 хувааж олон улсад авч үздэг байна (Зураг 5-аас ерөнхий бүтцийг харна уу).

## Зураг 5. Үр дүнгийн хэлхээ холбоо буюу логик бүтцийн пирамид хэлбэр



Эх сурвалж: [Global Affairs Canada, 2016, хууд. 22]

Үүнийг Монгол Улсад нутагшуулж байгаа олон улсын ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшинг тодорхойлон буулгаж үзвэл жишээлбэл, НҮБ-ын ТХЗ-ын “Ядуурлын бүх хэлбэрийг эцэс болгох”<sup>15</sup> гэсэн Зорилго 1-ийг “Өлсгөлөнг эцэс болгож, хүнсний аюулгүй байдлыг хангаж, хоол тэжээл байдлыг сайжруулж, тогтвортой хөдөө аж ахуйг хөхиүлэн дэмжих”<sup>16</sup> гэсэн ТХЗ Зорилго 2-той логик агуулгаар нь харьцуулж үзвэл ТХЗ Зорилго 2-ын үндсэн санаа нь ТХЗ Зорилго 1-д агуулагдаж байна. Өөрөөр хэлбэл өлсгөлөнг эцэс болгож, хүнсний аюулгүй байдлыг хангаж, хоол тэжээл байдлыг сайжруулсны **эцсийн үр дүнд ядуурлын бүх хэлбэр буурах, улмаар үгүй болох зорилго руу чиглэгдэж** байна. Элутгаар ТХЗ Зорилго 1-ийн шалгуур үзүүлэлтүүд нь Зорилго 2-той харьцуулахад дээд түвшний (урт хугацааны) үзүүлэлт гэж тодорхойлж байна. Гэхдээ энэ судалгаа нь ШҮХЛБ-ийг ашиглан үр дүнгийн агуулгаар нь ач холбогдлын түвшинг үнэлдэг олон улсын тус аргачлалыг ашиглахыг зориогүй бөгөөд энэ чиглэлээр хийгдэх дараа дараагийн судалгаанд ашиглах боломжтой гэж үзлээ.

Эл асуудалтай холбоотой шалгуур үзүүлэлтийн тухай, түүнийг хэрхэн хэмжих тухайгаа энэ хэсэгт тодорхойлсны эцэст бид **“тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт”** хэмээх ойлголтыг тус судалгаанд хэрхэн ойлгож, авч үзэж байгаагаа тайлбарлаж, цаашид энэ тодорхойлолтоо баримталсан болно.

Монгол Улсын Хөгжлийн бодлогын үзэл баримтлалын хүрээнд **шалгуур үзүүлэлтийн тухай ойлголтыг** “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт

<sup>15</sup> ҮСХ-ны орчуулснаар

<sup>16</sup> ҮСХ-ны орчуулснаар

бичгийн хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан **тоон болон чанарын үзүүлэлтийг**” хэлнэ хэмээн тодорхойлсон нь НҮБ-ын ТХЗ-ын хүрээнд гаргасан шалгуур үзүүлэлтийн үзэл баримтлалтай нийцэж байгаа хэдий ч “Үр дүнд суурилсан удирдлагын” хүрээнд шалгуур үзүүлэлт гэдэг нь дан ганц тухайн бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагааг хэмжих үзүүлэлтээс гадна гүйцэтгэлийг үр дүнд хүргэх зорилгоор ахиц дэвшлийг үнэлэх, мэдээлэл цуглуулах, шийдвэр гаргагч нарт үнэн зөв, найдвартай мэдээлэл өгөх менежментийн гол хэрэгсэл гэж үздэг. Эл утгаараа **шалгуур үзүүлэлт гэдэг нь** тухайн гүйцэтгэлийг хэмжих үзүүлэлтийн зөвхөн нэр төдий биш, харин шалгуур үзүүлэлтийн утга /**мэдээлэл буюу өгөгдөл**/, түүний эх сурвалж, давтамж, мэдээлэл цуглуулах арга, мэдээлэл цуглуулах этгээд гэх мэт ойлголтуудыг багтаасан өргөн хүрээтэй ойлголт юм. Улмаар үзүүлэлт бүрийн хувьд суурь болон зорилтот түвшин, хүрсэн түвшин гэх ойлголтуудтай салшгүй холбоотой хэмээжээ. Эдгээр ойлголтуудыг бүхэлд нь шалгуур үзүүлэлт хэмжих фрэймвөрк (framework) (Global Affairs Canada, 2016, p. 57) гэж тодорхойлохоос гадна **шалгуур үзүүлэлтийн утга нь баримт нотолгоонд суурилсан /evidence-based/** хүлээгдэж буй үр дүнг хэмжихэд чиглэсэн байх хэрэгтэй хэмээжээ (Global Affairs Canada, 2018, p. 5). Үүнийг мөн НҮБ ТХЗ-ын аргачлалыг тодорхойлсон баримт бичигтээ шалгуур үзүүлэлтийн мета өгөгдөл /SDG indicator metadata/ гээд олон улсад нийтлэг ашиглагдах боломжтойгоор аргачлалыг тодорхойлсон байна (UN, 2022). Иймээс бид энэхүү судалгаанд шалгуур үзүүлэлттэй холбоотой шалгуур үзүүлэлтийн утга, түүний эх сурвалж, давтамж, мэдээлэл цуглуулах арга, мэдээлэл цуглуулах этгээд гэх мэт ойлголтуудыг Монгол хэлнээ **“шалгуур үзүүлэлтийг хэмжих арга зүй”** хэмээн хөрвүүлж ашигласан болно.

Тиймээс шалгуур үзүүлэлт боловсруулна гэдэг нь дан ганц шалгуур үзүүлэлтийн нэрийг томъёолох тухай асуудал биш түүнийг хэмжих арга зүйг бүрэн тодорхойлох тухай асуудал юм. Иймээс энэ судалгаанд **“тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт”** гэдгийг хоёр өнцгөөс авч үзлээ. Үүнд:

*Нэгдүгээрт*, **“тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт”** гэдэг нь ТХЗ-2030-ын зорилтуудыг хянах шалгуур үзүүлэлт, түүнийг хэмжих нэгж, мэдээллийн эх сурвалж (үүсвэр), мэдээллээ цуглуулах арга зүй, мэдээлэл цуглуулах этгээд мэдээллийн давтамж, суурь болон зорилтот түвшин зэрэг хэмжилтийн арга зүйн ойлголтуудыг бүрэн биш тодорхойлсон, эсвэл тодорхойлоогүй дутуу орхигдуулсан байхыг ойлгоно.

*Хоёрдугаарт*, энэхүү судалгаанд Монгол Улсад ТХЗ-ыг тодорхойлсон шалгуур үзүүлэлтийг хэмжих арга зүй, аргачлал, бүрдэл хэсэг нь **НҮБ-ын тодорхойлсонтой харьцуулж үзэхэд ялгаатай байгаа тохиолдолд “тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт”** гэсэн ойлголтод хамааруулан **тооцсон** болно. Ингэж тодорхойлсноор, судалгааны үр дүнд үндэслэн тухайн

шалгуур үзүүлэлт хариуцсан байгууллага нь арга зүйг ялгаатай тооцох шаардлага үүсвэл түүний үндэслэлийг үнэхээр ул суурьтай гаргах, тухайлбал, Монгол Улсад ингэж тооцох боломжгүйг илтгэхүйцээр нарийн боловсруулах шаардлагатай болохыг ойлгоход тус дэм болно гэж үзлээ. Энэхүү үндэслэлийг дараах байдлаар дэлгэрэнгүй тайлбарлах нь зүйтэй болов уу.

НҮБ-аас ТХЗ-ын зорилт, түүний шалгуур үзүүлэлтийг батлахдаа заавал дагаж мөрдөх баримт бичиг бус харин тухайн улс орон өөрийн өвөрмөц онцлогт нийцүүлж, нутагшуулан хэрэглэх боломжтойг онцолсон байдаг. Улмаар НҮБ-ын зүгээс шалгуур үзүүлэлт бүрт хоёр жил тутам үнэлгээ хийхийн сацуу зарим шалгуур үзүүлэлтэд нэмэлт өөрчлөлт оруулах, нэмэх, хасах зэрэг зохицуулалтыг хийж, түүгээр ч үл барам тухайн шалгуур үзүүлэлтийг үндсэн концепц болгон нутагшуулахад анхаарах асуудлуудыг хүртэл боловсруулсан байна. Үүний үр дүнд НҮБ-ын зүгээс боловсруулсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн заримыг нь Монгол Улсад нутагшуулахдаа **агуулгын хувьд өөрчлөлт оруулах, ойролцоо утга бүхий шалгуур үзүүлэлтээр орлуулах, хүйс болон нийгмийн ямар нэгэн бүлгээр тодорхойлох боломжгүй боловч улсын хэмжээнд нэгдсэн дүнгээр тооцон гаргах** гэх мэт өөрчлөлтүүдийг хийсээр ирсэн байна. Тухайлбал ТХЗ-ын 11.2.1 “Нийтийн тээврээр саадгүй, тав тухтай зорчсон хүн амын эзлэх хувь (*Proportion of population that has convenient access to public transport, by sex, age and persons with disabilities*)” гэх үзүүлэлтийг хүйсээр, насаар, хөгжлийн бэрхшээлтэй хүн амаар гаргахаар НҮБ-ын ТХЗ-д тусгасан байхад Монгол Улсын хувьд уг үзүүлэлтийг нарийн тооцох боломжгүй, нөгөө талаар нийтийн тээврээр зорчиж байгаа иргэдийн хүйсийг ч ялгах боломжгүй байгаагаас үүдэн “Нийтийн тээврийн **тохиромжтой үйлчилгээнд** хамрагдсан хүн амын эзлэх хувь” гэж өөрчлөн, албан ёсны статистик мэдээ гаргахгүйгээр захиргааны байгууллагын зүгээс нийтийн тээврээр зорчиж байгаа иргэдийн тоо /*давхардсан тоогоор*/-оор орлуулан гаргасан байна. Энэ байдал нь НҮБ ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг 1-2 түвшинд ангилан авч үздэг байснаас Монгол Улсад ялгаатай авч үзэхэд хүргэж байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын ҮСХ-ноос ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг “**Тооцож байгаа**” болон “**Тооцох боломжгүй**” хэмээн ангилж 11.2.1 гэх шалгуур үзүүлэлтийг “Тооцож байгаа” ангилалд багтаасан байна. Энэ нь ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг нэг талаас НҮБ буюу Олон улсын түвшин 1, түвшин 2 гэсэн ангиллаар, нөгөө талаас Монгол Улсынх буюу “**Тооцож байгаа**” болон “**Тооцох боломжгүй**” гэсэн хоёр өөр өнцгөөс харах нөхцөл байдлыг үүсгэжээ.

Тиймээс ч бид судалгаандаа олон улсын болон Монгол Улсын түвшинд шалгуур үзүүлэлтийг хэмжих арга зүйн **хувьд ямар ялгаа байна вэ гэдгийг харьцуулж үзэх хэрэгцээ** гарч байна. Учир нь хэдийгээр Монгол Улс дэлхийн ТХЗ-ыг нутагшуулан, өөрийн орны онцлогт тохируулан тооцох нь нээлттэй ч, НҮБ-ын боловсруулсан мета өгөгдлийн арга зүйг манай нөхцөлд шууд



ашиглаж, тооцох боломж бүрэн байгаа тохиолдолд нь түүнийг нь баримталбал олон улсад харьцуулагдах нөхцөл бүрдэнэ гэж үзлээ.

Ингэж үзсэнд **хоёр үндэслэл** байна. **Нэгдүгээрт**, НҮБ бүх шалгуур үзүүлэлтийн арга зүйг боловсруулахдаа олон удаагийн судалгаа, туршилтыг хэд хэдэн орнуудад хийсний дараа нэвтрүүлдэг болохыг бид 16.7.2-ыг тооцсон байдлыг анх тандах явцдаа олж мэдсэн ба улмаар энэ шалгуур үзүүлэлтийн тооцоо нь нэлээд их ялгаатай байгааг олж харсан. **Хоёрдугаарт**, НҮБ-ын санал болгосон 2020 оны мета өгөгдлийн зөвлөмжөөр кейс ТХЗ 16.7.2-г тооцож гаргах бүрэн боломж байгаа ч энэ үзүүлэлтийг шинэчилсэн арга зүйгээр нь тооцоогүй, хуучин буюу 2018 оны манай өөрсдийн боловсруулсан арга зүйгээр тооцоор байгаа нь нийт шалгуур үзүүлэлтийн арга зүй, бүрдэл хэсгийг харьцуулан үзэх хэрэгцээ байгааг дахин илтгэсэн. **Харин Монгол Улсад үнэхээр хэрэгжүүлэх боломжгүй арга зүйг санал болгосон бол Монголд тохирох байдлаар нутагшуулах, онцлогтоо тааруулах боломж нь нээлттэй байдаг юм байна гэж үзэж байна.** Иймээс бид харьцуулсан тойм шинжилгээг хийх нь оновчтой судалгаа болно гэж үзсэн. Харьцуулсан шинжилгээ нь харьцуулж буй хоёр зүйлийн адил төсөөтэй ба ялгаатай шинж чанарыг илрүүлэх зорилготой хийгддэг ба ингэж харьцуулснаар бид ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг хэрхэн тооцож байгаагаа тодорхойлох, хэр үндэслэлтэйгээр өөрчилж тооцсон байна вэ гэдгээ танин мэдэх боломжийг бий болгож байгаа юм.

Нөгөө талаас, дээр дурдсанаар Монгол Улсад тооцох боломжгүй байгаа 102 шалгуур үзүүлэлтүүдийн гол шалтгааныг мэдээллийн эх үүсвэр нь байхгүйгээс үүдэн суурь зорилтот түвшин нь тодорхойлогдоогүй гэж ҮСХ дүгнэжээ.

Иймээс **нэгдүгээрт**, “Монгол Улсаас одоогийн байдлаар гаргах боломжгүй, мэдээллийн эх үүсвэр байхгүй тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалт”-д (sdg.gov.mn, 2022) буй 102 шалгуур үзүүлэлтийн мэдээллийн эх үүсвэр нь тодорхойгүй байгаа нь төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, зохион байгуулалттай холбоотой юу? эсвэл тухайн шалгуур үзүүлэлтийн хэмжилтийн арга зүйтэй холбоотой юу? гэдгийг тогтоох, **хоёрдугаарт**, Монгол Улсад тооцож байгаа 133 **шалгуур үзүүлэлтийн хэмжилтийн арга зүйд харьцуулсан тойм шинжилгээ хийхийн тулд**, мэдээллээ цуглуулах судалгааны арга зүйн байдлыг нь тодорхойлох зорилгоор өмнөх хэсгүүдэд тайлбарласан онолын тодорхойлолтуудад суурилан **ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг хэмжих арга зүй, аргачлалыг шалгах** шалгууруудыг боловсрууллаа. Тодорхой хэлбэл, эдгээр шалгууруудыг дараах баримтуудад суурилан боловсруулсан. Үүнд:

**Нэгдүгээрт**, 2016 онд “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-д сууриа олж, 2020 онд шинэчлэн найруулж баталсан “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулиар баталгаажсан шалгуур үзүүлэлттэй холбоотой ойлголтууд,

**Хоёрдугаарт**, 2016 онд олон улсын хөтөлбөрийн үр дүнг сайжруулах зорилгоор Канадын засгийн газраас “Үр дүнд суурилсан удирдлагыг” нэвтрүүлэх гарын авлагад тодорхойлсон “шалгуур үзүүлэлт боловсруулах онолын үзэл баримтлал”-д суурилан боловсруулсан. Ийнхүү ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг **хэмжих арга зүй, аргачлалыг нь харьцуулан шалгах 3 зүйл, 15 дэд үзүүлэлт тодорхойлов** (Хавсралт 2-оос харна уу).

### **2.3.2. Шийдвэр гаргалт нь олон нийтийг тэгш оролцуулсан, иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй<sup>17</sup> эсэхийг иргэдийн санаа бодлоор тодорхойлох ТХЗ- 16.7.2-ын шалгуур үзүүлэлтийн үзэл баримтлал**

**Удиртгал** хэсэгт дурдсанаар ТХЗ-ын **Зорилго 16**-ын хүрээнд гурван үндсэн шалгуур үзүүлэлт тодорхойлогдсон байв (sdg.1212.mn). Тэдгээр шалгуур үзүүлэлтүүд нь “Энхтайван, шударга ёсыг цогцлоох” агуулга бүхий Зорилго 16-д багтсан ба эл зорилго нь “Тогтвортой хөгжлийн төлөө аюулгүй, бүх талын оролцоог хангасан нийгмийг хөгжүүлж, хүн бүрийг хуулиар хамгаалуулах боломжоор хангах, бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, бүх талын оролцоог хангасан институтийг бий болгох”<sup>18</sup>-д оршино хэмээн заажээ. Зорилго 16 нь дотроо 12 зорилттой ба зорилт тус бүр нь дотроо 1-4 шалгуур үзүүлэлт бүхий нийт 23 шалгуур үзүүлэлттэй. Мөн Хүний эрхийн комисс, Шүүхийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Төрийн албаны зөвлөл, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Сангийн яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар зэрэг нийт 11 байгууллага тус бүртээ хамаарах зорилт, шалгуур үзүүлэлтээ хариуцан гаргаж, мэдээллээр хангах, судалгаа хийхээр төлөвлөсөн байна. Харин Зорилт 16.7 (Зураг 6-г харна уу) нь “Бүх түвшинд хурдан шуурхай, бүх талын оролцоог хангасан, оролцооны аргад тулгуурласан, төлөөллийн шийдвэр гаргадаг болгож”<sup>19</sup> хэрэгжүүлэхийг зорьж байгаа ба Зорилт 16.7-гийн хүрээнд дараах хоёр шалгуур үзүүлэлт тодорхойлогдоод байна (sdg.1212.mn). Үүнд:


1. 16.7.1 Үндэсний болон орон нутгийн хууль тогтоох байгууллага, төрийн алба, шүүхийн байгууллагад ажиллагчдын нийт төрийн албан ажиллагчдад эзлэх хувь (хүйс, насны бүлгээр, хөгжлийн бэрхшээлтэй хүн амаар, хүн амын бүлгээр)
2. 16.7.2. Шийдвэр гаргалт нь олон нийтийг тэгш оролцуулсан, иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй гэдэгт итгэдэг хүн амын эзлэх хувь, хүйсээр, насны бүлгээр, хөгжлийн бэрхшээлтэй хүн амаар, хүн амын бүлгээр судлан гаргахад оршино.

17 Энэ хэсгээс эхлэн цаашид 16.7.2 үзүүлэлтийн YCX-ны хүртээмжтэй/inclusive, хариуцлагатай/responsive гэсэн орчуулгыг утгыг нь бүрэн илэрхийлэх зорилгын үүднээс inclusive гэсэн үгийг олон нийтийг тэгш оролцуулсан, responsive гэсэн үгийг нь иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй шийдвэр гаргалт гэж монгол хэлнээ буулган цаашид хэрэглэнэ.

18 YCX-ны орчуулгаар

19 YCX-ны орчуулгаар

## Зураг 6. ТХЗ -ын Зорилт 16.7



Эх сурвалж: Судалгааны баг

Манай улсын хувьд ТХЗ-16-гийн Зорилт 16.7-д хүрэхийн тулд дээрх 2 үзүүлэлтийн хэрэгжилтийн талаарх мэдээллийн эх үүсвэрийг үүсгэж, уг мэдээлэлд суурилан суурь түвшин нь тодорхой болсноор хүрэх түвшингээ тодорхойлох боломжтой болно. Тэгвэл 16.7.1 нь мэдээллийн бэлэн байдалтай гэж үнэлэгдэж байгаа боловч 16.7.2 шалгуур үзүүлэлт нь **нэгдүгээрт**, мэдээллийн эх үүсвэр байхгүй, **хоёрдугаарт**, арга зүй, аргачлал мэдээлэл гаргах байдал нь бэлэн бус байдалтай байна гэж өмнө нь **Удиртгалын судалгааны асуудал** хэсэгт тайлбарласан билээ. Түүнчлэн уг шалгуур үзүүлэлт нь яг ямар концепцыг агуулж буйг тодорхой болгож, үүнийг судалгаа авч буй байгууллага нь мэдээлэл цуглуулагч судлаачдад ойлгуулахыг зөвлөсөн байна. Иймээс НҮБ-аас гаргасан шалгуур үзүүлэлт 16.7.2-ын концепц, арга зүйн зөвлөмжийг судлан, түүнд суурилан энэ үзүүлэлтийн судалгааг хийж, анхны мэдээллийг цуглуулах боломж бүрдэж байгаа тул эл шалгуур үзүүлэлт нь ЗГХЭГ-т хамаарч, ҮСХ-ноос тооцооллыг гаргах Удирдлагын академийн сургалт, судалгааны чиглэлд хамаарах асуудал гэж үзсэн тул **“тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт”** гэсэн ангилалд багтах 16.7.2” -ыг кейс болгож сонгон авч бүрэн судлахаар зорьсон юм.

ҮСХ-ноос тооцоолсноор ТАЗ-д, ЭЗХЯ-наас тооцоолсноор ЗГХЭГ-т хамаарч буй хоёр шалгуур үзүүлэлтийг дор дурдвал:

1. 16.7.1. Энэ нь Үндэсний болон орон нутгийн хууль тогтоох байгууллага, төрийн алба, шүүхийн байгууллагад ажиллагчдын нийт төрийн албан ажиллагчдад эзлэх хувиар (хүйс, насны бүлгээр, хөгжлийн бэрхшээлтэй хүн амаар, хүн амын бүлгээр), Хариуцах байгууллага - ТАЗ

2. 16.7.2. Шийдвэр гаргалт нь **хүртээмжтэй, хариуцлагатай байдаг** итгэдэг хүн амын эзлэх хувь, хүйсээр, насны бүлгээр, хөгжлийн бэрхшээлтэй хүн амаар, хүн амын бүлгээр (ҮСХ-ын орчуулгаар) гэсэн үзүүлэлтүүд багтаж байна. Хариуцах байгууллага – ТАЗ, ЗГХЭГ

Энэ хоёр шалгуур үзүүлэлтийг нэгтгэн харьцуулж үзэхэд, ҮСХ-ны **“Тогтвортой хөгжлийн зорилгын мэдээлж буй шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлал”**-д зааснаар хоёулаа **тооцож байгаа** гэсэн ангилалд хамаарч байна. Үзүүлэлт 16.7.1 нь ТАЗ-ийн захиргааны статистикийн мэдээнд суурилан ҮСХ нэгтгэхдээ төрийн албан хаагчийн судалгааг “Төрийн албаны тухай” хуульд заасан төрийн албаны ангилал, төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, хүйс, байгууллагын төрлөөр гаргаж ҮСХ-нд ирүүлдэг. Гэтэл төрийн албаны ажил мэргэжлийн ангилал: харьцуулагдах байдлыг хангахын тулд улс орнууд ажил мэргэжлийн ангилалтай уялдуулсан төрийн албаны ангиллыг ашигладаг ба **олон улсын ажил мэргэжлийн стандарт ангилал (ISCO-08)-ыг ашиглан** ихэнх улс орнууд төрийн албаны ажил мэргэжлийг үндсэн 4 төрөлд хуваадаг. Үүнд: менежер (Засгийн газраас томилогддоггүй төрийн албаны удирдах албан тушаалтнууд), мэргэжилтэн (бодлого боловсруулах, дүн шинжилгээ хийх, аудит хийх, санхүүгийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх г.м), гүйцэтгэх ажилтан (хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажил эрхэлдэг, нягтлан бодогч/хүний нөөц г.м), бичиг хэрэг/захиргааны ажилтнууд гэнэ. Иймээс Монгол Улс төрийн албан хаагчийн тоог олон улсын ISCO-08 ангиллаар бус хуульд заасан ангиллаар гаргаж байгаа тул энэ үзүүлэлтийг олон улсын аргачлалын дагуу тооцох боломжгүй, мөн насны ангиллын хувьд өөр ангилал ашиглаж байгаа нь Монгол Улсад нутагшуулахад онцлогоо тусгасан байдал гэж үзэж байна.

Харин 16.7.2-ын хувьд, “Бүх түвшинд хурдан шуурхай, бүх талын оролцоог хангасан, оролцооны аргад тулгуурласан, төлөөллийн шийдвэр гаргадаг болгох” гэсэн Зорилт 16.7-гийн хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийн үндсэн концепц нь гадаад үр дүнг хэмжихэд чиглэж байгаа билээ. Кларк нар гадаад үр дүнг “улс төрийн элитүүд болон төрийн институцийнхэн иргэдийн хүсэлт, шаардлагыг сонсож, хариу үйлдэл хийдэг гэдэгт итгэх үнэмшил юм” хэмээн концептуализаци хийсэн байдаг. (Clarke and others, 2010: 107 in Ann-Kristin Kölln, Peter Esaiasson, Sedef Turper, 2015). Мөн Монгол Улсын “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуульд заасан “... *засаглалын хүрээнд бий болох эерэг өөрчлөлт*” (4.1.18)-ийн үр дүнг харах нэг боломж нь “гадаад үр дүн”-г судлах явдал юм. Иймээс ч НҮБ-ын баримтад (UNDP, Oslo

Governance Centre, 2020) тайлбарласнаар ТХЗ-2030-ын **16.7.2 гэдэг шалгуур үзүүлэлтийн үндсэн концепц нь “гадаад үр дүн”-г<sup>20</sup> хэмжихэд чиглэгдэнэ** гэж үздэг байна.

“Гадаад үр дүн”-г *шийдвэр гаргалтад олон нийтийг тэгш оролцуулсан, иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй шийдвэр гаргалт* гэсэн хоёр хэмжээсээр хэмжихээр олон улсын түвшинд стандартдаа заажээ. Энэ нь *гадаад үр дүн* ямар түвшинд байгааг харах боломжийг өгнө гэж судалгаагаар тогтоожээ. Өөрөөр хэлбэл, улс төрчид болон улс төрийн институциуд жирийн иргэдийн санаа бодлыг хэр хэмжээнд сонсож, хариу үйлдэл хийж байгааг нь хүмүүсийн итгэл үнэмшил илэрхийлнэ (Aparna Basnyat, UNDP Oslo Governance Centre, 2020). Эндээс харахад гадаад үр дүнг хэмжих зорилго бүхий шалгуур үзүүлэлт 16.7.2 нь улс төрчид болон улс төрийн институциуд шийдвэр гаргахдаа **нэгдүгээрт**, иргэдийг тэгш хамруулан оролцуулж байгаа гэдэгт, **хоёрдугаарт** иргэдийн санал бодол, дуу хоолой шийдвэр гаргахад тусгагддаг гэдэгт иргэд өөрсдөө хэр их итгэл үнэмшилтэй байгааг хэмжих үзүүлэлт юм. Энэ хоёр үзүүлэлтийг НҮБХХ-ийн Осло дахь Засаглалын төв (Tier 3-016-07-02) нь 2017 оноос хойш судалж, туршиж, найдвартай болон оновчтой байдлыг нь тогтоож, хоёр үндсэн асуултаар хэмжихээр тогтсон байна. Иймд судалгааны үзэл баримтлалын гол суурь нь НҮБ-аас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилгын онолын үзэл баримтлал, ойлголтын тодорхойлолтуудыг **“тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт”**-ээс кейс болгож сонгож авсан 16.7.2”-ыг судлахад зориулагдсан доорх хүснэгтэд тайлбарлан харууллаа (Хүснэгт 5-аас харна уу).

20 external efficacy/system responsiveness – англиар ч синоним /ижил утгатай үг/ утга бүхий хоёр өөр үгээр илэрхийлэгддэг энэ нэр томъёог гадаад үр дүн, гадаад үр дүн, системийн мэдрэмжтэй байдал, тогтолцооны хариу үйлдлийн чадвар гэсэн хэд хэдэн хэллэгээр орчуулдаг ч бүгд ижил утгатай үгс /синоним/ юм. Энэ судалгаанд цаашид гадаад үр дүн гэдэг нэр томъёогоор ашиглах болно.

## Хүснэгт 5. ТХЗ-ын Шалгуур үзүүлэлт 16.7.2-ын “Гадаад үр дүн” үндсэн ойлголтыг хэмжих операциялизац

Хэмжих ойлголт, түүний тодорхойлолт	Хэмжээс	Хэмжих асуулт
<p>Гадаад үр дүн (<i>External efficacy/System responsiveness</i>)</p> <p>Гадаад үр дүн гэдэг нь олон түмний хэрэгцээ шаардлага, сонголтуудад хариу үйлдэл хийж буй төрийн тогтолцоо, тухайлбал бодлого боловсруулах үйл явц болон төр засгийн шийдвэрүүдэд хувь хүний итгэж буй итгэл үнэмшил юм” (Lane 1959; Converse 1972; Balch 1974)</p>	<p><b>1. Олон нийтийг тэгш оролцуулсан шийдвэр гаргалт</b> (<i>Inclusive participation in decision-making</i>)</p> <p>/Олон нийтэд үгээ хэлэх боломж олгох буюу тэд өөрсдийн шаардлага, санаа бодол болон/эсвэл сонголтуудынхаа талаар шийдвэр гаргагчдад <b>дуу хоолойгоо хүргэх боломжоор хангагдсан</b> шийдвэр гаргалтын үйл явцыг хэлнэ./</p>	<p>1. Манай төр засаг<sup>21</sup> иргэдийнхээ санаа бодлыг анхааран сонсох боломжийг хэр зэрэг бүрдүүлсэн гэж Та бодож байна вэ? (<i>How much would you say the political system in [country X] allows people like you to have a say in what the government does?</i>)</p>
	<p><b>2. Иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй шийдвэр гаргалт</b> (<i>Responsive decision-making</i>)</p> <p>/Улс төрчид болон/эсвэл төрийн институцийнхэн нь хүмүүсийн шаардсан шаардлага, санаа бодол болон/эсвэл сонголтуудыг <b>сонсож, үүний дагуу ямар нэг үйлдэл хийсэн</b> шийдвэр гаргалтын үйл явцыг хэлнэ./</p>	<p>2. Манай төр засгийн шийдвэрт<sup>22</sup> иргэдийн санаа бодол хэр зэрэг нөлөөлдөг гэж Та бодож байна вэ? (<i>And how much would you say that the political system in [country] allows people like you to have an influence on politics?</i>)</p>

21 “Х” Улсын улс төрийн тогтолцоо тань шиг хүмүүст төрийн үйл ажиллагаанд үгээ хэлж оролцох боломж хэр их олгодог гэж та үзэж байна вэ? гэсэн шууд утгаар орчуулагдахаар байгаа. Гэхдээ НҮБ-ын зөвлөмжөөр жирийн иргэний ярианы хэлээр орчуулгыг буулгахыг зөвлөсөн байдаг тул ШУА-ийн ФЭЗХ-ийн Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт, 2006 он болон Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт 2007-2008, 2009-2010 он зэрэг бүтээлийн дагуу “төр засаг” гэж гэсэн тогтсон хэллэгээр ашиглаж байсныг жирийн иргэдэд илүү ойлгомжтой гэж үзэн, мөн үндсэн концепц болох шийдвэр гаргалтын гадаад үр дүн гэдэг утгад нийцүүлэн судалгаанд ашиглахаар буулгасан.

22 “Х” Улсын улс төрийн тогтолцоо тань шиг хүмүүст улс төрд нөлөөлөх боломж хэр их олгодог гэж та үзэж байна вэ? гэсэн шууд утгаар орчуулагдахаар байгаа. Гэхдээ НҮБ-ын зөвлөмжөөр жирийн иргэний ярианы хэлээр орчуулгыг буулгахыг зөвлөсөн байдаг тул ШУА-ийн ФЭЗХ-ийн Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт, 2006 он болон Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт 2007-2008, 2009-2010 он зэрэг бүтээлийн дагуу “төр засаг” гэж гэсэн тогтсон хэллэгээр ашиглаж байсныг жирийн иргэдэд илүү ойлгомжтой гэж үзэн, мөн үндсэн концепц болох шийдвэр гаргалтын гадаад үр дүн гэдэг утгад нийцүүлэн судалгаанд ашиглахаар буулгасан.

# ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

## 3.1. Судалгааны дизайн: үндэслэл, судалгааны арга

“Урт хугацааны хөгжлийн бодлого, Тогтвортой хөгжлийн зорилго-2030-ын хэрэгжилтийг хянах, шалгуур үзүүлэлтийн судалгаа: дутуу байгаа шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах” судалгаа нь Удиртгал хэсэгт томъёолсон гурван үндсэн асуултад хариулт авах зорилготой байлаа.

Эхний **хоёр асуултын хүрээнд чанарын судалгаа хийж**, дутуу шалгуур үзүүлэлтүүдийг хэмжих арга зүй, аргачлалд харьцуулсан тойм шинжилгээ хийж, мөн шалтгааныг тодруулах зорилгоор шалгуур үзүүлэлт нь гараагүй байгаа үзүүлэлтүүд хамаарч буй төрийн байгууллагын 20 хүнтэй сурвалжилгын аргаар мэдээлэл цуглуулсан.

**Нэгдүгээр асуултын** хүрээнд дутуу байгаа шалгуур үзүүлэлтийн хувьд **хэмжилтийн арга зүй, аргачлалыг нь шалгах 3-н зүйл, 15 дэд үзүүлэлт тодорхойлон** (дэлгэрэнгүй хүснэгтийг Хавсралт 2-оос харна уу), ТХЗ-ын Монгол Улсад **тооцож байгаа 133 шалгуур үзүүлэлтүүдийг хэмжих арга зүй, аргачлалд** харьцуулсан тойм шинжилгээ хийсэн. Харьцуулах шинжилгээний арга нь адил төсөөтэй болон ялгаатай шинжийг илрүүлэхэд оршдог. Иймд 1.Монгол Улсын Хөгжлийн бодлогын үзэл баримтлал 2. Үр дүнд суурилсан удирдлагыг шалгуур үзүүлэлтийн бүрдэл хэсгийн арга зүйг ашиглан, харьцуулах үзүүлэлтүүдийг боловсруулсан товчийг доорх Хүснэгт 6-аас харна уу.

### Хүснэгт 6. Шалгуур үзүүлэлтийг хэмжих арга зүйг үнэлэх үзүүлэлт

Үндсэн дугаар	Зүйл	Дэд дугаар	ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн бүрэлдэхүүнийг хэмжих үзүүлэлт
1	Шалгуур үзүүлэлтийн нийцэл	1	Шалгуур үзүүлэлтийн “Алсын хараа-2050” бодлогын зорилготой логик уялдаа /шууд/ холбоотой эсэх
		2	Шалгуур үзүүлэлтийн төрөл
		3	ШҮ-ийн нэрний орчуулгын нийцтэй байдал
2	Мэдээлэл цуглуулах аргачлал	4	НҮБ болон Монгол Улсын ШҮ-ийг тооцох арга зүйн зөрүүтэй байдал
		5	Өгөгдөл цуглуулах арга
		6	Түүвэр бүрдүүлэх эсэх
		7	Түүврийн зөрүүтэй байдал
		8	НҮБ-ын аргачлалаар мэдээлэл цуглуулах давтамж
		9	Монгол Улсын аргачлалаар мэдээлэл цуглуулах давтамж
		10	Мэдээлэл цуглуулах этгээдийн шинж
3	Шалгуур үзүүлэлтийн өгөгдөл / утга	11	Мэдээллийн эх сурвалжийн зөрүүтэй байдал
		12	ШҮ-ийн утгыг 2016-2020 онд тооцсон байдал
		13	ШҮ нь дэд үзүүлэлттэй эсэх
		14	Дэд ШҮ-ийн утгыг 2016-2020 онд тооцсон байдал
		15	Тайлбар

Эх сурвалж: Судалгааны баг

**Хоёрдугаар асуултын хүрээнд,** ТХЗ-ын Монгол Улсад тооцоогүй байгаа 102 шалгуур үзүүлэлтүүдийн шалтгааныг тодруулахаар бүтэцлэгдсэн Сурвалжилгын төлөвлөгөө боловсруулсныг доорх Хүснэгт 7-оос харна уу. Уг сурвалжилгын төлөвлөгөөг боловсруулахын тулд 2020 онд ҮСХ-ноос Монгол Улсад тооцоогүй байгаа 102 шалгуур үзүүлэлтүүдэд хийсэн үнэлгээнд суурилан, мөн төсөл хэлбэрээр байгаа ЭЗХЯ-наас гаргасан 4 шалгуур (1-мэдээлэл бэлэн, 2-бэлэн байгаа мэдээлэлд нэмэлт тооцоолол хийж гаргах, 3-гарах боломжтой боловч үзүүлэлтийг нарийвчлан задлах үүднээс мэдээллийн эх үүсвэрийг бий болгох, 4-мэдээллийн эх үүсвэрийг шинээр бий болгох)-аас 3, 4-р шалгуурт хамаарч буй үзүүлэлтүүдийг түүвэрлэн авч, сурвалжлах хүмүүстэйгээ эдгээр тооцохгүй байгаа шалгуур үзүүлэлтүүдийн талаар ямар ойлголттой байгаа, яагаад гарах боломжгүй гэж бодож байгааг нь асууж тодруулах суурь мэдээллийг нэгтгэж боловсруулсан /Хүснэгт 7 -оос харна уу/.

### Хүснэгт 7. Сурвалжилгын төлөвлөгөө боловсруулахад туслах суурь мэдээлэл

UNSD Indicator Code <sup>a</sup>	ШҮ-ийн МОНГОЛ УЛС дахь төлөв байдал	Шалгуур үзүүлэлт	Үзүүлэлтийг хариуцан гаргах /ҮСХ/	ҮСХ-ноос гаргасан шалтгаан	ЭЗХЯ-наас гаргасан шалтгаан /төсөл/	Сурвалжилгын аргаар илэрсэн шалтгаан
----------------------------------	-------------------------------------	------------------	-----------------------------------	----------------------------	-------------------------------------	--------------------------------------

Эх сурвалж: судалгааны баг



## Хүснэгт 8. Сурвалжилгын төлөвлөгөө

Асуух сэдвийн чиглэл	ТХЗ/SDG хариуцсан ажилтан, албан тушаалтан
<p><b>1.Тухайн байгууллага дахь Тогтвортой Хөгжлийн Зорилго хариуцсан хүний нөөцийн тухай</b></p>	<p>1. Танай байгууллагад НҮБ-аас дэвшүүлсэн дэлхий нийтээр болон Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогоор хүрэхээр зорьж буй ТХЗ-2030-ыг танаас өөр ямар хэлтэс, албан тушаалтан хариуцдаг вэ, энэ талаараа ярина уу.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тодруулах асуулт /Probes &amp; prompts/: <ul style="list-style-type: none"> <li>• Яг ямар үүрэг?</li> </ul> </li> </ul>
<p><b>2. Тогтвортой Хөгжлийн Зорилго-2030 ба тухайн байгууллагын хариуцсан шалгуур үзүүлэлт</b></p>	<p>2. ТХЗ-2030-ыг танай байгууллагын удирдлага хэр зэрэг чухалчлан үздэг вэ?</p> <p>3. Танай байгууллага ТХЗ-ын ямар зорилт, шалгуур үзүүлэлтийг бодлогын түвшинд болон уг шалгуур үзүүлэлтийг хариуцан тооцож гаргах ёстой вэ? Энэ талаар ямар мэдээлэл танд байна вэ?</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тодруулах асуултууд (probes &amp; prompts): /хэрэв мэдэхгүй бол яагаад мэдээгүй байж болох тухай асуух/</li> </ul> <p>4. Танай байгууллага ҮСХ-ноос гаргасан мэдээлэлд ТХЗ-ын .... зорилтын шалгуур үзүүлэлт .....-ийг хариуцаж байгаа юм байна? Энэ тухай хэн нэгнээс, аль нэг газраас сонсож байсан уу?</p>
<p><b>3. Хариуцсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг тооцоход тулгарч буй хүндрэл</b></p>	<p>5. Ямар шалтгааны улмаас танай байгууллага хариуцсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг тооцож тодорхойлдоггүй гэж та бодож байна вэ?</p> <p>6. Уг шалгуур үзүүлэлтийг тодорхойлох гэхээр ямар хүндрэл, бэрхшээл учирч байна?</p> <ul style="list-style-type: none"> <li>- удирдлага, зохион байгуулалтын асуудал уу /хариуцсан ажилтан нь хийхгүй байгаагаас уу, эсвэл хэрэгтэй биш гэж үздэгээс үү гэх мэт/?</li> <li>- судалгааг нь тооцож гаргах арга зүй, аргачлалын ойлголт дутмаг байна уу?</li> <li>- мета өгөгдөл зөвлөмжийг хаанаас олохоо мэдэхгүй байна уу?</li> <li>- өөр ямар хүндрэл, шалтгаан байгааг ярина уу.</li> </ul> <p>7. ҮСХ, ЭЗХЯ-наас танай хороонд дээрх шалгуур үзүүлэлтийг тооцох тухай НҮБ-ын арга зүйн зөвлөмж болон тэдгээрийг тогтмол тооцох тухай албан бичиг, эсвэл ямар нэг чиглэл өгсөн, эсвэл албан бичгээр хүсэлт ирж байсан тохиолдол хэр олон байдаг вэ?</p> <p>8. Таны бодлоор танай байгууллага эдгээр шалгуур үзүүлэлтийг тооцохгүй байгаа нь ямар шалтгаантай байдаг юм бол? Танай байгууллагаас шалтгаалсан ямар нэг асуудал байдаг уу, байдаг бол ямар асуудал байна вэ?</p>

<p><b>4. Хариуцсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг тооцон гаргах боломжийн тухайд</b></p>	<p>9. Ер нь танай байгууллагын хариуцсан шалгуур үзүүлэлтийг тооцон гаргах боломж хэр зэрэг байгаа гэж та үзэж байна вэ?</p> <p>10. Үндэсний хөгжлийн газар, одоогийн Эдийн засгийн хөгжлийн яам болон Засгийн газар, ЗГХЭГ-аас энэ шалгуур үзүүлэлтийг гаргахад хамтран ажиллах санал тавьж байсан тохиолдол бий юу?</p> <p>11. Эсвэл энэ шалгуур үзүүлэлтийн тооцоог гаргах хэрэгтэй гэж дээрх байгууллагууд шахаж шаардаж байсан тохиолдол бий юу?</p>
<p><b>5. Хариуцсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг тооцох, тодорхойлохын тулд удирдлага, зохион байгуулалт хийж буй байдал</b></p>	<p>- Тодруулах асуултууд: /Хэрэв тооцож байгаа бол мета өгөгдөл дэх зөвлөмжийг яг дагаж хийж байгаа эсэх, эсвэл өөрчилж, орлуулж байгаа эсэхийг асуух/</p> <p>12. Танай байгууллага хариуцсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг хэрхэн, ямар аргаар тодорхойлж болох тухай судалж үзсэн үү?</p> <p>13. Уг шалгуур үзүүлэлтүүдийг тооцох НҮБ-ын мета өгөгдөл арга зүйн зөвлөмжтэй танилцсан уу? Тэр зөвлөмжийг дагаж хийдэг үү?</p>

*Эх сурвалж: Судалгааны баг*

Эцэст нь, сурвалжилгын суурь мэдээлэлдээ үндэслэн, сурвалжилгын төлөвлөгөөг боловсруулаад, уг төлөвлөгөөний дагуу ярилцаж, ярилцлагыг бичвэрт буулган, кодолж, утгын шинжилгээ хийж, хийсэн утгын шинжилгээний үр дүнг суурь мэдээллийн “Сурвалжилгын аргаар илэрсэн шалтгаан” гэсэн баганад тоон кодоор оруулж, нэгтгэсэн /Хавсралт 9-ийг харна уу/.

**Гуравдугаар асуултын хүрээнд** “олон нийтийг тэгш оролцуулсан, иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй шийдвэр гаргалт”-ын тухай хүмүүс ямар санаа бодолтой байдгийг хүн ам зүйн үзүүлэлтээр кейс болгон судалж, тодорхойлохыг зорьсон тул мөн чанараараа тоон дискрептив судалгаа хийсэн. Иймээс энэхүү судалгаа нь бүхэлдээ бол *холимог судалгааны дизайнаар* гүйцэтгэгдлээ.


Үүний тулд судалгааны үзэл баримтлалын хүрээнд боловсруулсан ТХЗ-2030-ын Түвшин 1 (Tier I), Түвшин 2 (Tier II)-т хамаарч буй Монгол Улсад дутуу байгаа шалгуур үзүүлэлтүүдийн хэмжилтийн арга зүйг үнэлэх шалгуурын дагуу **баримт бичгийн харьцуулсан тойм шинжилгээ**, тойм шинжилгээнд жишээ болгон ашигласан кейс шалгуур үзүүлэлт 16.7.2-ын мэдээлэл бүрдүүлэх тоон судалгаа хоёрыг **зэрэгцүүлэн** хийсэн.

Гэхдээ кейс болгож сонгож авсан 16.7.2”-ын мэдээлэл бүрдүүлэх эл судалгаа нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн газраас Шалгуур үзүүлэлт 16.7.2 -ыг судлахаар боловсруулж, 2019 онд 8 оронд туршилт судалгаа хийж, цаашид хэрэгжүүлэхээр санал болгоод буй судалгааны зөвлөмжид суурилсан. ТХЗ-ын

16.7.2 болон 16.7.1b, c, 16.6.2 зэрэг шалгуур үзүүлэлтийн арга зүйн зөвлөмж 2020 онд батлагдсан байна (SDG 16 Goal Profile: Final, 2020). НҮБ-аас санал болгож буй нийтлэг арга зүйн зөвлөмж нь дэлхийн улс орнуудыг харьцуулахад зориулагдсан гэж ойлгогдож байна.

16.7.2-ын кейс судалгааны дизайн нь тоон Дискрептив судалгааны арга зүйд үндэслэсэн тул **анкетын аргыг ашиглан анхдагч өгөгдөл, мэдээллээ цуглуулсан**. Учир нь дээр 2.2-р бүлэгт дурдсанаар “хууль, дүрэм журам, бодлого хэлбэрээр хэрэгжиж буй дээрээс доош хүн амд чиглэсэн шийдвэр гаргалтууд нь “зарчим, үйл явц, үр дүн”-г ялгаж байгаа ба **иргэдээс авч буй асуулгууд нь үр дүнг илэрхийлэх анхдагч эх сурвалж болдог** ба зарчим, прогрессыг нь хэмжихүйц үзүүлэлт гэж ч үзэж болно” (Orkin, M., 2017:3). Иймээс ч ЭЗХАХОУБ нь **улс төрийн үр нөлөөний талаарх иргэдийн мэдрэмж, иргэний оролцоо, төрийн үйлчилгээний сэтгэл ханамж, итгэл зэрэг асуудлуудыг иргэдээс нь асууж судлахад төвлөрч байдаг** юм. Түүнчлэн ЭЗХЯамны удирдах ажилтантай ТХЗ-ын ярилцаж байхад тэрээр “Гарахгүй байгаа үзүүлэлтүүдийг яаж гаргах вэ гэдэг асуудал байна. Энэ үзүүлэлтийг гаргадаг ажлыг нэг яам ч чадахгүй, би ч чадахгүй, магадгүй та нар ч чадахгүй. Тэгэхээр яах вэ? хамгийн хялбар арга юу вэ? гэхлээр одоо статистикийн хорооноос хийдэг асуулгууд байгаа. Статистикийн хорооноос мэдээлэл цуглуулдаг тэр юманд нь бид нар асуулт болгож суулгах л арга байна. Хамгийн эхний ээлжинд. Тэр нь ямар байдлаар асуух вэ, асуулт нь юу байх вэ гэдэг нь чухал. Тэгж чадах юм бол эдгээрийн нилээдгүй үзүүлэлтүүд нь гараад ирнэ” хэмээн ярьж байгаа нь ТХЗ-ын зарим мэдээллийг цуглуулахад асуулга ямар чухал болохыг илтгэж байлаа. Ийнхүү эл судалгааны хувьд судалгааны нэгж нь хувь хүн буюу Монгол Улсад оршин суугаа Монгол Улсын иргэн байв. Уг судалгааг дор Зураг 7-д зурагласан дизайны төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

## Зураг 7. Судалгааны үе шат, ерөнхий дизайн



Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолсноор

Энд төлөвлөсөн дизайны хүрээнд судалгааг Үндэсний Статистикийн хороотой хамтран гүйцэтгэсэн. Ялангуяа ТХЗ 16.7.2 шалгуур үзүүлэлтийн туршилт судалгааг Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн А/97 тоот тушаалаар Өрхийн нийгэм эдийн засгийн газартай гэрээ байгуулан хамтран ажиллаж, ҮСХ-ноос түүврийн хэмжээг тогтоож, улс даяар уг асуулгаар судалгаа авлаа. Мөн НҮБ-ын ТХЗ хариуцсан нэгж, Эдийн засгийн хөгжлийн яамны ТХЗ хариуцсан албан тушаалтан, ажилтантай ярилцаж, санал бодлоо солилцон судалгаандаа тусгалаа. Ийм зохион байгуулалттай ажилласан шалтгаан нь энэхүү судалгааны эцсийн үр дүн нь НҮБ-ын ТХЗ-ын мэдээлэл, мөн Үндэсний Статистикийн хорооны судалгааны мэдээлэлд 16.7.2 шалгуур үзүүлэлтэд холбогдох өгөгдөл, мэдээллийг ашиглахад хувь нэмэр оруулах зорилготой байв.

### 3.2. Эх олонлог, түүвэр

Энэхүү судалгааны эх олонлог болон түүвэр нь хоёр түвшинд хийгдсэн.

**Нэгдүгээрт**, Монгол Улсын ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн эх олонлог нь ҮСХ-ноос тогтоогоод байгаа шалгуур үзүүлэлтүүд байв. Эдгээр шалгуур үзүүлэлтээс дараах шалгуураар түүврээ бүрдүүлсэн. Үүнд:

- ТХЗ-ын Монгол Улсын ҮСХ-ны дээр дурдсан жагсаалтад орсон шалгуур үзүүлэлтүүд,
- Үүнээс, тооцож буй 133, тооцох боломжгүй 102 шалгуур үзүүлэлтүүд нийт 235 шалгуур үзүүлэлтийг хамрууллаа.

Үүнээс тооцохгүй байгаа 102 шалгуур үзүүлэлтийн шалтгааныг тодруулах зорилгоор зорилтот түүврээр төрийн захиргааны байгууллагад бодлого, ТХЗ-ын асуудлыг хамаарч байх магадлалтай гэж үзсэн статистик судалгаа хариуцсан, хяналт, шинжилгээ үнэлгээ, төрийн захиргаа, бодлого төлөвлөлт, санхүү бодлого, төсөв зэрэг чиглэлээр ажиллаж буй 14 төрийн захиргааны байгууллагын 20 төрийн захиргааны албан хаагчаас сурвалжилгын аргаар өгөгдөл мэдээлэл цуглууллаа.

**Хоёрдугаарт**, кейс ТХЗ 16.7.2 шалгуур үзүүлэлтийн хувьд, ҮСХ-ны даргын 2022 оны А/97 тоот тушаалын Хавсралт 2-т заасан түүврийн дизайнаар бүрдүүлсэн. Уг дизайнаар Монгол Улсын 18-аас дээш насны 2,096,244 иргэдийг эх олонлог гэж авч үзэн, нийт түүвэрт 6000 иргэдийг хамруулахаар шийдсэн боловч, ТХЗ-ын 16.7.2 шалгуур үзүүлэлтийг тооцох мэдээлэл цуглуулалтаар утсаар асуулга авах явцад утасны дуудлагад хариу өгөхгүй, утсаа авахгүй, утас нь холбогдохгүй зэрэг тохиолдлууд нэлээд гарч байсан тул судалгаанд бэлтгэсэн 3000 нөөц өрхийг нэмснээр нийт 9105 хүнтэй дуудлага хийж 3-5 удаа холбогдох оролдлого хийснээс 4325 хүн тухайн 2 асуултад хариулт өгсөн. Олон улсад ковидоос шалтгаалан утсаар болон онлайн асуулгад хариулагчдын тоо буурсан тул түүнийг тооцох олон арга хэрэглэж байна. Тухайлбал, АНУ-ын хүн амын орлого болон ядуурлын 2020 оны асуулгад 2019 оныхтой харьцуулахад 10 пунктаар бага буюу хариултын түвшин 73%-тай байсан байна. Иймээс уг асуулгын орлогын тухай үр дүнг нь өмнөх жилүүдтэй нь харьцуулж тайлбарласан байна.

<https://www.census.gov/newsroom/blogs/research-matters/2020/09/pandemic-affect-survey-response.html>. Энэ судалгаанд өмнө нь хийсэн харьцуулах судалгаа байхгүйг харгалзан, мөн түүврийн найдвартай байдал хангагдсан гэж үзсэн тул хариултыг ӨНЭЗС-ны өгөгдөлтэй холбож үр дүнг насанд хүрсэн хүн амд тархаан тооцов. Энэ судалгаанд *НҮБ*-ын мета өгөгдөлд заасны дагуу энгийн санамсаргүй түүврээр 18-аас дээш насны хүмүүсээс түүврээ бүрдүүлсэн ба Монгол Улсын хувьд 2,096,244 иргэд байлаа. Тиймээс бид эх олонлогт тархаан ерөнхийлөх бүрэн боломжтой. Тус судалгаа нь стратификаци буюу нийгмийн бүлгийг эх олонлогт тэнцүү харьцаат байдлаар түүвэрт хамруулахыг зориогүй /хөгжлийн бэрхшээлтэй гэх мэт ангилсан бүлэгт/ ба харин энгийн санамсаргүй түүврийн зарчмыг чанд баримтлан, түүн дотроос тухайн түүвэрт хамрагдсан иргэдийн хэдэн хувь нь хөгжлийн бэрхшээлтэй, байршил, бүс, эрэгтэй, эмэгтэй байхыг тодорхойлоход оршиж байгаа юм. Учир нь стратификаци /бүлэглэсэн түүвэр/ түүвэр хийх нь үндсэн зорилго байгаагүй. ҮСХ-ноос баталж гаргасан түүврээр энэ судалгааны түүвэр нь улс, бүсийн хэмжээнд төлөөлөх чадвартайгаар хийгдсэн. Учир нь анхны 6000 түүвэр нь цаанаа бүс бүр дээрээ том 16000 өрхийн судалгаан дээр тархах боломжтойгоор төлөөлөл болгож хийсэн. Ингэж тархахдаа 73 хувийн түүвэр авах боломжтойгоор тархалтыг нь хийсэн тул улсын хэмжээнд төлөөлөх

чадвартай гэж үзнэ. Судалгааны мэдээлэл цуглуулалт Улсын хэмжээнд төлөөлөх чадвартай байсан бөгөөд бүсийн хэмжээнд тодорхой алдааны түвшинд төлөөлөх чадвартай гэж үзсэн /ҮСХ, 2022.11.16/. 16.7.2-шалгуур үзүүлэлтийг асуулгаар авахад ашиглах түүврийн хэмжээг тогтоосон ҮСХ-ны даргын зөвлөлөөр батлагдсан тайлбарыг доорх дэд хэсгээс уншина уу.

### 1. Түүврийн хүрээ

Монгол Улсын нийт өрх, хүн ам судалгааны хүрээг бүрдүүлнэ. 2021 оны эцсийн байдлаар Монгол Улсын 920.2 мянган өрхөд 3.3 сая иргэн амьдарч байна. Нийт эх олонлогоос түүвэрлэн авсан хэсгээр төлөөлүүлэн “Шийдвэр гаргалт нь олон нийтийг тэгш оролцуулсан, иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй байдаг гэдэгт итгэдэг хүн амын эзлэх хувь,” хэмээх үзүүлэлтийг тооцох мэдээллийг бий болгоно.

### 2. Түүврийн домэйн

Судалгааны үр дүнг үндэсний болон бүс нутгийн түвшинд төлөөлөхүйц байдлаар боловсруулах зорилт тавигдсан. Иймд судалгааны домэйн нь бүс байна. Хавсралт 6-д домэйн болон аймаг, дүүргийн хүн ам, өрхийн тоо болон баг/ хорооны нийт тоог харуулсныг үзнэ үү.

### 3. Түүврийн хэмжээ

Тодорхой нэг нутаг дэвсгэр эсвэл хүн амын тодорхой бүлгийн хувьд 2 үе шаттай түүвэр судалгааны түүврийн хэмжээг дараах томъёоллын дагуу тооцсон. Үүнд:

$$n = \frac{z^2 \times P_0 \times (1 - P_0)}{e^2} * deff \quad (1)$$

Энд:

*z* - хүсэж буй ач холбогдлын түвшинг тодорхойлсон статистик утга

*P*<sub>0</sub> - түлхүүр үзүүлэлтийн тооцоо (хувийн жин)

*e* - алдааны хязгаар

*deff* - тухайн дизайны үр ашигтай байдал /design effect/

Дээрх томъёоллын дагуу түүврийн хэмжээг тодорхойлохын тулд эхлээд өгөгдсөн хувьсагчдын утгыг тодорхойлсон. Үүнд:

*z* - 95 хувийн ач холбогдлын түвшин дэх *t* статистикийн тархалтын утга 1.96

*P*<sub>0</sub> - түлхүүр үзүүлэлтийн хувийн жин. (ямар нэгэн мэдээлэл байхгүй өмнө нь судалгаа хийгдэж байгаагүй тохиолдолд =0.5)

*e* - таамаглаж байгаа алдааны хязгаар (Бидний тохиолдолд аймаг, дүүргийн түвшинд үр дүнг тархаах зорилт тавигдаж байгаа тул үндэсний хэмжээнд харьцангуй алдаа 8.0 % буюу абсолют алдаа 0.04)

*deff* - 2.0-той тэнцүү байна гэж таамагласан.

**Хувьсагчдын утгыг дээрх байдлаар тодорхойлж, нэг бүсийн хувьд түүврийн хэмжээг тооцоход ойролцоогоор 1200, нийт 5 бүсийн хувьд 6000 болсон.**

#### 4. Түүврийн хуваарилалт

Түүврийн хэмжээ бүс бүрт тэнцүү 1200 байхаар тооцоолол хийгдсэн. Түүврийн хүрээ нь Монгол Улсын нийт 920.2 мянган өрхөд амьдарч буй 3.3 сая иргэн (2021 оны эцсээр) юм. Бүсийн хувьд өрх, хүн амын тоо харьцангуй ялгаатай байна. Улаанбаатарын хувьд нийт өрх, хүн амын тал орчим хувь амьдарч байгаа юм.

Бид судалгааны үр дүнг үндэсний болон бүс нутгийн түвшинд төлөөлөхүйц байдлаар гаргах зорилтыг тавьсан. Иймээс бүсийн төлөөллийг хангах зорилгоор түүврийн хэмжээг бүсээр тэгш хуваарилсан.

Түүврийн хэмжээг аймгуудын түвшинд хуваарилахдаа ӨНЭЗС-2021 оны түүврийн тархалтыг ашиглан хуваарилалтыг хийж гүйцэтгэснийг доорх хүснэгт болон хавсралт 6-аас харна уу.

#### Хүснэгт 9. Түүврийн хэмжээ

Бүс	Хүн амын тоо	Хувь	Өрхийн тоо	Хувь
Улаанбаатар	1,539,252	46.5	412,527	44.8
Зүүн бүс	229,232	6.9	68,678	7.5
Төвийн бүс	518,417	15.7	152,420	16.6
Хангайн бүс	608,814	18.4	177,129	19.2
Баруун бүс	416,560	12.6	109,411	11.9
<b>Нийт</b>	<b>3,312,275</b>	<b>100.1</b>	<b>920,165</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: ҮСХ-ны тооцоолсноор

#### Хүснэгт 10. Түүврийн хэмжээ бүс болон аймгаар

Бүс/аймаг	Түүврийн хэмжээ
Зүүн бүс	1200
Дорнод	363
Сүхбаатар	363
Хэнтий	474
Төвийн бүс	1200
Төв	277
Говьсүмбэр	0
Сэлэнгэ	224
Дорноговь	171
Дархан-Уул	185
Өмнөговь	171
Дундговь	171

Хангайн бүс	1200
Орхон	112
Өвөрхангай	236
Булган	146
Баянхонгор	191
Архангай	236
Хөвсгөл	280
Баруун бүс	1200
Завхан	265
Говь-Алтай	203
Баян-Өлгий	265
Ховд	203
Увс	265
Улаанбаатар	1200
Багануур	23
Багахангай	3
Баянгол	183
Баянзүрх	303
Налайх	30
Сонгинохайрхан	270
Сүхбаатар	120
Хан-Уул	153
Чингэлтэй	113
Нийт	6000

Эх сурвалж: ҮСХ-ны тооцоолсноор

## 5. Түүврийн сонголт

Эхлээд аймаг болон дүүргээр ӨНЭЗС-2021 онд хамрагдсан 18, түүнээс дээш насны хүмүүсийн жагсаалтыг гаргуулж авсан. Дараа нь аймаг болон дүүрэг тус бүрээр харгалзах тооны түүврээр **энгийн санамсаргүй түүврийн аргыг** ашиглан сонголтыг хийж гүйцэтгэсэн.

## 6. Нөөц нэгж

Судалгааны үр дүнгийн нарийвчлалын түвшинг хадгалах зорилгоор нөөц нэгжийг нэмэлтээр сонгосон. Аймаг болон дүүрэг тус бүрд нөөц нэгжийг сонгож бэлтгэсэн байсан.

## 7. Судалгааны үр дүн, түүврийн жин болон алдаа тооцох

Судалгааны мэдээлэл цуглуулалтын үйл ажиллагаа дууссаны дараа тоон өгөгдлийн чанарыг шалгах, алдааг нягтлах, орлуулга хийх үйл ажиллагаанууд хийгдсэн. Эдгээр үйл ажиллагаанууд хэрэгжсэний дараа судалгааны үндсэн



үр дүнгийн тооцоолол боловсруулах, түүврийн жин, түүврийн алдаа тооцох үйл ажиллагаанууд хэрэгжсэн.

Түүнчлэн түүвэрт хамрагдсан иргэдийг хөгжлийн бэрхшээлтэй хүн амаар, (Хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэсэн стратад зориулсан асуулгын асуултуудыг НҮБХХ-ийн зөвлөмжийн дагуу хүснэгт 7-д байгаа Вашингтон Группийн товч 6 асуултын хүрээнд асууна). Хүн амыг бүсийн байршлаар тэнцүү хувиар хамруулах замаар эх олонлогийн төлөөлөх чадварыг хангахыг зорино. Иймээс энэ судалгааны үйл явц, үр дүнд статистик ерөнхийлөл хийх боломжтой гэж үзсэн.

### Хүснэгт 11. Вашингтон Группийн 6 асуулт

Танд дараах эрүүл мэндийн бэрхшээлүүд байдаг уу?					
Асуултуудыг уншиж өгөн, доорх кодыг ашиглана уу. Хөгжлийн бэрхшээлийг тодорхойлохын тулд энэ асуултыг өрхийн 15 ба түүнээс дээш насны гишүүдээс асууна. Бүх хариулт 1, 2, 99 бол => A14					
(Нэр)-нд юм харахад хүндрэлтэй байдаг уу? (Харааны шил зүүсэн ч)	(Нэр)-нд юм сонсоход хүндрэлтэй байдаг уу? (Сонсголын аппарат зүүсэн ч)	(Нэр)-нд тэгш гадаргуу дээр алхах, налуу гадаргуу дээр өгсөх, уруудахад хүндрэлтэй байдаг уу?	(Нэр)-нд аливаа зүйлийг санах, анхаарлаа төвлөрүүлэхэд хүндрэлтэй байдаг уу?	(Нэр)-нд бие даан усанд орох, хувцсаа өмсөх зэргээр өөрийгөө арчлахад хүндрэлтэй байдаг уу?	(Нэр)-нд бусадтай ярилцахад ямар нэгэн хүндрэлтэй байдаг уу?

Эх сурвалж: YCX

### 3.3. Судалгааны найдвартай ба оновчтой байдал

3.3.1 Дэлхийн ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн Монгол Улс дахь хэрэгжилтэд хийсэн харьцуулсан тойм шинжилгээнд чанарын судалгааны итгэж болохуйц байдлыг хангасан нь

Харьцуулсан тойм шинжилгээ хийхдээ чанарын судалгаанд баримталдаг итгэж болохуйц чанар, шилжих чанар, найдаж болохуйц чанар, баталгаажих чанарын (дэлгэрэнгүй тайлбарыг Narantuya J., 2014:84-89 үзнэ үү) дөрвөн шалгуурыг хангахын тулд баримт бичиг, сурвалжилгын аргыг хослуулан дараах байдлаар ажиллалаа. Үүнд:

- Итгэж болохуйц чанар(credibility)-ыг хангах үүднээс судалж буй ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн талаар гүнзгий мэдээлэл авах, харьцуулсан тойм шинжилгээ хийх үзүүлэлтийг боловсруулахын өмнө YCX-ны тогтвортой хөгжлийн зорилго хариуцсан мэргэжилтнүүд, НҮБ-ын ТХЗ

хариуцсан нэгж, Эдийн засгийн хөгжлийн яамны ТХЗ хариуцсан албан тушаалтан, ажилтан гээд нийт 7 хүнтэй урьдчилан ярилцлага хийж, санал бодлоо солилцон судалгаандаа тусгалаа.

- Найдаж болохуйц чанар (dependability)-ыг хангах үүднээс судалгааны үйл явцад аудит хийж, түүнийг давтан хийх, шүүн тунгаах боломжийг бүрдүүлэх зорилгоор судалгааны үйл явц, процедурыг тууштай, найдвартайгаар баримтжуулан, тайланд нарийн тайлбар өгч, хавсралтуудаар хамаарах материалуудыг хавсаргалаа.
- Баталгаажих чанар (confirmability)-ыг хангах үүднээс судалгааны багийнхан өөрсдийн зүгээс судлаачийн нөлөө гарах нөхцөлийг хязгаарлах зорилгоор энэ чиглэлийн экспертүүдтэй ярилцахаас гадна агуулга, найруулгыг ҮСХ-ны дөрвөн шатны хурлаар хэлэлцүүлээ. Мөн НҮБ-ын ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн Монгол Улсад нутагшуулсан байдал (хэрэгжилт)-д тойм шинжилгээг хийхдээ НҮБ болон Монгол Улсаас боловсруулсан эх сурвалжуудыг ашиглан субстантив<sup>23</sup> контент шинжилгээг урьдчилан хийж харьцуулсныг 4.1-р хэсгээс үзнэ үү. Ингэснээр судалгааны өгөгдөл, түүний тайлбар нь бодит өгөгдөлд суурилсан болохыг илтгэж байгаа юм. Түүнчлэн НҮБ-ын Тогтвортой хөгжил хариуцсан 5 экспертүүд Удирдлагын Академид зочлоход ТХЗ-ын харьцуулсан тойм шинжилгээ хийсэн шалгуурууд, шинжилгээний явц, үр дүн, ТХЗ-ын 16.7.2 кейс шалгуур үзүүлэлтийн туршилтын судалгааны дүнг танилцуулж, санал солилцсон.
- Шилжих чанар (transferability) хангах зорилгоор судалгааны шинжилгээний үйл явцыг нягт нямбай, нарийн дэлгэрэнгүй (a thick description) тайлбарлах замаар хэрэгжүүлснийг энэхүү тайлан илтгэж байгаа юм. Ингэснээр судалгааны үр дүнтэй танилцсан хэн боловч натурал байдлаар өөрийн нөхцөл байдал, орчинд тохирч байгаа эсэхийг тунгааж, ашиглах эсэхээ шийдэх боломжтой гэж үзэж байна.

3.3.2 ТХЗ-ын 16.7.2 кейс шалгуур үзүүлэлтийг тооцох судалгааны оновчтой ба найдвартай байдлын шинжилгээ

ТХЗ-ын 16.7.2 шалгуур үзүүлэлтийг тооцох судалгааг ҮСХ-той хамтран гүйцэтгэхийн өмнө судалгааны баг нь уг үзүүлэлтэд хамаарах асуулгын асуултуудыг дөрвөн чиглэлээр туршиж найдвартай байдлыг хангалаа. Үүнд:

#### 1). Орчуулгын хувьд:

НҮБ-ын Засаглалын Ослогийн зөвлөмжид заасны дагуу асуулгын асуултуудыг англиас монгол руу долоо, монголоос англи руу зургаан хүнээр тус тусад нь хоёр талт орчуулга хийж, англи эх хэл дээрх концепцын утгыг алдуулахгүй байх зарчмыг баримталсан.

<sup>23</sup> Баатартогтох.Ц (2012)-ын тодорхойлсноор тухайн мэдээллийн сурвалжийн субстантив агуулгыг илэрхийлсэн үг, сэдэв, мэдээнд суурилсан судалгаа юм. (Баатартогтох.Ц, 2012, хууд. 208)

## 2). Асуултын найруулгыг үнэлсэн экспертийн үнэлгээ:

Асуулгын асуултуудыг энгийн хүнд ойлгогдож буй байдлыг тандах зорилгоор зургаан хүнд уншиж өгч, хариултыг нь сонсож тэмдэглээд, тэдгээр тэмдэглэлд суурилан дахин улс төр, төрийн бодлого, иргэдийн оролцооны чиглэлийн мэргэжлийн зургаан эксперттэй концепцын утгыг буулгах, оноож хэрэглэсэн үгсийн тухай ярилцаж, хамгийн анхны хувилбараа үг найруулгын хувьд дахин сайжруулсан. Мөн энд төлөвлөсөн дизайны хүрээнд судалгааг Үндэсний Статистикийн хороотой хамтран гүйцэтгэх болсон. Иймээс ҮСХ-ны Өрхийн нийгэм эдийн засгийн газар, Судалгааны арга зүйн зөвлөл, даргын зөвлөл зэрэг хурлуудаар хэлэлцүүлж, тус байгууллагын судлаачдаар үг найруулга болон агуулгыг дахин хянуулав. Үүний үр дүнд ТХЗ 16.7.2 шалгуур үзүүлэлтийн туршилт судалгааг Үндэсний Статистикийн хорооны даргын 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн А/97 тоот тушаалаар Өрхийн нийгэм эдийн засгийн газартай гэрээ байгуулан хамтран ажиллаж, ҮСХ-ноос түүврийн хэмжээг тогтоож, улс даяар уг асуулгаар судалгаа авлаа. Ийм зохион байгуулалттай ажилласан шалтгаан нь энэхүү судалгааны эцсийн үр дүн нь НҮБ-ын ТХЗ-ын мэдээлэл, мөн Үндэсний Статистикийн хорооны судалгааны мэдээлэлд ТАЗ-ын хариуцсан 16.7.2 шалгуур үзүүлэлтэд холбогдох өгөгдөл, мэдээллийг ашиглахад хувь нэмэр оруулах зорилготой байлаа.

### 3). Асуултад хариулахад зарцуулсан цаг хугацаа:

Шийдвэр гаргалтын гадаад үр дүнг хэмжих үндсэн хоёр асуултыг хариулахад дараах хугацааг зарцуулж байв. Үүнд:

*Асуулт 1 "Манай төр засаг иргэдийнхээ санаа бодлыг сонсож, хүлээн авах боломжийг хэр зэрэг бүрдүүлсэн гэж Та бодож байна вэ?"*

- Оролцсон 22 хүний 12 нь тус асуултыг шууд ойлгож хариулсан бөгөөд тус асуултад шууд хариулсан оролцогчид дунджаар 23.7 секундыг зарцуулсан.
- Судалгаанд оролцсон 22 хүний 8 нь нэгдүгээр асуултыг 2 удаа уншуулж, 2 хүн нь 3 удаа уншуулж байж ойлгож хариулсан.

*Асуулт 2 "Манай төр засгийн шийдвэрт иргэдийн санаа бодол хэр зэрэг нөлөөлдөг гэж Та бодож байна?"*

- Оролцсон 22 хүний 20 нь асуултыг шууд ойлгож хариулсан. Тэд тус асуултад шууд хариулахад зарцуулсан дундаж хугацаа 14.32 секунд байна. Судалгаанд оролцсон 22 хүнээс 2 нь Асуулт 2-ыг 2 удаа уншуулж байж ойлгож хариулсан. Асуулт 2-ын тухайд судалгаанд оролцогчид нэг, нэг удаа тус асуултыг уншуулж байж ойлгож хариулсан.

## Хүснэгт 12. Асуултад хариулах хугацааг туршсан байдал, судалгаанд оролцогчдын мэдээлэл

Асуултуудын хугацааг туршсан байдал					Судалгаанд оролцогчдын мэдээлэл		
<p>Энгийн хүнд ойлгогдохуйц байх шаардлагыг хангах үүднээс 22 хүнээс асуултуудыг асууж туршин, үг хэллэгийн ойлгомжтой байдлыг шалгасан. Үг хэллэгийн ойлгомжтой байдал болон зарцуулах цаг хугацааг шалгахдаа дараах хүснэгтийн дагуу тэмдэглэл хөтлөн хийв.</p>					<p>Судалгаанд оролцогчдын мэдээлэл</p>		
Оролцогчийн дугаар	Асуулт 1-г харуулахад зарцуулсан хугацаа (секунд)	Асуулт 1-ийг уншуулж ойлгосон тоо	Асуулт 2-г харуулахад зарцуулсан хугацаа (секунд)	Асуулт 2-ийг уншуулж ойлгосон тоо	Нас	Тоо	Хувь
1	30.2	2	6.27	1	30 хүртэлх насныхан	3	13.6
2	4.04	1	2.4	1	31-50 хүртэлх насныхан	15	68.2
3	6.54	1	25.58	2	51-ээс дээш насныхан	4	18.2
4	6.11	1	10.19	1	<b>Нийт</b>	<b>22</b>	<b>100.0</b>
5	4.3	1	14.24	2	<b>Хүйс</b>		
6	6.42	1	6.2	1	Эрэгтэй	8	36.4
7	6.25	2	12.05	1	Эмэгтэй	14	63.6
8	3.36	1	2.44	1	<b>Нийт</b>	<b>22</b>	<b>100.0</b>
9	4.32	2	2.3	1	<b>Боловсролын түвшин</b>		
10	5.11	1	3.45	1	Бүрэн дунд боловсролтой	3	13.6
11	30	2	10	1	Тусгай дунд боловсролтой	1	4.5
12	60	3	10	1	Дээд боловсролтой	18	81.8
13	120	3	20	1	<b>Нийт</b>	<b>22</b>	<b>100.0</b>
14	45	1	15	1	<b>Ажил эрхлэлт</b>		
15	60	2	30	1	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	3	13.6
16	15	2	40	1	Төрийн албан хаагч	10	45.5
17	30	2	15	1	Өндөр насны тэтгэвэрт	2	9.1
18	10	1	15	1	Оюутай, сурагч	1	4.5
19	15	1	20	1	Бусад	6	27.3
20	20	1	20	1	<b>Нийт</b>	<b>22</b>	<b>100.0</b>
21	30	2	30	1			
22	10	1	15	1			
Дундаж	23.7	1.5	14.3	1.1			

Эх сурвалж: Судалгааны баг

### 4). ТХЗ 16.7.2- шалгуур үзүүлэлтийн асуулгыг сонгогдсон дүүрэгт бүхэлд нь туршсан байдал:

Үндэсний хэмжээнд ТХЗ 16.7.2-ын судалгааг эхлүүлэхийн тулд туршилт судалгааг хийх нь зайлшгүй шаардлага байсан. Туршилт судалгааг хийх үндсэн зорилго нь үр дүнгээс нь юу олж мэдэв, цаашдын судалгаанд яах ёстой вэ, юуг нэмж, хасах вэ, яаж сайжруулах вэ гэдэг шийдвэр гаргахын тулд хийдэг. Иймээс шийдвэр гаргалтын гадаад үр дүнг олон улсад эхний үедээ хэмжихэд хэрэглэж байсан асуултыг ашиглан, эксполатори фактор шинжилгээ, батлах фактор шинжилгээг (confirmatory factor analysis) хийсэн. Үүнд үндсэн 2 асуултаа гаргаж авахад туршиж байсан 13 асуултыг судалгааны баг туршиж үзсэн ба тэдгээр нь Монгол хэлээр буулгаад үзэхэд үндсэн концепцоо илэрхийлж чадаж байгаа эсэхийг судаллаа. Үүний тулд уг 13 асуултаар эксполатори фактор шинжилгээ, найдвартай байдлын шинжилгээ хийгээд үндсэн концепцоо илэрхийлж байгааг харсан. Иймээс Үндэсний хэмжээний судалгаандаа НҮБ-аас санал болгосон өмнө нь Европ, Африкийн 8 улс оронд туршигдсан хоёр асуултаар судалгааг авахаар шийдсэн. Зөвхөн энэ хоёр асуулт нь үндсэн концепцоо бүрэн хэмжиж чадаж байгааг олон улсад баталсан тул дагалтаар хэрэглэж байсан бусад 11 асуултыг бид цаашид хэрэглээгүй гэдгийг энд онцлон тэмдэглэж байна.

Судалгааны баг нийслэлийн 9 дүүргээс санамсаргүйгээр Сүхбаатар дүүргийг сонгосон. Ингээд энэ дүүргийн хотын захын гэр хорооллын 1 хороо, гэр хороолол болон орон сууц холимог 1 хороо, хотын төвийн орон сууцны хороололд оршин суугаа иргэдийн төлөөллөөс судалгаа авсан. 2022 оны 5-р сард Сүхбаатар дүүргээс сонгогдсон хорооны 18 ба түүнээс дээш насны 123 иргэнийг туршилт судалгаанд оролцуулж, асуулгын аргаар мэдээлэл цуглуулж, боловсруулалт хийж ажилласан. Туршилт судалгааны үр дүнг 5-р бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан байгааг үзнэ үү. Хэдийгээр 16.7.2 шалгуур үзүүлэлтийн найдвартай болон оновчтой байдал нь олон улсад аль хэдийн туршигдчихсан боловч энэ хэсэгт бид кейс ТХЗ -ын 16.7.2 шалгуур үзүүлэлтийн асуулгыг 12 асуултаар туршиж, нэгэнт Монгол хэлээр анх авч байгаа асуулга тул оновчтой (factor analysis) болон найдвартай байдлын шинжилгээ (internal consistency reliability test) хийлээ. Юуны өмнө түүврийн хэмжээ нь фактор шинжилгээ хийхэд тохиромжтой эсэхийг КМО тестээр шалгахад .5-аас их байх ёстой (Жюли Паллат (Julie Pallatt, 2016:68, Johendra Kumar Nayak <http://www.youtube.com/watch?v=s>) ба бидний судалгаанд .821 байгаа нь түүвэр нь фактор шинжилгээ хийх боломжтой илэрхийлж байна. Бартлеттийн тест нь .000 байгаа нь асуултуудын хооронд наад зах нь нэг ач холбогдол бүхий корреляци байгааг илтгэж байна. Иймээс энэ туршилт судалгааны асуулга нь фактор шинжилгээ хийх хоёр нөхцөлийг хангасан болохыг Хүснэгт 13-аас харна уу.

### Хүснэгт 13. Фактор шинжилгээ хийх нөхцөл хангасан байдал (КМО болон Бартлеттийн тест)

KMO and Bartlett's Test		
Kaiser-Meyer-Olkin Measure of Sampling Adequacy.		.821
Bartlett's Test of Sphericity	Approx. Chi-Square	688.377
	Df	78
	Sig.	.000

*Эх сурвалж: Судалгааны баг*

Нэгэнт фактор шинжилгээ хийх болзол хангагдсан тул нийт асуулт нь хэдэн бүлэг/бүрэлдэхүүн/факторт хуваагдаж буйг шалгаж үзэхэд Айгенвалю/ Eigenvalues/ нь 1-ээс илүү хоёр бүрэлдэхүүнд хуваагдсан болохыг тодруулсныг доорх Хүснэгт 12-оос харна уу. Мөн энэ хоёр бүлэг асуулт нь нийлээд нийт факторын 55.2%-ийг төлөөлж байна. Энэ нь асуулгын ямар асуултууд ямар бүлэг/бүрэлдэхүүн/факторт харьяалагдаж буйг илтгэхээс гадна энэхүү өгөгдлийг бид фактор тус бүрд найдвартай байдлын шинжилгээ/Кронбах Альфагаар хийхэд (Johendra Kumar Nayak [http://www.youtube.com/watch?v=s\\_Msz\\_wWmGO](http://www.youtube.com/watch?v=s_Msz_wWmGO)) ашигласан.

#### Хүснэгт 14. Асуултуудын бүлэг/бүрэлдэхүүн/фактор

Total Variance Explained									
Component	Initial Eigenvalues			Extraction Sums of Squared Loadings			Rotation Sums of Squared Loadings		
	Total	% of Variance	Cumulative %	Total	% of Variance	Cumulative %	Total	% of Variance	Cumulative %
1	<b>4.944</b>	<b>38.032</b>	<b>38.032</b>	<b>4.944</b>	<b>38.032</b>	<b>38.032</b>	<b>4.324</b>	<b>33.263</b>	<b>33.263</b>
2	<b>2.244</b>	<b>17.264</b>	<b>55.296</b>	<b>2.244</b>	<b>17.264</b>	<b>55.296</b>	<b>2.864</b>	<b>22.033</b>	<b>55.296</b>
3	.974	7.492	62.788						
4	.940	7.230	70.018						
5	.776	5.973	75.991						
6	.595	4.581	80.572						
7	.533	4.097	84.669						
8	.439	3.373	88.042						
9	.421	3.242	91.284						
10	.384	2.957	94.242						
11	.303	2.329	96.570						
12	.281	2.163	98.733						
13	.165	1.267	100.000						

Эх сурвалж: Судалгааны баг

Хүснэгт 13 Корреляцийн матрицаас харахад бүрэлдэхүүнүүд нь тэгтэй ойрхон биш буюу сул корреляцитай байсан тул варимакс/varimax/ (хэрэв корреляци нь 5-аас ихгүй бол тэднийг ортогонал матрикс /варимакс/ гэж үзнэ Johendra Kumar Nayak [http://www.youtibe.com/watch?v=s\\_Msz\\_wWmGO](http://www.youtibe.com/watch?v=s_Msz_wWmGO)) буюу ортогонал сэлгэлт/ротаци хийсэн /Хүснэгт 15-аас харна уу/. Энэ хүснэгтээс харахад “Та оршин суугаа орон нутгийн бодлого, шийдвэрийн талаарх мэдээллийг тогтмол авч чаддаг уу?” гэсэн асуулт нь 2 бүрэлдэхүүнд тэнцүү хувиар давхардсан/crossloading байсан тул асуулгын асуултаас хассан. Бусад нь. 3-аас их байсан тул давхардаагүй гэж үзсэн. Үлдсэн 12 асуулт нь үндсэн хоёр асуултын хоёр бүрэлдэхүүнд хуваагдан орсныг хүснэгт 15-аас харна уу.

### Хүснэгт 15. Rotated component matrix

	Component	
	Иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй шийдвэр гаргалт	Олон нийтийг тэгш оролцуулсан шийдвэр гаргалт
Төрийн байгууллага иргэдийнхээ санал бодлыг гаргаж буй шийдвэртээ тусгадаг гэдэгт итгэдэг үү?	.805	
Өмнө болж өнгөрсөн сонгуулиудыг шударга, хараат бус, чөлөөт сонгууль болж өнгөрсөн гэдэгт Та итгэж байна уу?	.756	
Иргэний нийгмийн байгууллага, иргэдийн бүлэгт нэгдсэнээр шийдвэр гаргалтад нөлөөлөх боломжтой гэдэгт Та итгэдэг үү?	.747	
Таны гаргасан санал, санаачилга шийдвэрт тусгагдаж хэрэгжих боломжтой гэдэгт Та итгэдэг үү ?	.715	.149
Та сонгуулийн үр дүнгээр нийгэмд эерэг өөрчлөлт гарсан гэдэгт итгэдэг үү?	.708	
Таны оршин суугаа орон нутгийн удирдлагууд шийдвэр гаргахдаа Таны санал бодлыг сонсдог уу?	.634	.354
<b>Манай төр засгийн шийдвэрт иргэдийн санаа бодол хэр зэрэг нөлөөлдөг гэж Та бодож байна вэ?</b>	.630	
Үндэсний болон орон нутгийн төрийн байгууллагаас зохион байгуулж буй иргэдийн оролцоог хангасан үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог		.875
Иргэний нийгмийн байгууллагууд болон сайн дурын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог	.106	.874
Хувийн санаачилгаар шийдвэр гаргагчидтай уулзаж аливаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог	.123	.776
<b>Манай төр засаг иргэдийнхээ санаа бодлыг анхааран сонсох боломжийг хэр зэрэг бүрдүүлсэн гэж Та бодож байна вэ?</b>	.200	.710
Үндэсний болон орон нутгийн сонгуулиудад саналаа өгч идэвхтэй оролцдог		.569
<b>Та оршин суугаа орон нутгийн бодлого, шийдвэрийн талаарх мэдээллийг тогтмол авч чаддаг уу?</b>	<b>.441</b>	<b>.451</b>
Extraction Method: Principal Component Analysis. Rotation Method: Varimax with Kaiser Normalization.		
a. Rotation converged in 3 iterations.		

Эх сурвалж: Судалгааны баг

Ингээд асуулгын хоёр бүрэлдэхүүн тус бүрт хамаарах асуултуудын утга, асуулт хоорондын дотоод уялдаа холбооны найдвартай байдлын түвшинг Кронбах Альфагийн коэффициентоор тодорхойлсныг дор харуулж байна.

“Олон нийтийг тэгш оролцуулсан шийдвэр гаргалт”-ын найдвартай байдлын коэффициент нь .767 байгаа нь 0.7-гоос их байгаа тул асуултуудын дотоод уялдаа холбоо найдвартай байдлыг хангаж байгааг харуулж байна /Хүснэгт 16-аас харна уу/.

#### Хүснэгт 16. Олон нийтийг тэгш оролцуулсан шийдвэр гаргалт бүрэлдэхүүний найдвартай байдлын шинжилгээ

Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items
.777	.767	5

Эх сурвалж: Судалгааны баг

Гэхдээ Жюли Паллат (Julie Pallatt, 2016:68), Бригс болон Чийк (Briggs and Cheek, 1986) нарын анхааруулснаар нэг бүрэлдэхүүнд хамаарах асуултын тоо нь 10-с доош буюу цөөн бол найдвартай байдлын коэффициентийг дунджаар нь илэрхийлэх зүйтэй ба энэ нь .2-оос .4-ийн хооронд хэлбэлзэж байвал найдвартай гэж үзнэ хэмээжээ. Иймд энэ бүрэлдэхүүн нь 5 асуулттай тул дунджийг нь үзэхэд .397 байгаа нь хангалттай үзүүлэлт болохыг илтгэж байна /Хүснэгт 17-оос харна уу/.

#### Хүснэгт 17. Олон нийтийг тэгш оролцуулсан шийдвэр гаргалт бүрэлдэхүүний найдвартай байдлын коэффициентын дундаж

	Mean	Minimum	Maximum	Range	Maximum / Minimum	Variance	N of Items
Inter-Item Correlations	.397	.154	.736	.583	4.794	.044	5

Эх сурвалж: Судалгааны баг

“Иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй шийдвэр гаргалт” -ын найдвартай байдлын коэффициент нь .853 байгаа нь энэ бүрэлдэхүүний асуултуудын утгын дотоод уялдаа холбоо найдвартай байдлыг хангаж байгааг харуулж байна /Хүснэгт 18-аас харна уу/.

#### Хүснэгт 18. Иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй гаргалт бүрэлдэхүүний найдвартай байдлын шинжилгээ

Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items
.853	.854	7

Эх сурвалж: Судалгааны баг



Энэ бүрэлдэхүүн нь 7 асуулттай тул дунджийг нь үзэхэд .455 байгаа нь хангалттай үзүүлэлт болохыг илтгэж байна /Хүснэгт 19-өөс харна уу/.

**Хүснэгт 19.Иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй шийдвэр гаргалт бүрэлдэхүүний найдвартай байдлын коэффициентын дундаж**

	Mean	Minimum	Maximum	Range	Maximum / Minimum	Variance	N of Items
Inter-Item Correlations	.455	.319	.593	.273	1.857	.007	7

*Эх сурвалж: Судалгааны баг*

Дээрх оновчтой ба найдвартай байдлын шинжилгээнээс дүгнэхэд ТХЗ-ын 16.7.2 шалгуур үзүүлэлтийн асуулга нь үндсэн концепцоо илэрхийлж чадаж байгаа ба энэ нь НҮБ-ын Ослогийн Засаглалын төвийн судалгааны дүнтэй нийцэж байгааг илтгэж байна. Иймээс цаашид НҮБ-аас санал болгосон өмнө нь Европ, Африкийн 8 улс оронд туршигдсан хоёр асуултын хүрээнд судалгааг авахаар тогтсон.

**3.4. Судалгааны ёс зүй**

Судалгаанд сурвалжилга, анкетын асуулгын явцад хоёуланд нь судалгааны ёс зүйг чанд барин гүйцэтгэлээ. Үүнд:

*Нэгдүгээрт*, судалгаанд оролцогч хувь хүний нууцлалыг ҮСХ-ны баримталдаг нэр, хаягийн нууцлалыг хадгалах судалгааны ёс зүйн зарчмыг ханган ажилласан.

*Хоёрдугаарт*, ганцаарчилсан сурвалжилгаар 20 хүнээс мэдээлэл цуглуулахдаа судалгааны арга зүйд баримталдаг судалгааны зорилгыг таниулж, судалгаанд оролцогчдын мэдээллийг кодолж боловсруулалт хийлээ.

*Гуравдугаарт*, мөн судалгаанд ашигласан өгөгдөл, мэдээллийг үнэн зөвөөр цуглуулж, боловсруулах, судлаачийн хүсэл, нөлөөнд автахгүй байх ёс зүйн зарчмыг нарийн чанд баримталж, бүхий л мэдээллийг баримтжуулж, тайланд тайлбартайгаар орууллаа.

**3.5. Өгөгдөл шинжилгээ**

Өгөгдлийн шинжилгээ нь мөн хоёр түвшинд хийгдсэн. Үүнд:

*Нэгдүгээрт*, Түвшин 1, Түвшин 2-т хамаарч буй ч Монгол Улсад дутуу байгаа шалгуур үзүүлэлтүүдийг хэмжих арга зүйд харьцуулсан тойм шинжилгээ хийхдээ судалгааны үзэл баримтлалд томъёолон боловсруулсан шалгуур үнэлгээний хүрээнд контент шинжилгээ хийж, Excel программ дээр

шинжиллээ. 20 респонденттай ярилцсан сурвалжилгын өгөгдөлд утгын шинжилгээг дедуктив замаар хийж, шинжиллээ.

Хоёрдугаарт, 16.7.2-ын кейс шалгуур үзүүлэлтийг асуулгаар Монгол Улсын 5 бүсийн 18-аас дээш насны түүвэрт хамрагдсан иргэдээс авсан өгөгдлийн тоон мэдээллийн шинжилгээг Excel, SPSS болон бусад тоон шинжилгээ хийх боломжтой бусад программаар боловсрууллаа.

Анкетын асуултын мэдээллийг урьдчилан хийсэн туршилт судалгааны найдвартай болон оновчтой байдлын шинжилгээгээр баталгаажуулсан.

### Хэмжилтийг тооцох арга

Кейс 16.7.2-ын шалгуур үзүүлэлтийн мэдээллийг цуглуулах судалгааны асуултуудыг доор хүснэгтэд үзүүлсэн Ликертийн таван шкалаар хэмжлээ. Үүнээс үндсэн хоёр асуултад эерэгээр хариулсан респондентуудын хувийг дараах байдлаар тооцов. Үүнд:

а. 3 буюу “бага зэрэг”, 4 буюу “их”, 5 буюу “маш их” гэж хариулсан тохиолдолд доорх Хүснэгт 20-д жишээ болгосноор нэгтгэн хувилна.

### Хүснэгт 20. Үндсэн асуултууд, хэмжих шкал (Ликертийн 5 шкал)

1. Манай төр засаг иргэдийн санаа бодлыг анхааран сонсох боломжийг хэр зэрэг бүрдүүлсэн гэж Та бодож байна вэ?		2. Манай төр засгийн шийдвэрт иргэдийн санаа бодол хэр зэрэг нөлөөлдөг гэж Та бодож байна вэ?	
1- Огт бүрдүүлээгүй	8%	1- Огт нөлөөлдөггүй	16%
2- Маш бага	22%	2- Маш бага	30%
3- Заримдаа	26%	3- Заримдаа	26%
4- Хангалттай	34%	4- Хангалттай	14%
5- Хангалттай сайн	10%	5- Хангалттай сайн	14%
6-Мэдэхгүй		6-Мэдэхгүй	
7-Хариулахаас татгалзсан		7-Хариулахаас татгалзсан	
Эергээр хариулсан хүний % (жишээ нь, 3, 4 болон 5-ыг сонгосон хүмүүс)	(26%+34%+10%) = 70%	Эергээр хариулсан хүний % (жишээ нь, 3, 4 болон 5-ыг сонгосон хүмүүс)	(26%+14%+14%) = 54%

Эх сурвалж: НҮБ-ын зөвлөмжийн дагуу

б. Дээрх нэгтгэсэн хоёр хувийн дунджийг эцэст нь мөн дундчилсан. Жишээ нь:  $(70\% + 54\%) / 2 = 62\%$

Асуулт тус бүрт “мэдэхгүй”, “хариулахаас татгалзсан” гэсэн хариултыг сонгосон судалгаанд оролцогчдын тоог тодорхой мэдээлэх нь чухал, гэхдээ “мэдэхгүй”, “хариулахаас татгалзсан” гэж хариулсан судалгаанд

оролцогчдын тоог хасаж үзүүлэлтийг тооцно. Жишээлбэл, 1000 оролцогчдын 65 нь асуултад “мэдэхгүй” болон “хариулахаас татгалзсан” тохиолдолд хасаж, эерэг хариултын хувийг 935 хүнээс тооцно гэсэн үг.

Мөн түүврийн кейсүүдийг орлого, боловсролын түвшин, оршин сууж буй газар гэсэн дараах үзүүлэлтүүдээр задалж судална.

- Үзүүлэлтийн задаргаа:
  - насаар
  - хүйсээр
  - хөгжлийн бэрхшээлтэй байдлаар<sup>24</sup>
  - орлогын түвшнээр
  - боловсролын түвшнээр
  - байршлаар

---

<sup>24</sup> Хөгжлийн бэрхшээлтэй байдлыг НҮБ-ын Статистикийн газраас боловсруулсан Вашингтон бүлгийн асуулгаар асуусан. Вашингтон бүлгийн асуулгыг ҮСХ-ноос баталсан орчуулга болон тус байгууллагын арга зүй, нэр томъёог ашиглан хийлээ.

# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ДЭЛХИЙН ТХЗ-ЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН МОНГОЛ УЛС ДАХЬ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХАРЬЦУУЛСАН ТОЙМ ШИНЖИЛГЭЭ

Харьцуулсан тойм шинжилгээнд 2022 оны 6 дугаар сарын 09-ний байдлаар НҮБ-аас боловсруулсан, тооцох арга зүй, аргачлал олон улсад батлагдсан Түвшин 1 (Tier I), Түвшин 2 (Tier II)-д хамрагдах нийт 248 шалгуур үзүүлэлт тодорхойлогдсоноос Монгол Улсын ҮСХ-ноос тооцох арга зүй аргачлалыг баталсан нийт 133 шалгуур үзүүлэлт байгаагаас 132 шалгуур үзүүлэлтийг Монгол Улс тооцож байгаа, 1 шалгуур үзүүлэлт нь тооцох боломжгүй байгаа гэсэн ангилалд хамаарсан байв. Иймээс эл судалгаанд НҮБ-аас боловсруулсан ТХЗ-ын нийт 248 шалгуур үзүүлэлтийг Монгол Улсад тооцож байгаа 132 шалгуур үзүүлэлт, тооцох боломжгүй байгаа 103 шалгуур үзүүлэлттэй буюу нийт 235 шалгуур үзүүлэлттэй харьцуулж тойм шинжилгээ хийлээ. Үүнээс 13 шалгуур үзүүлэлтийг Монгол Улсад хамааралгүй хэмээн тодорхойлсон байгаа тул харьцуулалтаас хассан. Тухайлбал 14.1.1-д “Эрэг хавийн эутрофикаци индекс болон хөвөгч хуванцар хог хаягдлыг нягтрал”, 14.3.1-д “Дээж цуглуулах станцууд дээр хэмжигдсэн далайн усны хүчиллэгийн дундаж түвшин (pH)”, 14.5.1-д “Хамгаалагдсан эргийн болон далайн газрын эзлэх хувь” гэх мэт Монгол улсад хамааралгүй шалгуур үзүүлэлтүүд байсан тул энд судалгаанд авч шинжлээгүй болно.

## 4.1. ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон эх сурвалжуудын харьцуулалт

НҮБ-ын ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн Монгол Улсад нутагшуулсан байдал (хэрэгжилт)-д тойм шинжилгээг хийхдээ НҮБ болон Монгол Улсаас боловсруулсан дараах эх сурвалжуудыг ашиглан субстантив<sup>25</sup> контент шинжилгээ хийж харьцууллаа. Үүнд:

1. НҮБ-аас боловсруулсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн ангилал (United Nations, 2022)
2. НҮБ-аас боловсруулсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн аргачлал (United Nations, 2022)
3. Монгол Улсын ҮСХ-ноос боловсруулсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн ангилал<sup>26</sup>
4. Монгол Улсын ҮСХ-ноос боловсруулсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн аргачлал<sup>27</sup>

25 Баатартогтох.Ц (2012)-ын тодорхойлсноор тухайн мэдээллийн сурвалжийн субстантив агуулгыг илэрхийлсэн үг, сэдэв, мэдээнд суурилсан судалгаа юм. (Баатартогтох.Ц, 2012, хууд. 208)

26 ҮСХ-ноос мэйлээр хүлээж авсан

27 ҮСХ-ноос мэйлээр хүлээж авсан

## 5. Монгол Улсын ЭЗХЯ-наас боловсруулсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн ангилал (төсөл)<sup>28</sup>

Хэдийгээр нэгдмэл улс гэдэг утгаараа Монгол Улсын ҮСХ болон ЭЗХЯ-ны боловсруулсан баримт бичгүүд ижил агуулгатай байх ёстой боловч тухайн хоёр эх сурвалж дахь зарим шалгуур үзүүлэлтүүдийн мэдээлэл нь зөрүүтэй байсан тул тус тусад нь эх сурвалж болгон ашиглалаа. Нэг үгээр хэлбэл, Дэлхийн ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн Монгол Улс дахь хэрэгжилтэд хийсэн тойм шинжилгээ нь НҮБ, ҮСХ, ЭЗХЯ гэсэн 3 байгууллагаас гаргасан эх сурвалжуудыг ашигласан контент шинжилгээ болно.

### Хүснэгт 21. Баримт бичигт туссан шалгуур үзүүлэлтүүдийн тоо

Эх сурвалж, байгууллагаар	Шалгуур үзүүлэлтийн тоо
НҮБ /2022.02.04/	247
НҮБ /2022.06.09/	248
Монгол Улсын ҮСХ /вэб сайт/	244
Монгол Улсын ҮСХ /мэйл/	247
Монгол Улсын ЭЗХЯ /төсөл/	224
НЭГТГЭЛ	258

*Эх сурвалж: Судалгааны баг*

НҮБ нь ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдэд ямар нэгэн өөрчлөлт орох бүрт ТХЗ-ын вэб сайт дээрх ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн ангилал<sup>29</sup> гэсэн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж, түүнийг онлайн хэлбэрээр татаж авах боломжтойгоор байршуулдаг. Уг байгууллагаас боловсруулж гаргасан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн ангиллыг 2022 оны 2 дугаар сарын 04 болон 6 дугаар сарын 09-нд өөрийн вэб сайтдаа байршуулсан эх сурвалжаас<sup>30</sup> харахад анх 247 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон боловч 6 дугаар сарын байдлаар 248 шалгуур үзүүлэлт танилцуулсан байсан. Эндээс харахад НҮБ-аас сүүлд гаргасан эх сурвалж нь өмнөхөөсөө 1 шалгуур үзүүлэлтээр илүү харагдаж байгаа боловч тухайн хоёр эх сурвалжийг хооронд нь харьцуулахад 243 шалгуур үзүүлэлт нь ижил, 5 шалгуур үзүүлэлтэд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Эдгээр 5 шалгуур үзүүлэлтэд орсон нэмэлт өөрчлөлтийг эх текстээр нь (Монгол хэлээр хөрвүүлэхгүйгээр) Хүснэгт 22-д харуулав.

28 Тус файл нь УИХ-аар хэлэлцүүлж батлуулахаар боловсруулсан (батлагдаагүй) бөгөөд албан бусаар Microsoft Excel файлаар хүлээж авсан.

29 IAEГ-SDGs — SDG Indicators (un.org) ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн ангиллыг татаж авах файлын холбоосыг PDF болон Microsoft Excel файл хэлбэрээр байршуулдаг байна.

30 Тухайн эх сурвалжийг тухайн сайтад Microsoft Excel файл хэлбэрээр байршуулсан.

## Хүснэгт 22. Нэмэлт өөрчлөлт оруулсан 5 шалгуур үзүүлэлт

ID	UNSD Indicator Code <sup>^</sup>	Indicator //2022.02.04//	Indicator /2022.06.09/	Tier Classification	Notes
1	<b>C170304</b>	17.3.1 Foreign direct investment, official development assistance and South-South cooperation as a proportion of gross national income	<b>17.3.1 Additional financial resources mobilized for developing countries from multiple sources</b>	Tier I/ II depending on resource	<b>Proposed new indicator developed by the Working Group on Measurement Support and adopted at UNSC53</b>
2	<b>C160105</b>	16.1.4 Proportion of population that feel safe walking alone around the area they live	<b>16.1.4 Proportion of population that feel safe walking alone around the area they live after dark</b>	Tier II	<b>UNSC 53 refinement</b>
3	C120701	12.7.1 Degree of sustainable public procurement policies and action plan implementation	<b>12.7.1 Number of countries implementing sustainable public procurement policies and action plans</b>	Tier II	<b>Refinement of the indicator name approved in the interim by the Inter-agency and Expert Group on SDG Indicators (IAEG-SDGs) and pending final approval by the 54th session of the Statistical Commission in March 2023. UNSC 51 refinement</b>
4	<b>C110503</b>		<b>11.5.3 (a) Damage to critical infrastructure and (b) number of disruptions to basic services, attributed to disasters</b>		<b>The current indicator 11.5.3 was previously part of 11.5.2; previous indicator 11.5.2 was refined to split to the current 11.5.2 and the current 11.5.3 during UNSC 53 refinement</b>

5	C110502	11.5.2 Direct economic loss in relation to global GDP, damage to critical infrastructure and number of disruptions to basic services, attributed to disasters	<b>11.5.2 Direct economic loss attributed to disasters in relation to global gross domestic product (GDP)</b>	Tier II	<b>UNSC 53 refinement</b> <b>1.5.2/11.5.2 are repeats</b>
---	---------	---	---	---------	--

Эх сурвалж: (United Nations, 2022)

**Тайлбар:** "Тодруулсан" өнгөөр ялгасан хэсэгт өөрчлөлт орсныг тэмдэглэж байгаа бөгөөд 12.7.1, 16.1.4 болон 17.3.1 дэх шалгуур үзүүлэлтийн нэр нь өөрчлөгдсөн бол 11.5.2-т байсан шалгуур үзүүлэлтийг 11.5.2 болон 11.5.3 хэмээн хоёр шалгуур үзүүлэлт болгон салгаж өгсөн ч түвшин/ангиллыг нь зааж өгөөгүй байна. Өөрөөр хэлбэл өмнө нь 11.5.2-т хоёр шалгуур үзүүлэлтийг нэг дор оруулсан байсан.

Үндсэндээ НҮБ-аас 2022 оны 6 дугаар сарын 09-ний байдлаар ТХЗ-ын нийт 248 шалгуур үзүүлэлтийг кодолж, томьёолж, 17 зорилго, үүний дотор 169 дэд зорилгод бүлэглэж ангилсан боловч шинээр салгаж оруулсан 11.5.3-т заасан шалгуур үзүүлэлтийн түвшин буюу ангиллыг нь тодорхойлж өгөөгүй байна (ШҮ-ын ангиллыг НҮБ-ын тодорхойлсныг доорх хүснэгтээс харна уу).

### Хүснэгт 23. НҮБ-аас боловсруулж гаргасан шалгуур үзүүлэлтийн түвшин

Шалгуур үзүүлэлтийн түвшин/ангилал	НҮБ /2022.06.09/
Tier I	144
Tier I (a)/Tier II (b)	1
Tier I (a)/Tier II (b, c)	1
Tier I/II depending on indice	1
Tier I/II depending on resource	1
Tier II	99
(blank)	1
<b>НИЙТ</b>	<b>248</b>

Эх сурвалж: (United Nations, 2022)

Харин Монгол Улсаас гаргасан гурван эх сурвалжийн хувьд ҮСХ-ны албан ёсны вэб сайтанд байршуулснаар ТХЗ-ын нийт 244 шалгуур үзүүлэлт<sup>31</sup>, ҮСХ-ноос бидэнд мэйл хаягаар илгээсэн эх сурвалжид ТХЗ-ын нийт 247 шалгуур үзүүлэлт, ЭЗХЯ-аас файл хэлбэрээр авсан /төсөл буюу УИХ-аар батлагдаагүй/ эх сурвалжид ТХЗ-ын нийт 224 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна. Эдгээр эх сурвалжуудын ялгаатай байдлаас үүдэн НҮБ-аас боловсруулсан

ТХЗ-ын нийт 248 шалгуур үзүүлэлт нь энэхүү харьцуулсан тойм шинжилгээнд нийт 258 шалгуур үзүүлэлт болж харагдаж байгааг шалгуур үзүүлэлтүүдийн түвшнээр нь ялгаж авч үзвэл дараах байдалтай байна. (Хүснэгт 19-өөс харна уу). Уг хүснэгтээс харахад НҮБ-аас гаргасан 248 ТХЗ-ын шалгуур үзүүлэлтээс 131 шалгуур үзүүлэлтийг нь Монгол Улсын хувьд тооцож байгаа, 1 шалгуур үзүүлэлт нь тооцож байгаа боловч орлуулж тооцож байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл нийт 248 ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн 53.2%<sup>32</sup>-ийг Монгол Улсын хэмжээнд тооцож байна. Харин 103 ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг нь Монгол Улсын хувьд тооцохгүй байгаа хэмээн тодорхойлсон бол 13 шалгуур үзүүлэлтийг нь Монгол Улсын хувьд хамааралгүй шалгуур үзүүлэлт гэж ангилжээ. Энэхүү 13 шалгуур үзүүлэлтийг тодорхойлбол<sup>33</sup> НҮБ-аас гаргасан ТХЗ-ын 14 дэх зорилт болох “Тогтвортой хөгжлийн зорилгоор далай, тэнгис, далайн нөөц баялгийг хамгаалах, тогтвортой ашиглах”-тай холбоотой нийт 10 шалгуур үзүүлэлт, 3 дахь зорилтын 3.3.3-т заасан “100,000 хүн амд ногдох хумхаа өвчний тохиолдол” болон 3.3.5.-т заасан “Халуун орны устсан өвчний эсрэг эмчилгээ шаардлагатай хүмүүсийн тоо”, мөн 5.3.2-т заасан “Эмэгтэй бэлэг эрхтнийг хөндөх/хөвч таслах үйл хийлгэсэн 15-49 насны охид, эмэгтэйчүүдийн эзлэх хувь (зөвхөн хамааралтай улс орнуудын хувьд), насны бүлгээр” гэсэн нийт 13 шалгуур үзүүлэлтийг Монгол Улсын хувьд хамааралгүй гэж тодорхойлсон байна.

#### Хүснэгт 24. НҮБ-аас тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн түвшин ба Монгол Улс дахь шалгуур үзүүлэлтүүдийн бэлэн байдал хоорондын харьцуулалт

ҮЗҮҮЛЭЛТ		Монгол Улсын ҮСХ /мэйл/ -ноос гаргасан ТХЗ-ын ШҮ-ийн мэдээллийн бэлэн байдал					НИЙТ
		Тооцож байгаа	Тооцож байгаа: орлуулсан	Тооцохгүй байгаа	Хамааралгүй	blank	
НҮБ /2022.06.09/-аас гаргасан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн түвшин	Tier I	85	1	50	8		144
	Tier I (a)/Tier II (b)			1			1
	Tier I (a)/Tier II (b, c)	1					1
	Tier I/II depending on indice	1					1
	Tier I/II depending on resource	1					1

32 НҮБ-аас гаргасан нийт 248 шалгуур үзүүлэлтийн 132 шалгуур үзүүлэлтийг нь Монгол Улсад тооцож байна гэж үзээд 132-г 248-д харьцуулж хувиар илэрхийлэв.

33 Монгол Улсын ҮСХ-ноос мэйлээр ирүүлсэн эх сурвалжид үндэслэн гаргасан болно.



	Tier II	43		51	5		99
	(blank)			1		10	11
	<b>НИЙТ</b>	<b>131</b>	<b>1</b>	<b>103</b>	<b>13</b>	<b>10</b>	<b>258</b>

Эх сурвалж: Судалгааны баг

Гэтэл НҮБ-аас тодорхойлсон ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн түвшинд багтаагүй нийт 11 шалгуур үзүүлэлт байгаагаас нэг шалгуур үзүүлэлт нь нэмэлт өөрчлөлтөөр бий болсон 11.5.3-т заасан “Үндсэн дэд бүтцэд учруулсан гэмтэл болон суурь үйлчилгээ тасалдсан тоо” гэсэн шалгуур үзүүлэлт юм. Энэ шалгуур үзүүлэлт нь өмнө нь 11.5.2-т заасан шалгуур үзүүлэлтэд багтаж байсан бөгөөд 2022 оны 6 дугаар сарын байдлаар тусад нь салгаж томъёолсон үзүүлэлт гэдгийг дээр өгүүлсэн. Харин НҮБ-ын боловсруулсан түвшинд багтаагүй 10 шалгуур үзүүлэлт авч үзэхэд Монгол Улсын ҮСХ-ноос мэйлээр ирсэн эх сурвалж мөн байхгүй шалгуур үзүүлэлт байна. Өөрөөр илэрхийлбэл, энэ 10 шалгуур үзүүлэлт нь ҮСХ-ны вэбсайт дээр байршуулсан болон ЭЗХЯ-наас албан бус төсөл хэлбэрээр авсан эх сурвалжтай шууд холбоотой байна. Тухайлбал НҮБ-аас 2022 оны 6 дугаар сарын байдлаар тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн жагсаалтад тодорхойлогдоогүй дараах 5 шалгуур үзүүлэлтүүдийг ҮСХ-ны вэбсайтад байршуулсан эх сурвалжид:

- 1.а.3 Ядуурлыг бууруулах хөтөлбөрт шууд хуваарилсан нийт буцалтгүй тусламжийн ДНБ-д эзлэх хувь
- 8.9.2. Нийт аялал жуулчлалын ажлын байранд тогтвортой аялал жуулчлалын салбарын ажлын байрны эзлэх хувь
- 11.с.1. Дотоодын материал ашиглаж тогтвортой, уян, нөөцийг үр ашигтай зарцуулсан барилга барих болон барилгыг сайжруулахад буурай хөгжилтэй орнуудад үзүүлж буй санхүүгийн дэмжлэгийн эзлэх хувь
- 13.3.2. Дасан зохицох, технологи шилжүүлэх, хөгжлийн үйл ажиллагааг нэвтрүүлэхэд байгууллагын, системийн, хувь хүний чадавхыг бэхжүүлэх талаар мэдээлдэг улс орнуудын тоо
- 17.6.2. 100 оршин суугчдад ногдох суурин интернэтийн өргөн зурвас ашиглах бүртгэлийн тоо, хурдаар 5 шалгуур үзүүлэлтийг ЭЗХЯ-наас төсөл хэлбэрээр авсан эх сурвалж Excel файл/-д:
- 3.5.3. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэгчдийн хувь
- 7.1.3. Евро-5 стандартын шатахууны хэрэглээ
- 7.1.4. Нийт малчин өрхийн сэргээгдэх эрчим хүч хэрэглэдэг өрхийн эзлэх хувь

- 11.2.2. Нийтийн тээврээр ая тухтай зорчдог хүн амын эзлэх хувь<sup>34</sup>
- 11.2.3. Улаанбаатар Смарт Картын системд бүртгэгдсэн зорчилтын тоо, хүн амын бүлгээр тус тус тодорхойлжээ.

Энэ бүгдээс авч үзэхэд НҮБ-аас 2022 оны 6 дугаар сарын 09-нд нэмэлт өөрчлөлт оруулсан болон Монгол Улсын ҮСХ-ноос мэйлээр бидэнд илгээсэн эх сурвалжид туссан нийт Дэлхийн ТХЗ-ын 248 шалгуур үзүүлэлтийн хувьд харьцуулсан тойм шинжилгээ хийх нь ТХЗ-ын Монгол Улсад дутуу байгаа шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах сэдэвтэй илүү уялдаж байна. Иймээс бид дээр тодорхойлсон НҮБ-аас гаргасан эх сурвалжид тусаагүй 10 шалгуур үзүүлэлтийг харьцуулсан тойм шинжилгээнд оруулахгүй болно.

#### 4.2. Харьцуулсан тойм шинжилгээнд ашиглах субстантив контент шинжилгээний үзүүлэлтийг тодорхойлох нь

Дэлхийн шалгуур үзүүлэлтүүдийг Монгол Улсад нутагшуулсан байдалд хийсэн контент шинжилгээ нь НҮБ-аас боловсруулсан ТХЗ-ын I болон II-түвшинд багтсан 132 шалгуур үзүүлэлтийг хамрах бөгөөд Монгол Улсад эдгээр 132 шалгуур үзүүлэлтийг тооцож байгаа гэх ангилалд багтаасан ч тэдгээрийг тооцоходоо олон улсын түвшинд тодорхойлсон шалгуур үзүүлэлттэй холбоотой судалгааны арга зүй, аргачлалтай бүрэн нийцэж байгаа эсэхийг тодорхойлохыг зорилоо. Нөгөө талаас, олон улс болон Монгол Улсын ТХЗ-ын шалгуур үзүүлэлт болон түүнтэй холбоотой судалгааны арга зүй, аргачлалууд ялгаатай байдал үүссэн бол тухайн шалгуур үзүүлэлтийг энэхүү судалгаанд “Тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт” гэж үзэн ямар ялгаа байгааг нь тодруулахыг зорьсон. Өөрөөр хэлбэл, НҮБ-аас гаргасан ТХЗ-ын бүх шалгуур үзүүлэлт нь үндсэндээ түвшин 1 болон 2 гэсэн ангилалд багтаж, бүх шалгуур үзүүлэлтүүдийн концепц нь тодорхойлогдсон, Олон улсын түвшинд судалгааны арга зүй, тооцох аргачлал болон стандарт нь батлагдсан хэдий боловч яг ямар үзүүлэлтүүдийг Монгол Улсад ойролцоо утга бүхий шалгуур үзүүлэлтээр эсвэл орлуулан тооцож, хэмжиж байгааг шинжилж, тухайн шалгуур үзүүлэлттэй холбоотой ямар мэдээлэл нь Дэлхийн шалгуур үзүүлэлтээс ялгаатай байгааг тодорхойлон гаргах нь ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн нутагшуулсан байдалд хийсэн субстантив контент шинжилгээ хэмээн тодорхойлсон билээ. Иймээс Монгол Улсад нутагшуулж байгаа шалгуур үзүүлэлтийн хувьд контент шинжилгээний арга зүй ашиглан ТХЗ-ын шалгуур үзүүлэлт болон түүнтэй холбоотой судалгааны арга зүй, тооцох аргачлал болон стандартыг НҮБ-ынхтай харьцуулан судаллаа. Энэхүү харьцуулсан тойм шинжилгээний эхний

34 Энэхүү шалгуур үзүүлэлт нь НҮБ-аас гаргасан 11.2.1-д заасан шалгуур үзүүлэлттэй агуулгын хувьд ойролцоо боловч ЭЗХЯ-аас тодорхойлохдоо 11.2.2. хэмээн заалтын дугаарыг өөрчилсөн, нөгөө талаас 11.2.1-д “Нийслэлийн нийтийн тээврээр зорчдог хүн амын эзлэх хувь, хүн амын бүлгээр” гэсэн шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон (НҮБ-аас гаргасан 11.2.1-д заасан шалгуур үзүүлэлтээс агуулгын хувьд ялгаатай) байгаа тул олон улсын аргачлалаар тодорхойлсон шалгуур үзүүлэлтэд тодорхойлогдоогүй гэж үзлээ.

хэсэгт дараагийн хэсэгт тайлбарлах 3 үндсэн зүйл, 15 дэд үзүүлэлт ашиглав (Хавсралт 2-ыг харна уу).

### **4.3. Харьцуулсан тойм шинжилгээний үр дүн**

#### **4.3.1. “Шалгуур үзүүлэлтийн нийцэл” буюу нэгдүгээр үзүүлэлтийн шинжилгээний үр дүн**

##### **4.3.1.1. Шалгуур үзүүлэлтийн “Алсын хараа-2050” бодлогын зорилготой логик уялдаа /шууд/ холбоотой эсэх**

Шалгуур үзүүлэлтийг “Алсын хараа-2050” бодлогын зорилготой шууд уялдаа холбоотой эсэхийг нягтлахдаа тухайн шалгуур үзүүлэлтийн томьёолол дах гол түлхүүр үгийг ашиглан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгээс хайлт хийж, дор хаяж нэг илэрц гарч ирсэн бол уг шалгуур үзүүлэлтийг “Алсын хараа-2050” бодлогын зорилготой уялдаатай буюу тийм, харин ямар нэгэн илэрц гарч ирэхгүй бол уг шалгуур үзүүлэлтийг “Алсын хараа-2050” бодлогын зорилгын томьёололд тусаагүй гэж үзэн уялдаагүй буюу үгүй хэмээн гэж хэмжилт хийсэн. 2020 оны 5 дугаар сарын 13-ын өдөр Монгол Улсын УИХ-ын 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” бодлогын баримт бичгийг гурван хавсралттай баталсан. Эдгээр хавсралтын нэгдүгээр хавсралт нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг агуулсан бол хоёрдугаар хавсралт нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг, гуравдугаар хавсралт нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт, шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-г тус тус тусгасан. Харин энэ судалгаанд зөвхөн нэгдүгээр хавсралтаар баталсан баримт бичгийг эх сурвалж болгон ашигласан ба дараах алхмуудыг баримтлан ажилласан.

1. Шалгуур үзүүлэлтийн үндсэн агуулга буюу нэр томьёо, ойлголтуудыг тодорхойлно. Үндсэн агуулга буюу нэр томьёо нь ойролцоо утгатай үгээр илэрхийлэгдэж болох учраас түлхүүр үгийг ашиглана. Жишээлбэл: “5.1.1 Хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байх, эрх тэгш байдлыг цогцлоох, хангах, үнэлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн эсэх” гэх шалгуур үзүүлэлтээс “хүйсээр ялгаварлах”, “гадуурхах”, “эрх тэгш байдал”, “жендэр”, “хүйсийн харьцаа”, гэх мэт ойролцоо утгатай түлхүүр үгүүдийг тодорхойлохдоо тухайн шалгуур үзүүлэлтийн гол хэмжих гэж байгаа “эрх зүйн орчин бүрдсэн эсэх” ойлголтыг орхигдуулж болохгүй.
2. “Алсын хараа-2050” бодлогын баримт бичиг буй холбоос /Эрх зүйн акт дэлгэрэнгүй (legalinfo.mn)/-ыг нээнэ.
3. Эхний алхмаар гаргасан түлхүүр үгүүдээр нэг бүрчлэн “Алсын хараа-2050” бодлогын баримт бичгээс хайлт хийнэ.
4. Хэрэв холбогдох түлхүүр үгүүдээр хайлт хийхэд хайлтын үр дүн хоосон буюу

ямар ч текст гарч ирэхгүй бол тухайн шалгуур үзүүлэлтийг тус бодлогын баримт бичигт тусаагүй гэж үзээд ҮГҮЙ буюу “2” гэсэн утга өгнө.

5. Хэрэв хайлтын үр дүн хоосон биш ямар нэгэн текст гарч ирвэл тухайн гарч ирсэн үр дүн бүрийн агуулгыг нягтална. Тухайлбал, дээрх түлхүүр үгүүдийн ихэнх нь үр дүн гарахгүй. Харин “эрх тэгш” түлхүүр үгээр хайхад хоёр хайлтын үр дүн гарна. Үүнд нэгдүгээрт, “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших ЭРХ ТЭГШ боломж бүрдүүлж”, хоёрдугаарт “чанартай боловсрол эзэмших ЭРХ ТЭГШ боломж бүрдүүлнэ” үр дүн гарч ирнэ. Хэдийгээр эрх тэгш гэсэн утга олдож байгаа боловч шалгуур үзүүлэлтийн агуулга нь хүйсийн эрх тэгш байдлын тухай хөндөж байхад хайлтын үр дүнд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломжийн тухай гарч ирсэн учраас тухайн шалгуур үзүүлэлтийг тус бодлогын баримт бичигт тусаагүй гэж үзээд ҮГҮЙ буюу “2” гэсэн утга өгнө.

Түүнээс гадна “эрх зүйн орчин бүрдсэн эсэх”-тэй холбоотой агуулгаар хайлт хийхэд дараах 5 үр дүн гарч ирнэ.

- a. Даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах хууль, эрх зүйн орчин бүрдэж
- b. Цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж,
- c. Шударга ёсыг бэхжүүлэх бодлогын болон хууль, эрх зүйн орчин бүрдэнэ.
- d. Салбарын инновацын үйл ажиллагааг дэмжих хууль, эрх зүйн орчин бүрдсэн
- e. Олон улсын найрсаг харилцааны эрх зүйн орчин бүрдүүлэх

Эдгээр хайлтын үр дүн мөн дээрхтэй адил хүйсээр ялгаварлахгүй, хүйсийн эрх тэгш байдалтай холбоотой эрхзүйн орчны тухай ойлголтыг агуулаагүй хэмээн үзэж тухайн шалгуур үзүүлэлтийг тус бодлогын баримт бичигт тусаагүй гэж үзээд ҮГҮЙ буюу “2” гэсэн утга өгнө.

Алхам 4-6-гийн үр дүнд дор хаяж нэг ширхэг тухайн түлхүүр үгийг багтаасан хайлтын үр дүн гарч ирээд, тухайн шалгуур үзүүлэлтийн агуулгыг бүрэн илэрхийлсэн ойлголт гарч ирвэл тухайн шалгуур үзүүлэлт тус бодлогын баримт бичигт туссан гэж үзээд ТИЙМ буюу “1” гэсэн утга өгнө. Тухайлбал: “1.1.1. Ядуурлын олон улсын түвшнээс доогуур амьдралтай хүн амын эзлэх хувь” гэх шалгуур үзүүлэлтийн хувьд гол түлхүүр үг нь “ядуурлын түвшин”, харин түлхүүр үгээр хайлт хийхэд “3.Бүтээмжтэй, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдлыг хөхиүлэн дэмжиж, ЯДУУРЛЫН ТҮВШИН буурч, нийгмийн дундаж давхарга өргөжсөн байна” хэмээсэн нэг л хайлтын үр дүн гарч ирнэ. Энэхүү хайлтын үр дүн нь тухайн шалгуур үзүүлэлтийн агуулгыг бүрэн илэрхийлсэн байна хэмээн үзэж ТИЙМ буюу “1” гэсэн утга өгсөн.

НҮБ-аас боловсруулсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлт нь “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигтэй хэрхэн уялдаж байгааг үнэлэх зорилгоор энэхүү үзүүлэлтээр хэмжилт хийхэд Хүснэгт 26-д харуулсан үр дүн гарлаа.

**Хүснэгт 26. ТХЗ-ын Монгол Улсад тооцож байгаа шалгуур үзүүлэлтийн “Алсын хараа-2050” бодлогын зорилготой логик уялдаа /шууд/ холбоотой эсэхийг тодорхойлсон байдал**

	ШҮ-ийн Монгол Улс дахь төлөв байдал /Тооцож байгаа - 1, Тооцохгүй байгаа - 2, Хамааралгүй - 3/					
	Тооцож байгаа	Тооцож байгаа: орлуулсан	Тооцохгүй байгаа	Хамааралгүй	(blank)	Нийт
1 – Тийм	94		1			<b>95</b>
2 – Үгүй	37	1				<b>37</b>
(blank)			102	13		<b>116</b>
Нийт	<b>131</b>	<b>1</b>	<b>103</b>	<b>13</b>		<b>248</b>

Эх сурвалж: Судалгааны баг

ҮСХ-ноос гаргасан эх сурвалжид дурдсан 132 тооцож байгаа шалгуур үзүүлэлтийн 37 шалгуур үзүүлэлтийг буюу 28 хувийг<sup>35</sup> нь “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигтэй шууд уялдаа холбоогүй гэж тодорхойлсон. Гэтэл нийт 95 шалгуур үзүүлэлтийг тус бодлогын баримт бичигтэй холбоотой гэж үзсэнээс “9.b.1 ДНБ-д дунд болон өндөр технологийн үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь” гэх шалгуур үзүүлэлт нь Монгол Улсад мэдээллийн эх үүсвэр нь тодорхойгүй гэсэн үндэслэлээр тооцохгүй байгаа гэсэн ангилалд хамааруулсан боловч уг шалгуур үзүүлэлтийн тооцох аргачлалыг нь ҮСХ-ноос гаргасан шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлал баримт бичигт оруулсан байна. Эндээс дүгнэж үзвэл НҮБ-аас боловсруулж гаргасан нийт 248 шалгуур үзүүлэлтийн 132-ийг нь Монгол Улсад тооцож байгаа боловч үүний 95 шалгуур үзүүлэлт буюу 38.3%<sup>36</sup> нь “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигтэй шууд уялдаа холбоотой байна.

**4.3.1.2. Шалгуур үзүүлэлтийн төрөл**

ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг төрлөөр нь авч үзвэл Монгол Улсад тооцож байгаа 132 шалгуур үзүүлэлтээс 88 шалгуур үзүүлэлт буюу 66.7% нь тоон, 44 шалгуур үзүүлэлт 33.3% нь чанарын шалгуур үзүүлэлт байна (Хүснэгт 27-оос харна уу).

35 Шууд холбоогүй гэж тоологдсон 37 үзүүлэлтийг Монгол Улсад тооцож байгаа 132 шалгуур үзүүлэлтэд харьцуулж, хувиар илэрхийлсэн.

36 Монгол Улсын “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигтэй шууд уялдаа холбоотой гэж тооцогдсон 95 үзүүлэлтийг НҮБ-аас гаргасан 248 шалгуур үзүүлэлтэд харьцуулж хувиар илэрхийлсэн.

## Хүснэгт 27. Шалгуур үзүүлэлтийн төрөл

/2022.06.09/	ШҮ-ийн Монгол Улс дахь төлөв байдал /Тооцож байгаа - 1, Тооцохгүй байгаа - 2, Хамааралгүй - 3/					
Шалгуур үзүүлэлтийн төрөл	Тооцож байгаа	Тооцож байгаа: орлуулсан	Тооцохгүй байгаа	Хамааралгүй	(blank)	Нийт
1 – Тоон	120	1	1			<b>122</b>
2 - Чанар	11					<b>11</b>
(blank)			102	13		<b>115</b>
Нийт	<b>131</b>	<b>1</b>	<b>103</b>	<b>13</b>		<b>248</b>

Эх сурвалж: Судалгааны баг

Хэдийгээр НҮБ-аас гаргасан шалгуур үзүүлэлтийн томъёолол /нэр/ болон хэмжих нэгж нь тоон утгаар илэрхийлэгдэж байгаа боловч Монгол Улсын хувьд зарим шалгуур үзүүлэлтийн өгөгдлийг чанарын утгаар илэрхийлэхээр байвал тухайн шалгуур үзүүлэлтийг чанарын төрөлд хамааруулсан. Жишээлбэл: НҮБ-аас гаргасан эх сурвалжид “17.18.3 Number of countries with a national statistical plan that is fully funded and under implementation, by source of funding” гэж тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн утга нь хэдийгээр улс орнуудын тоогоор илэрхийлэгдэж байгаа боловч Монгол Улсын хувьд энэхүү шалгуур үзүүлэлтийг 17.18.3.-т заасан “Бүрэн санхүүжилттэй, хэрэгжилтийн шатанд яваа статистикийн үндэсний хөтөлбөртэй эсэх (тийм-1, үгүй-2)” гэж тодорхойлсон бөгөөд манай улсын хувьд уг шалгуур үзүүлэлтийн утгыг тоогоор биш “тийм” “үгүй” (тоон биш утга) гэсэн чанарын утгаар хэмжилт хийж тодорхойлж байгаа учраас 17.18.3 заасан шалгуур үзүүлэлтийг Монгол Улсын хувьд чанарын шалгуур үзүүлэлт гэж үзэн чанарын төрөлд хамааруулсан. Үүнтэй төстэй өөр нэг шалгуур үзүүлэлт бол 1.5.3-т заасан “Number of countries that adopt and implement national disaster risk reduction strategies in line with the Sendai Framework for Disaster Risk Reduction 2015–2030” гэх үзүүлэлт. Энэ үзүүлэлт нь хэдийгээр НҮБ-аас гаргасан эх сурвалжид тоогоор хэмжигдэж байгаа боловч Монгол Улсын хувьд үүнийг “1.5.3 Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд авч хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны суурь баримт бичигтэй уялдуулсан гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний стратегийг баталж, хэрэгжүүлдэг эсэх” гэж тодорхойлсон буюу утга нь “тийм” “үгүй” (тоон биш утга) гэсэн чанарын утгаар хэмжигдэж байгаа учраас уг үзүүлэлтийг чанарын шалгуур үзүүлэлт гээд чанарын төрөлд хамааруулж “2” буюу “ЧАНАР” гэсэн утга оноосон. Өөрөөр хэлбэл Монгол Улсын хувьд “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ”-ний бичиг баримтыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг боловсруулж, Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор батлан, хэрэгжүүлж байгаа

бөгөөд хэрэгжилтийн явц, үр дүнг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 2 жил тутам Засгийн газарт тайлагнахаас гадна НҮБ-ын Гамшгийн Эрсдэлийг Бууруулах Газраас гаргасан аргачлалын дагуу холбогдох тоо мэдээллийг гаргаж хүргүүлдэг (ҮСХ, 2021, хууд. 17) тул "тийм" гэсэн чанарын утгаар хэмжигдсэн ч "1" гэсэн тоон утгад шилжүүлж статистик мэдээг НҮБ-д 2016-2020 онд тасралтгүй тайлагнасан байна.

Тоон шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо утга нь хувь, километр, сая төгрөг, мг/м<sup>3</sup> гэх мэт тоогоор хэмжигдэх утга авдаг бол тухайн шалгуур үзүүлэлтийг тоон шалгуур үзүүлэлтийн төрөлд хамааруулсан. Үүний сонгодог жишээ гэвэл "2.b.1 Хөдөө аж ахуйн экспортын татаас", "11.2.1 Улаанбаатар хотод нийтийн тээврээр үйлчлүүлсэн хүн амын эзлэх хувь", "11.6.2 Хотын агаар дахь нарийн болон том ширхэглэгт тоосонцор (PM 2.5 болон PM 10)-ын жилийн дундаж хэмжээ, мг/м<sup>3</sup>", "17.3.2 ДНБ-д мөнгөн гуйвуулгын эзлэх хувь" гэх мэт.

#### 4.3.1.3. Шалгуур үзүүлэлтийн нэршлийн орчуулгын нийцтэй байдал

НҮБ-аас боловсруулсан шалгуур үзүүлэлтийн нэршил, концепц, аргачлал нь англи хэлээр боловсруулагдсан. Гэвч улс орнууд шалгуур үзүүлэлтүүдийг өөрийн оронд нутагшуулахдаа тухайн улсынхаа хэлээр хөрвүүлж байгаа ч цөөн тооны шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт оруулсан байна. Ингэснээрээ тухайн шалгуур үзүүлэлтийн концепц нь алдагдах, буруу өгөгдөл цуглуулах, хэмжилтийн алдаа үүсдэг байна. Монгол Улсын хувьд тооцож байгаа 132 ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн нэршлийг Монгол хэлнээ хөрвүүлэхэд 11 шалгуур үзүүлэлтэд зөрүү үүссэн хэмээн тодорхойллоо (Хүснэгт 28-аас харна уу). Үүний нэг нь орчуулгын агуулга нийцээгүй буюу орчуулга нь шалгуур үзүүлэлтийн үндсэн концепцыг бүрэн алдагдуулсан, харин 10 шалгуур үзүүлэлт нь орчуулгын агуулгад бага зэрэг зөрүү гарч үндсэн ойлголт нь бага зэрэг хазайсан гэж үзлээ.

#### Хүснэгт 28. Шалгуур үзүүлэлтийн орчуулгын нийцтэй байдал

/2022.06.09/	ШҮ-ийн Монгол Улс дахь төлөв байдал /Тооцож байгаа - 1, Тооцохгүй байгаа - 2, Хамааралгүй - 3/					
	Тооцож байгаа	Тооцож байгаа: орлуулсан	Тооцохгүй байгаа	Хамааралгүй	{blank}	Нийт
1 - Орчуулга агуулга бүрэн нийцсэн	120	1	1			122
2 - Орчуулгын агуулга бага зэрэг зөрүүтэй	10					10
3 - Орчуулгын агуулга нийцээгүй	1					1

(blank)			102	13		<b>115</b>
Нийт	<b>131</b>	<b>1</b>	<b>103</b>	<b>13</b>		<b>248</b>

Эх сурвалж: Судалгааны баг

Орчуулгын агуулга нийцээгүй шалгуур үзүүлэлтийг авч үзвэл НҮБ-аас гаргасан эх сурвалжид *“12.b.1 Implementation of standard accounting tools to monitor the economic and environmental aspects of tourism sustainability”* гэж томъёолсон байхад Монгол Улсын ҮСХ болон ЭЗХЯ-аас гаргасан эх сурвалжид уг үзүүлэлтийг харгалзан *“12.b.1. Тогтвортой аялал жуулчлалын стратеги эсвэл бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй эсэх (тийм-1, үгүй-2)”*, *“12.b.1. Аялал жуулчлалын тогтвортой стратеги эсвэл бодлого, хяналт үнэлгээний арга хэрэгслийн хамт хэрэгжүүлсэн үйл ажиллагааны төлөвлөгөөний тоо”* хэмээн тус тус орчуулсан нь шалгуур үзүүлэлтийн үндсэн концепцыг бүрэн алдагдуулж байна гэж үзсэн. Учир нь НҮБ-аас уг үзүүлэлтийг тодорхойлохдоо *“Аялал жуулчлалын тогтвортой байдлын эдийн засаг, байгаль орчны асуудалд хяналт тавих нягтлан бодох бүртгэлийн стандарт арга хэрэгслийн хэрэгжилт”* хэмээн тодорхойлсон байхад Монгол хэлнээ тухайн арга хэрэгслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа төлөвлөгөөний тоо эсвэл төлөвлөгөөтэй эсэх хэмээн хөрвүүлсэн нь 12.b.1-т заасан үзүүлэлтэд хэмжилтийн алдаа үүсэх гол шалтгаан болсон гэж үзэж байна. Түүнээс гадна ҮСХ-ноос гаргасан эх сурвалжид 12.b.1-д заасан үзүүлэлтийг тооцож байгаа гэх ангилалд оруулсан боловч ҮСХ-ны ТХЗ-ыг мэдээлж буй шалгуур үзүүлэлтийн тооцох аргачлалд уг үзүүлэлтийн аргачлалыг нь тодорхойлоогүй орхигдуулсан байна. Иймээс Монгол Улсын хувьд уг үзүүлэлтийн хэмжилтийн алдааг засах залруулах, утгын үнэн зөв найдвартай байдлыг хангах арга замыг эрэлхийлэх асуудал тулгарч байна. Үүнтэй төстэй өөр нэг шалгуур үзүүлэлт бол 16.7.2 гэх шалгуур үзүүлэлт бөгөөд энэ талаар бид энэхүү судалгааны 2.2 болон 2.3-т дэлгэрэнгүй авч үзэж байгаа тул энд онцолж дурдсангүй.

Харин орчуулгын агуулга бага зэрэг зөрүүтэй хэмээн үзсэн шалгуур үзүүлэлтээс авч үзвэл НҮБ-ын 2022 оны 2 дугаар сарын 04-нд вэб сайтдаа байршуулсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн эх сурвалжид 17.3.1-т заасан үзүүлэлт *“Foreign direct investment, official development assistance and South-South cooperation as a proportion of gross national income”* гэсэн нэршилтэй байсан боловч 2022 оны 6 дугаар сарын 09-нд гаргасан эх сурвалжид уг үзүүлэлтийн нэршлийг *“Additional financial resources mobilized for developing countries from multiple sources”* гэж өөрчилсөн байна. Гэтэл ҮСХ-ноос гаргасан эх сурвалжид тухайн үзүүлэлтийг орчуулахдаа *“Улсын нэгдсэн төсөвт гадаадын шууд хөрөнгө оруулалт, хөгжлийн албан ёсны тусламжийн эзлэх хувь”* хэмээн орчуулжээ. Эндээс харахад тухайн шалгуур үзүүлэлтийн нэршлийг орчуулахдаа НҮБ-ын сүүлийн нэршлийг ашиглаагүй, харин өмнөх нэрийг нь орчуулахдаа *“gross national income”* буюу *“үндэсний нийт орлого”* гэх ойлголтыг



“улсын нэгдсэн төсөв” хэмээн хөрвүүлсэн нь хэмжилтийн зөрүү үүсэж байна.

Өөр нэг шалгуур үзүүлэлтийг авч үзэхэд 10.1.1-д НҮБ “*Growth rates of household expenditure or income per capita among the bottom 40 per cent of the population and the total population*” гэж томъёолсон бол ҮСХ “Нийт хүн амын болон доогуур орлоготой 40 хувийнхны нэг хүнд ногдох дундаж орлого, зарлагын өсөлт” гэж хөрвүүлсэн нь агуулгын хувьд алдаагүй гэж харах боловч “*household expenditure or income*” буюу “*өрхийн орлого эсвэл зарлага*” гэдгийг “*нэг хүнд ногдох дундаж орлого, зарлага*” хэмээн агуулгын хувьд өөр, статистик өгөгдөл нь ч үндсэн концепцоос бага зэрэг зөрүүтэй утга илэрхийлж байна.

8.3.1-д заасан “*Proportion of informal employment in total employment, by sector and sex*” гэх үзүүлэлтийг “*Хөдөө аж ахуйн бус салбарын нийт ажиллагсдад албан бус ажил эрхлэгчдийн эзлэх хувь*” хэмээн орчуулсан нь нэршлийн хувь эрс ялгаатай. Гэхдээ НҮБ-ын шалгуур үзүүлэлтийн аргачлалд 8.3.1 үзүүлэлтийг “*agricultural*” болон “*non agricultural*” гэсэн хоёр үзүүлэлтээр салгаж үнэлэхээр аргачлал (United Nation, 2022, р. 4) боловсруулсан байна. Харин Монгол Улсын ҮСХ-ноос “*non agricultural*” буюу “ХАА-н бус” салбараар аргачлалыг нь боловсруулж (ҮСХ, 2021, хууд. 76), статистик үзүүлэлтийг тооцож гаргасан байна.

1.4.2-т заасан “*Proportion of total adult population with secure tenure rights to land, (a) with legally recognized documentation, and (b) who perceive their rights to land as secure, by sex and type of tenure*” хэмээх үзүүлэлтийг “*Насанд хүрсэн, газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхтэй, хууль ёсны гэрчилгээтэй хүн амын нийт насанд хүрэгчдэд эзлэх хувь, эзэмшлийн төрлөөр*” гэж оруулсан нь өмнөхтэй адил дотроо хоёр үзүүлэлтээр илэрхийлэгдэж байхад нэгийг нь ҮСХ-ноос боловсруулж гаргасан байна. Өөрөөр хэлбэл ҮСХ-ны аргачлалд уг шалгуур үзүүлэлтийн (b) хэсгийг “*газар эзэмших, ашиглах, өмчлөх эрх нь найдвартай гэж үздэг насанд хүрэгчдийн хувь гэсэн үзүүлэлтийг олон улсын аргачлалаар өрхөд суурилсан судалгаанаас гаргахыг зөвлөдөг боловч одоогоор гаргахгүй байна*” (ҮСХ, 2021, хууд. 14) хэмээн тайлбарласан байна. Ингэснээрээ тухайн шалгуур үзүүлэлтийг тооцож байгаа гэдэг боловч үнэн хэрэгтээ дутуу тооцож байгаа хэлбэр юм.

Гэтэл 3.d.1-д заасан “*International Health Regulations (IHR) capacity and health emergency preparedness*” гэх шалгуур үзүүлэлтийг ҮСХ-ноос гаргасан эх сурвалжид “*Олон улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэх чадавх, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн бэлэн байдал*” гэж хөрвүүлсэн орчуулгын агуулга бага зэрэг зөрүүтэй гэж үзэж байна. Учир нь “*health emergency preparedness*” буюу “яаралтай түргэн тусламжийн бэлэн байдал” гэх ойлголтыг “ноцтой үеийн бэлэн байдал” хэмээн орчуулсан нь ойлголтын хувьд зөрүү үүсгэж үзсэн. Нөгөөтэйгүүр ҮСХ-ны аргачлалд олон улсын аргачлалыг тусгасан боловч ЭМЯ нь олон улсын аргачлалаас өөр аргачлалаар статистик мэдээг гаргадаг тухай өгүүлсэн байна (ҮСХ, 2021, хууд. 40).

#### 4.3.2. “Мэдээлэл цуглуулах аргачлал” буюу хоёрдугаар үзүүлэлтийн шинжилгээний үр дүн

ТХЗ-ын Монгол Улсад тооцож байгаа шалгуур үзүүлэлтийн хэмжилтийн арга зүйд харьцуулсан тойм шинжилгээг гүйцэтгэхдээ НҮБ-ын болон Монгол Улсын боловсруулсан шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах аргачлалд ямар ялгаа үүссэнийг тодорхойлох зорилгоор дараах дэд үзүүлэлтүүдийг ашиглалаа. Үүнд

- Тооцох аргачлалын хувьд үүссэн ялгаа
- Мэдээлэл цуглуулах давтамжид үүссэн ялгаа
- Тухайн шалгуур үзүүлэлтийн статистикийг гаргаж буй байдал

Тооцох аргачлалын хувьд НҮБ-аас боловсруулсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах аргачлалыг Монгол Улсын түвшинд боловсруулсан тооцох аргачлалыг харьцуулахад нийт тооцож байгаа 132 шалгуур үзүүлэлтээс 103 шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлал нь хоорондоо ялгаагүй буюу ижил, 16 шалгуур үзүүлэлтийн тооцох аргачлалын хувьд дэд үзүүлэлтийг өөрчилсөн, 7 шалгуур үзүүлэлтийг өөр шалгуур үзүүлэлтээр орлуулсан, 3 шалгуур үзүүлэлтийн хувьд тооцох арга зүй болон дэд үзүүлэлт нь ижил боловч статистик өгөгдлөө цуглуулахдаа өөр үзүүлэлтийн өгөгдлийг ашигласан, харин 3 шалгуур үзүүлэлтийн хувьд Монгол Улсад тооцож байгаа гэсэн боловч ҮСХ-аас боловсруулсан шалгуур үзүүлэлтийн аргачлалыг нь тусгаагүй байна. Өөрөөр хэлбэл нийтдээ 132 шалгуур үзүүлэлтээс 29<sup>37</sup> (21.9%) шалгуур үзүүлэлтийн аргачлалыг НҮБ-аас гаргасан үзүүлэлтийг тооцох аргачлалаас ялгаатай байдлаар тодорхойлсон байна (Хүснэгт 29-өөс харна уу).

#### Хүснэгт 29. НҮБ болон Монгол Улсын ШҮ-ийн тооцох арга зүйн зөрүүтэй байдал

/2022.06.09/	ШҮ-ийн Монгол Улс дахь төлөв байдал /Тооцож байгаа - 1, Тооцохгүй байгаа - 2, Хамааралгүй - 3/					
	Тооцож байгаа	Тооцож байгаа: орлуулсан	Тооцохгүй байгаа	Хамааралгүй	blank	Нийт
НҮБ болон Монгол Улсын ШҮ-ийн тооцох арга зүйн зөрүүтэй байдал						
1 - Тооцох арга зүй яг тохирч байгаа	102	1	1			104
2 - Тооцох арга зүй дэх дэд үзүүлэлтийг өөрчилсөн	16					16

37 НҮБ болон Монгол Улсын ШҮ-ийн тооцох арга зүйн зөрүүтэй байдал үзүүлэлтийн 2, 3, 4, 5 гэсэн утга авсан Монгол Улсад тооцож байгаа үзүүлэлтүүдийн нийлбэр болно.  $16+7+3+3 = 29$

3 - Шалгуур үзүүлэлтийг бүхэлд өөр шалгуур үзүүлэлтээр орлуулсан	<b>7</b>					<b>7</b>
4 - Тооцох арга зүй болон дэд үзүүлэлт нь яг тохирч байгаа боловч, өгөгдлөө цуглуулахдаа зөрүүтэй байдаг	<b>3</b>					<b>3</b>
5 - Монгол Улсад тооцох аргачлалыг нь батлаагүй	<b>3</b>					<b>3</b>
(blank)			102	13		<b>115</b>
Нийт	<b>131</b>	<b>1</b>	<b>103</b>	<b>13</b>		<b>248</b>

Эх сурвалж: Судалгааны баг

Эдгээр дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлтийн дэд үзүүлэлтийг нь өөрчилсөн хэсгээс авч үзэхэд жишээ нь 16.а.1-д заасан “*Existence of independent national human rights institutions in compliance with the Paris Principles*” шалгуур үзүүлэлтийг НҮБ-аас боловсруулсан шалгуур үзүүлэлтийн агуулга нь хүний эрхийн үндэсний байгууллагуудын тухай илэрхийлж байхад Монгол Улсын аргачлалд хэд хэдэн байгууллага биш зөвхөн байгууллагатай эсэхийг “*Парисын зарчмыг мөрдлөг болгодог хүний эрхийн бие даасан байгууллагатай эсэх*” хэмээн хэмжиж байна. Бас 16.2.1-д тодорхойлсон “*Proportion of children aged 1–17 years who experienced any physical punishment and/or psychological aggression by caregivers in the past month*” шалгуур үзүүлэлтийг Монгол Улсад хэмжилт хийхдээ “*Судалгааны өмнөх 1 сард эцэг/эх/асран хамгаалагчийн зүгээс сэтгэл зүйн болон бие махбодын шийтгэл хүлээсэн 1-14 насны хүүхдийн хувь*” хэмээн насных нь бүлгийг өөрчилсөн байна. Харин 9.1.2-т боловсруулсан “*Passenger and freight volumes, by mode of transport*” шалгуур үзүүлэлтийг НҮБ-ын аргачлалд ачаа болон зорчигч эргэлтийг тээврийн төрлөөр нь тус тусад нь үнэлдэг боловч Монгол Улсад “*Зорчигч болон ачаа тээврийн хэмжээ, тээврийн төрлөөр*” гэж ижил агуулгаар тодорхойлсон ч статистик өгөгдлөө гаргахад ачаа болон зорчигч эргэлтийг нэгтгэхдээ тусгай коэффициент ашиглаж нэг нэгжид шилжүүлж тооцдог байна.

7.1.2-ын “*Proportion of population with primary reliance on clean fuels and technology*” шалгуур үзүүлэлтийг ҮСХ-аас тооцоход “*Цэвэр түлш, технологийг голчлон хэрэглэдэг хүн амын эзлэх хувь*” хэмээн томъёолж нийт хүн амд эзлэх хувиар тодорхойлохоор аргачлалд тусгасан боловч Монгол Улсын хувьд Судалгаанд хамрагдсан өрхийн хүн амын тоотой харьцуулах аргачлалыг

хэрэглэж статистик өгөгдлөө боловсруулж 16 шалгуур үзүүлэлтийн дэд хэсэгт өөрчлөлт оруулсан байна (Хавсралт 3-аас харна уу).

Харин НҮБ-аас боловсруулсан шалгуур үзүүлэлтийг бүхэлд нь өөр шалгуур үзүүлэлтээр орлуулсан 7 шалгуур үзүүлэлт байна. Тухайлбал 1.2.1-д заасан *“Proportion of population living below the national poverty line, by sex and age”* гэх үзүүлэлтийг Монгол Улсад *“Үндэсний ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай хүн амын нийт хүн амд эзлэх хувь, хүйсээр, насны бүлгээр”* хэмээн тодорхойлж ядуурлын түвшнөөс доогуур хэрэглээтэй хүн амын эзлэх хувийг ядуурлын хамралтын индекс гэдэг аргачлалаар тооцон, өрхийн нийгэм эдийн засгийн судалгаагаар дамжуулан түүвэр хийсэн байна. Өөр нэг үзүүлэлт нь 1.3.1 дэх *“Proportion of population covered by social protection floors/systems, by sex, distinguishing children, unemployed persons, older persons, persons with disabilities, pregnant women, newborns, work-injury victims and the poor and the vulnerable”* гэх үзүүлэлтийг *“Нийгмийн хамгааллын суурь хөтөлбөрт хамрагдсан хүн амын нийт хүн амд эзлэх хувь, хүйсээр, ядуурлын байдлаар, зорилтот бүлгээр (хүүхэд, ажилгүйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, жирэмсэн эх, нярай хүүхэд, ажлын байран дахь ослын хохирогчид, эмзэг бүлгийн иргэд)”* хэмээн агуулгын хувьд зөрчилгүй тодорхойлсон боловч нийгмийн хамгааллын хөтөлбөрт хамрагдаж байгаа бүртгэл ашиглахгүйгээр өрхийн нийгэм эдийн засгийн судалгаагаар нийгмийн хамгааллын хөтөлбөрт хамрагдаж байгаа иргэдийг тухайн бүлэгт эзлэх хувиар тооцон тархааж бодсоноор тухайн шалгуур үзүүлэлтийг өөр үзүүлэлтээр орлуулж байна.

11.2.1-д заасан *“Proportion of population that has convenient access to public transport, by sex, age and persons with disabilities”* үзүүлэлтийн хувьд *“Улаанбаатар хотод нийтийн тээврээр үйлчлүүлсэн хүн амын эзлэх хувь”* хэмээн ҮСХ-ноос боловсруулсан аргачлалд хөрвүүлж тайлант жилд нийтийн тээврээр үйлчлүүлсэн хүний тоог давхацсан тоогоор орлуулан тооцож байна. НҮБ-ын ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн жагсаалтад 15.a.1 болон 15.b.1<sup>38</sup> гэсэн хоёр үзүүлэлтийн нэр болон аргачлал нь хоорондоо ямар ч ялгаагүй боловсруулсан байгаа ч Монгол Улсын хувьд ҮСХ-ноос гаргасан аргачлал нь НҮБ-аас гаргасан аргачлалтай ижил боловч тооцохдоо *“Ойжуулалт, ой нөхөн сэргээлт, ойн тогтвортой менежментэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, тэрбум төг”* хэмээн өөрчилж орлуулан тооцож байна. Мөн 16.7.2-т тодорхойлсон *“Proportion of population who believe decision-making is inclusive and responsive, by sex, age, disability and population group”* үзүүлэлтийг Монгол Улсын аргачлалд *“Шийдвэр гаргалт нь хүртээмжтэй, хариуцлагатай байдагт итгэдэг хүн амын эзлэх хувь”* хэмээн нийцтэй байдлаар орчуулсан хэдий ч аргачлалын хувьд НҮБ-ын аргачлалд заасан асуулгыг нь төсөөтэй асуултаар орлуулж статистик өгөгдлийг тооцож гаргасан тул орлуулан өөрчилсөн шалгуур үзүүлэлтийн тоонд хамаарууллаа (Хавсралт 4-өөс харна уу).

38 15.b.1 (a) Official development assistance on conservation and sustainable use of biodiversity; and (b) revenue generated and finance mobilized from biodiversity-relevant economic instruments

Шалгуур үзүүлэлтийг орлуулан тооцсон өөр нэг шалтгаан нь тухайн НҮБ болон Монгол Улсаас боловсруулсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн нэр болон түүний орчуулга, аргачлал нь хоорондоо нийцэж байгаа хэдий ч статистик өгөгдлөө цуглуулахдаа өөрчилж, өөр өгөгдлөөр орлуулдаг байна. Энэ шалтгаанаар **“тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт”**-д хамаарагдаж байгаа 3 үзүүлэлтийг доорх хүснэгтэд харуулав.

**Хүснэгт 30. НҮБ болон Монгол Улсын боловсруулсан шалгуур үзүүлэлтийн тооцох арга зүй болон дэд үзүүлэлт нь яг тохирч байгаа боловч, өгөгдлөө цуглуулахдаа зөрүүтэй байдаг үзүүлэлтүүд**

№	Indicator <sup>39</sup> /2022.06.09/	Шалгуур үзүүлэлт / MNG - from mail/	Тайлбар
1	1.4.2 Proportion of total adult population with secure tenure rights to land, (a) with legally recognized documentation, and (b) who perceive their rights to land as secure, by sex and type of tenure	1.4.2 Насанд хүрсэн, газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхтэй, хууль ёсны гэрчилгээтэй хүн амын нийт насанд хүрэгчдэд эзлэх хувь, эзэмшлийн төрлөөр	Газар эзэмших, ашиглах, өмчлөх эрх нь найдвартай гэж үздэг насанд хүрэгчдийн хувь гэсэн үзүүлэлтийг олон улсын аргачлалаар өрхөд суурилсан судалгаанаас гаргахыг зөвлөдөг боловч одоогоор гаргахгүй байгаа тухай ҮСХ аргачлалдаа тусгажээ.
2	1.5.2 Direct economic loss attributed to disasters in relation to global gross domestic product (GDP)	1.5.2 Гамшгийн улмаас учирсан эдийн засгийн шууд хохирлын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хувь	Гамшгийн улмаас учирсан эдийн засгийн шууд хохирлын хэмжээг тооцохдоо НҮБ-ын аргачлалд заасан салбараар ангилан тооцдоггүй, Гамшгийн зэрэглэл тогтоох журмаар нарийвчлан тооцдог байна.
3	8.3.1 Proportion of informal employment in total employment, by sector and sex	8.3.1 Хөдөө аж ахуйн бус салбарын нийт ажиллагсад албан бус ажил эрхлэгчдийн эзлэх хувь	НҮБ-ын аргачлалаар ХАА болон ХАА бус гэж хоёр салгаж тооцдог боловч Монгол Улсын хувьд зөвхөн ХАА бус салбараар нь тооцох аргачлал боловсруулж, тооцож байна.

Эх сурвалж: Судалгааны баг

Үндсэндээ хүснэгт 25-д харуулсан эдгээр 29 шалгуур үзүүлэлт бол НҮБ-ын боловсруулсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг Монгол Улсад дутуу байгаа шалгуур үзүүлэлт хэмээн үзэх шалтгаан юм.

39 НҮБ-аас 2022 оны 6 дугаар сарын 09-ний өдөр өөрийн вэб хуудсандаа байршуулсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлт.

Мэдээлэл цуглуулах аргачлалын өөр нэг бүрэлдэхүүн хэсэг бол шалгуур үзүүлэлтийн давтамж юм. Давтамж гэдэг нь хэмжилт хийх аргачлалаар дамжуулан тодорхой заасан хугацаан (интервал)-д тухайн шалгуур үзүүлэлтийн утгыг тодорхойлох давталтын тоог хэлнэ. Давтамжийг НҮБ-ын болон Монгол Улсын гаргасан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн аргачлал гэх баримт бичигт дурдсанаар агуулгын шинжилгээ хийхэд 13 янзын хэмжилтийн утга тодорхойлогдсоныг 0-12 тоогоор кодоллоо. Тухайлбал шалгуур үзүүлэлтийн давтамж нь тасралтгүй буюу continuous хэмээн тодорхойлсон бол 0, нэг жилд 12 удаагийн давтамжтай бол 1, нэг жилд 4 удаагийн давтамжтайгаар мэдээлэл гаргадаг бол 2 гэх мэт кодолсныг Хүснэгт 31-ээс дэлгэрэнгүй харж болно.

### Хүснэгт 31. НҮБ-ын болон Монгол Улсын аргачлалаар мэдээлэл цуглуулах давтамжийн харьцуулалт

/2022.06.09/	Монгол Улсын аргачлалаар мэдээлэл цуглуулах давтамж														
	0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	blank	НИЙТ
0					9										9
1				1				1							2
2				1											1
3				2	1			2							5
4		9		41	2			8					3	2	65
5				1	3			4					3		11
6				2											2
7				1											1
8															
9					3	2									5
10					1			1							2
11					2			1							3
12					15	2		1	2				5		25
blank														117	117
НИЙТ		9		1	80	8		2	18				11	119	248

Эх сурвалж: Судалгааны баг

Тайлбар: 0 – тасралтгүй, 1 - 1 жилд 12 удаа, 2 - 1 жилд дөрвөн удаа, 3 - 1 жилд хоёр удаа, 4 - 1 жилд нэг удаа, 5 - 2 жилд нэг удаа, 6 - 3 жилд нэг удаа, 7 - 4 жилд нэг удаа, 8 - 5 жилд нэг удаа, 9 - тухай бүрд мэдээлэл цуглуулах боломжтой, 10- тухайн улсын шийдвэрлэснээр, ихэнхдээ жил болон жилээс бага давтамжтай, 11- тухайн улсын шийдвэрлэснээр, ихэнхдээ жилээс дээш давтамжтай, 12- тодорхойгүй

Мэдээлэл цуглуулах давтамжаас харахад НҮБ болон Монгол Улс нь давтамжийн тухай аргачлалд тусгасан байдлаар авч үзвэл нийт 248 шалгуур үзүүлэлтээс 129 нь давтамжийг тодорхойлсон тойм шинжилгээгээр гаргасан байна. Үүнээс 48.8% [=63/129\*100] буюу 63 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамж нь жилд 1 удаа болон түүнээс бага хугацаатай байна.

Харин 25 шалгуур үзүүлэлтийн хувьд мэдээлэл цуглуулах давтамж нь 1-ээс дээш 5 жилийн хооронд ядаж нэг удаа мэдээлэл цуглуулдаг бол 10 шалгуур үзүүлэлтийн хувьд НҮБ-аас гаргасан аргачлалд тухайн улсын шийдвэрлэснээр янз бүрийн хугацаанд мэдээлэл цуглуулж байхаар тодорхойлсон байна. Харин 20 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамжийг НҮБ-ын аргачлалаар тодорхойгүй байдлаар томъёолсон байхад Монгол Улсын аргачлалаар 1-5 жилийн хугацаанд давтамжтай байхаар тодорхой болгож өгсөн бол 6 шалгуур үзүүлэлтийн хувьд олон улсын аргачлалаар 1-2 жилийн хугацаанд давтамжтай байхаар заасан боловч Монгол Улсын аргачлалд давтамжийг нь тодорхойгүй байдлаар томъёолсон байна. Үлдсэн 5 шалгуур үзүүлэлтийн хувьд олон улсад ч Монгол Улсын хувьд ч мэдээлэл цуглуулах аргачлалдаа давтамжийг нь тодорхойгүй гэж үзсэн байна.

#### **4.3.3. “Шалгуур үзүүлэлтийн өгөгдөл/утга” буюу гуравдугаар үзүүлэлтийн шинжилгээний үр дүн**

НҮБ-ын боловсруулсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн нэг онцлог нь нэг шалгуур үзүүлэлтийн ард хэд хэдэн дэд шалгуур үзүүлэлтийг давхар агуулсан байдаг. Жишээлбэл 8.5.2-т заасан “*Unemployment rate, by sex, age and persons with disabilities*” буюу ажилгүйдлийн түвшин гэх шалгуур үзүүлэлт хэдийгээр хувиар илэрхийлэгдсэн боловч *нас, хүйс, хөгжлийн бэрхшээлтэй* гэсэн зорилтот 3 бүлгээр нь ангилж гаргаснаар хэд хэдэн шалгуур үзүүлэлтүүдийг давхар агуулж байгаа юм. Энэ утгаараа ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг үндсэн шалгуур үзүүлэлт, дэд шалгуур үзүүлэлт хэмээн хоёр ялгаатай авч үзэх нь тухайн үзүүлэлтийг бүрэн тооцож байгаа эсэхийг тодорхойлох гол хэмжүүр болж байна. Магадгүй, Монгол Улсын хувьд үндсэн шалгуур үзүүлэлтийг тооцохгүйгээр зөвхөн дэд үзүүлэлтийг тооцох тохиолдол цөөнгүй гарч байна. Тухайлбал 2.5.1-т заасан “*Number of (a) plant and (b) animal genetic resources for food and agriculture secured in either medium- or long-term conservation facilities*” гэх шалгуур үзүүлэлтийг Монгол Улсын хувьд тооцохдоо “*Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр дунд болон урт хугацаанд ашиглахаар зориулалтын байгууламжид хадгалсан ургамал, амьтны генетикийн нөөцийн тоо*” хэмээн тодорхойлж үндсэн үзүүлэлтийн 2016-2020 оны статистик утгыг гаргаагүй ч *ургамлын болон амьтны генетикийн нөөцийн тоо* гэсэн хоёр дэд үзүүлэлтийг ХХААХҮЯ-ын мэдээллээр гаргаж байна (Хүснэгт 32-оос харна уу). Энд утга гэдэг нь тухайн шалгуур үзүүлэлтийн хэмжилтийн үр дүнд бий болсон өгөгдөл юм. Заримдаа Монгол Улсын тухайн шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах арга, түүвэр болон тооцох арга нь НҮБ-ынхээс ялгаатай боловч хэмжилтийн үр дүнд Монгол Улс үндсэн болон дэд үзүүлэлт тус бүрээр статистик өгөгдлийн сан үүсгэж, НҮБ-д мэдээлдэг байна.

### Хүснэгт 32. Үндсэн болон дэд шалгуур үзүүлэлтийн 2016-2020 оны статистик утгыг боловсруулсан байдал

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2020	Хариуцсан байгууллага	Эх үүсвэр
2.5.1 Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр дунд болон урт хугацаанд ашиглахаар зориулалтын байгууламжид хадгалсан ургамал, амьтны генетикийн нөөцийн тоо	-	-	-	-	-	-	ХХААХҮЯ	ХХААХҮЯ-ны мэдээлэл
Ургамлын генетик нөөц, мян.ш	20.6	21.9	22.1	21.5	21.50	14.8		
Амьтны генетик нөөц, мян.ш	55.7	65.6	57.4	53.6	64.80	61.5		

Эх сурвалж: {УСХ, Тогтвортой хөгжлийн зорилгын мэдээллийн бэлэн байдал, 2021}

Иймээс үндсэн болон дэд үзүүлэлтийн өгөгдлийг 2016-2020 оны байдлаар тооцож гаргасан байдлаар нь 8 хувааж авч үзсэн. Жишээлбэл 2016-2020 оны бүх өгөгдлийг бүрэн тооцсон бол 1, зөвхөн сүүлийн 5 жил буюу 2017-2020 оны өгөгдлийг тооцсон бол 2 гэх мэтээр хувааж авч үзсэн болно (Хүснэгт 33-ын тайлбараас харна уу).

### Хүснэгт 33. ШҮ-ийн утгыг 2016-2020 онд тооцсон байдал

Count of Indicator /2022.06.09/	ШҮ-ийн Монгол Улс дахь төлөв байдал /Тооцож байгаа - 1, Тооцохгүй байгаа - 2, Хамааралгүй - 3/						
	ШҮ-ийг тооцсон байдал	Тооцож байгаа	Тооцож байгаа: орлуулсан	Тооцохгүй байгаа	Хамааралгүй	blank	НИЙТ
1	74		1				75
2	3						3
3	3						3
4	1						1
5	1						1
6	1						1
7	21						21



8	27		1			28
(blank)			102	13		115
НИЙТ	131	1	103	13		248

Эх сурвалж: Судалгааны баг

Тайлбар: 1 - ШҮ-ийг бүрэн тооцсон, 2 - ШҮ-ийг зөвхөн сүүлийн 5 жил тооцсон, 3 - ШҮ-ийг зөвхөн сүүлийн 4 жил тооцсон, 4 - ШҮ-ийг зөвхөн сүүлийн 3 жил тооцсон, 5 - ШҮ-ийг зөвхөн сүүлийн 2 жил тооцсон, 6 - ШҮ-ийг зөвхөн сүүлийн 1 жил тооцсон, 7 - ШҮ-ийг дараалсан биш, 1 болон түүнээс дээш удаа тооцсон, 8 - ШҮ-ийг огт тооцоогүй

Үндсэн үзүүлэлтийн утгыг тооцож байгаа байдлаас харвал 82 шалгуур үзүүлэлт 1 жилээс бага давтамжтай тооцогдож байгаа бол зөвхөн сүүлийн нэг болон хоёр жил тооцогдсон 2 шалгуур үзүүлэлт, тодорхой давтамж нь мэдэгдэхгүй боловч ядаж 1 болон түүнээс дээш удаа тооцогдсон 21 шалгуур үзүүлэлт, сүүлийн жилд огт тооцогдоогүй 27 шалгуур үзүүлэлт тус тус байгаа нь дутуу байгаа шалгуур үзүүлэлтийн тоонд хамаарах эрсдэлтэй шалгуур үзүүлэлтийн эзлэх хувь 36.3% (=48/132) байна. Учир нь тооцож байсан шалгуур үзүүлэлтийг үргэлжлүүлэн тооцохгүй орхих эрсдэл харагдаж байна.

#### Хүснэгт 34. ШҮ нь дэд үзүүлэлттэй эсэх

Count of Indicator /2022.06.09/	ШҮ-ийн Монгол Улс дахь төлөв байдал /Тооцож байгаа - 1, Тооцохгүй байгаа - 2, Хамааралгүй - 3/					
ШҮ нь дэд үзүүлэлттэй эсэх	Тооцож байгаа	Тооцож байгаа: орлуулсан	Тооцохгүй байгаа	Хамааралгүй	(blank)	НИЙТ
1	50					50
2	81	1	1			83
(blank)			102	13		115
НИЙТ	131	1	103	13		248

Эх сурвалж: Судалгааны баг

Тооцож байгаа нийт 132 шалгуур үзүүлэлтийн 50 үндсэн шалгуур үзүүлэлт нь дэд үзүүлэлттэй бөгөөд 83 шалгуур үзүүлэлт нь дэд үзүүлэлтгүй байна (Хүснэгт 22-оос харна уу). Энд ҮСХ-ноос боловсруулсан ТХЗ-ын мэдээллийн бэлэн байдлын тайланд тооцохгүй болон Монгол Улсад хамааралгүй хэмээн тодорхойлсон харгалзан 102, 13 шалгуур үзүүлэлтийн хувьд дэд үзүүлэлттэй эсэхийг тодорхойлоогүй болно (ҮСХ, Тогтвортой хөгжлийн зорилгын мэдээллийн бэлэн байдал, 2021).

Харин дэд үзүүлэлттэй 50 шалгуур үзүүлэлтийн 17 шалгуур үзүүлэлтийн хувьд дэд үзүүлэлтийн 2016-2020 оны статистик өгөгдлийг бүрэн тооцсон, 6 үндсэн үзүүлэлтийн хувьд дэд үзүүлэлтийн өгөгдлийг сүүлийн 3 жил тооцсон

бол тодорхой давтамж нь мэдэгдэхгүй боловч мөн хугацаанд ядаж 1 болон түүнээс дээш удаа тооцогдсон 14 үндсэн үзүүлэлтийн дэд үзүүлэлт, 2016-2020 оны хугацаанд огт тооцогдоогүй 13 үндсэн үзүүлэлтийн дэд үзүүлэлт тус тус байгаа нь дэд үзүүлэлт нь дутуу тооцогдох эрсдэлтэй үндсэн шалгуур үзүүлэлтийн эзлэх хувь 54.0% (=27/50) байна (Хүснэгт 35-аас харна уу).

### Хүснэгт 35. Дэд ШҮ-ийн утгыг 2016-2020 онд тооцсон байдал

/2022.06.09/	ШҮ-ийн Монгол Улс дахь төлөв байдал /Тооцож байгаа - 1, Тооцохгүй байгаа - 2, Хамааралгүй - 3/					
	Тооцож байгаа	Тооцож байгаа: орлуулсан	Тооцохгүй байгаа	Хамааралгүй	(blank)	НИЙТ
1	17					17
4	6					6
7	14					14
8	13					13
(blank)	80	1	103	13		198
НИЙТ	131	1	103	13		248

Эх сурвалж: Судалгааны баг

Тайлбар: 1 - ШҮ-ийн дэд үзүүлэлтийг бүрэн тооцсон, 2 - ШҮ-ийн дэд үзүүлэлтийг зөвхөн сүүлийн 5 жил тооцсон, 3 - ШҮ-ийн дэд үзүүлэлтийг зөвхөн сүүлийн 4 жил тооцсон, 4 - ШҮ-ийн дэд үзүүлэлтийг зөвхөн сүүлийн 3 жил тооцсон, 5 - ШҮ-ийн дэд үзүүлэлтийг зөвхөн сүүлийн 2 жил тооцсон, 6 - ШҮ-ийн дэд үзүүлэлтийг зөвхөн сүүлийн 1 жил тооцсон, 7 - ШҮ-ийг дэд үзүүлэлтийг дараалсан биш, 1 болон түүнээс дээш удаа тооцсон, 8 - ШҮ-ийг дэд үзүүлэлтийг огт тооцоогүй

Энэ бүгдээс нэгтгэж үзэхэд Монгол Улсын хувьд НҮБ-аас боловсруулж гаргасан нийт 248 шалгуур үзүүлэлт байгаагаас 132 шалгуур үзүүлэлтийг тооцож байгаа хэмээн ҮСХ-ноос гаргасан 2021 оны ТХЗ-ын мэдээллийн бэлэн байдлын тайланд дурдсан боловч ҮСХ-ноос боловсруулсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн аргачлалд 9.b.1<sup>40</sup> буюу “Боловсруулах салбарын нийт нэмэгдэл өртөгт дунд болон өндөр технологийн үйлдвэрийн нэмэгдэл өртгийн эзлэх хувь” гэх Монгол Улсад тооцохгүй байгаа шалгуур үзүүлэлтийн аргачлалыг НҮБ-ын аргачлалтай ижил боловсруулсан байна. Үүнээс үүдэн Монгол Улсад тооцож байгаа 132 шалгуур үзүүлэлт, тооцохгүй байгаа 1 шалгуур үзүүлэлтийн хэмжилтийн арга зүйг харьцуулсан байна.

Шалгуур үзүүлэлтийн хэмжилтийн арга зүйг харьцуулсан нийт 133 шалгуур үзүүлэлтээс 100 шалгуур үзүүлэлт нь НҮБ-ын ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн орчуулгын агуулга бүрэн нийцсэн болон тооцох арга зүйн олон улсын аргачлалтай тохирч байгаа бол үлдсэн 33 шалгуур үзүүлэлтийн олон улсын

40 9.b.1 Proportion of medium and high-tech industry value added in total value added. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хувьд Монгол Улсын аргачлал нь НҮБ-ын аргачлалтай ижил боловсруулагдсан боловч Монгол Улсын хувьд уг үзүүлэлтийг тооцохгүй байгаа гэдэг ангилалд оруулсан байна.

тооцох аргачлалаас зөрүүтэй болон орчуулгын агуулга нь зөрүүтэй байна (Хүснэгт 36-аас харна уу). Өөрөөр хэлбэл, Монгол Улсад 133-аас **"тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт"** нь 33 буюу 24.8% (=33/133) байна.

### Хүснэгт 36. НҮБ болон Монгол Улсын ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн зөрүүтэй байдал

Count of Indicator /2022.06.09/	НҮБ болон Монгол Улсын ШҮ-ийн тооцох арга зүйн зөрүүтэй байдал						
	1	2	3	4	5	(blank)	Нийт
ШҮ-ийн нэрний орчуулгын нийцтэй байдал							
1 - Орчуулга агуулга бүрэн нийцсэн	100	14	5	1	2		122
2 - Орчуулгын агуулга бага зэрэг зөрүүтэй	4	2	2	2			10
3 - Орчуулгын агуулга нийцээгүй					1		1
(blank)						115	115
Нийт	104	16	7	3	3	115	248

Эх сурвалж: Судалгааны баг

Тайлбар: **Тооцох арга зүйн зөрүүтэй байдал:** 1 - Тооцох арга зүй яг тохирч байгаа, 2 - Тооцох арга зүй дэх дэд үзүүлэлтийг өөрчилсөн, 3 - Шалгуур үзүүлэлтийг бүхэлд нь өөр шалгуур үзүүлэлтээр орлуулсан, 4 - Тооцох арга зүй болон дэд үзүүлэлт нь яг тохирч байгаа боловч, өгөгдлөө цуглуулахдаа зөрүүтэй байдаг, 5 - Монгол Улсад тооцох аргачлалыг нь батлаагүй.

**"Тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт"**-ийн ангилалд багтах 33 шалгуур үзүүлэлтийн 3 шалгуур үзүүлэлтийн аргачлалыг нь Монгол Улсын ҮСХ-ноос гаргасан аргачлалд тусгаагүй орхигдуулсан байна. ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн нэрийг Монгол хэлнээ хөрвүүлэхдээ агуулга бага зэрэг зөрүүтэй хэмээн үзсэн 4 шалгуур үзүүлэлт байгаа бөгөөд тооцох аргачлалын хувьд НҮБ-ын аргачлалтай яг тохирч байгаа болно. Үлдсэн 26 шалгуур үзүүлэлт нь тооцох аргачлалын хувьд олон улсын аргачлалаас зөрүүтэй гэж үзсэн байгаагийн шалтгааныг арилгах нь ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг Монгол улсад олон улсын аргачлалын дагуу нийцүүлэн хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн бодлогын түвшний чухал асуудал юм (Хавсралт 5-аас харна уу).

# ТАВДУГААР БҮЛЭГ. ДЭЛХИЙН ТХЗ-ЫН МОНГОЛ УЛСАД ТООЦОХГҮЙ БАЙГАА ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ШАЛТГААНЫГ ТОДОРХОЙЛОХ СУРВАЛЖИЛГЫН АРГААР ХИЙСЭН СУДАЛГАА

## 5.1 Ерөнхий тойм

Энэ судалгаанд НҮБ-аас тодорхойлсон Түвшин 1, Түвшин 2-т хамаарч буй ч Монгол Улсад тооцохгүй байгаа 102 шалгуур үзүүлэлтийн шалтгааныг тодорхойлох зорилгоор төрийн яам, агентлаг, иргэний нийгмийн байгууллагуудад хамаарч буй /ЭЗХЯ, ҮСХ-ноос тодорхойлсноор/ ТХЗ-ын тухай 14 байгууллагын 20 респонденттай холбогдож, зарим тохиолдолд утсаар, бичгээр, ярилцлагаар хийж, шаардлагатай мэдээллийг олж авахыг зорьсон. Эцэст нь бүх мэдээллийг буулган текстэн хэлбэрт оруулан утгын шинжилгээ хийсэн (жишээг Хавсралт 8-с харна уу).

Монгол Улсад тооцох боломжгүй ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүд буурахгүй байгаа шалтгааныг тодруулахын тулд дараах гурван чиглэлийн хүрээнд бүтэцлэгдсэн асуулт бүхий сурвалжилгыг оролцогч нартай хийсэн. Үүнд:

*Нэгдүгээрт*, эдгээр тооцоогүй байгаа шалгуур үзүүлэлтийг хариуцаж буй байгууллагад хамаарах ТХЗ-2030-ын шалгуур үзүүлэлтийн ойлголтын тухай тодруулж асуух,

*Хоёрдугаарт*, ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг тооцоход тухайн байгууллагад тулгарч буй хүндрэл бэрхшээл /тооцохгүй байгаа шалтгааныг тооч гэсэн шууд утгаар бус тооцож болохгүй байгаа хүндрэл бэрхшээл гэдэг өнцгөөс яриулсан/,

*Гуравдугаарт*, хариуцсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг тооцон гаргах боломжийн тухайд гэсэн хүрээнд асууж тодотголоо.

Сурвалжилгын бичвэрийн утгын шинжилгээнд суурилан илэрсэн шалтгаануудыг судалгаанд хамрагдсан **14 байгууллагын** (26-29 байгууллагыг ҮСХ болон ЭЗХЯ тодорхойлсон байдаг ба эдгээр хамаарах байгууллагыг бүгдийг нь судлах цаг хугацаа, хөрөнгө мөнгөний боломж байхгүй тул) ард тоон кодоор жагсаан оруулсан (жишээг Хүснэгт 37-оос харна уу. Мөн Хавсралт 9-д нийт үр дүнг хавсаргав/.

**Хүснэгт 37. Сурвалжилгын аргаар илэрсэн тооцох боломжгүй байгаа шалгуур үзүүлэлтийн шалтгаан /14 байгууллагын хувьд/**

1	2	3	4	5	6	7
UNSD Indicator Code^	ШҮ-ийн Монгол Улс дахь төлөв байдал	Шалгуур үзүүлэлт	Үзүүлэлтийг хариуцан гаргах / ҮСХ/	ҮСХ-ноос гаргасан шалтгаан	ЭЗХЯ-наас гаргасан шалтгаан /төсөл/	Сурвалжилгын аргаар илэрсэн шалтгаан
C010202	Тооцохгүй байгаа	1.2.2. Үндэсний тодорхойлолтоор ядуурлын бүх хэлбэрт амьдарч байгаа хүн ам (эрэгтэй, эмэгтэй болон хүүхэд)-ын нийт хүн амд эзлэх хувь	ҮСХ	Туршилтаар түүвэр судалгаа хийгдсэн боловч үр дүн хэт өндөр зөрүүтэй гарсан тул нягтлах, хэлэлцэх шаардлагатай. Одоогийн байдлаар ҮСХ нь олон хэмжээст ядуурлын аргачлалаар тооцоог хийж байна.	4	2, 3, 4, 5, 6
C040102	Тооцохгүй байгаа	4.1.2 Сургууль төгсөлтийн түвшин (бага, бүрэн бус дунд, бүрэн дунд боловсролоор)	БШУЯ	Тооцооллыг сайжруулах шаардлагатай. Тооцохоор ажиллаж байна.		2,3,4,5,8
C040301	Тооцохгүй байгаа	4.3.1. Сүүлийн 12 сарын хугацаанд албан болон албан бус боловсрол, сургалтад хамрагдсан залуучуудын тухайн насны хүн амд эзлэх хувь, хүйсээр	ҮСХ	Мэдээллийн эх үүсвэр хангалтгүй.	1	2, 3, 4, 5, 6

C050c01	Тооцохгүй байгаа	5.с.1. Жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх зорилгоор төсөв хуваарилах, хянах тогтолцоотой эсэх	ЖҮХ	Тооцох боломжийг судалж байна.	4	5,6,8
C060402	Тооцохгүй байгаа	6.4.2 Усны хомсдолын түвшин: цэнгэг усны нийт нөөцөөс авч ашиглаж байгаа усны эзлэх хувь	БОАЖЯ	Мэдээллийн эх үүсвэр байхгүй.	3	2, 3, 4, 6, 8
C060601	Тооцохгүй байгаа	6.6.1 Цаг хугацааны явцад гарсан усны экосистемийн өөрчлөлт	БОАЖЯ	Мэдээллийн эх үүсвэр байхгүй.	4	2, 3, 4, 6, 8
C080802	Тооцохгүй байгаа	8.8.2. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенц, зөвлөмж болон үндэсний хууль тогтоомжид үндэслэн гарах эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон хамтын хэлэлцээртэй холбоотой хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн түвшин	ХНХЯ	Мэдээллийн эх үүсвэр тодорхойгүй.	4	1, 2, 3, 4, 5, 6

Эх сурвалж: Судалгааны баг

Тайлбар: **6-р баганын хувьд:** 1-мэдээлэл бэлэн, 2-бэлэн байгаа мэдээлэлд нэмэлт тооцоолол хийж гаргах, 3-гарах боломжтой боловч үзүүлэлтийг нарийвчлан задлах үүднээс мэдээллийн эх үүсвэрийг бий болгох, 4-мэдээллийн эх үүсвэрийг шинээр бий болгох

**7-р баганын хувьд:**

1-1.-Тухайн байгууллагад хамаарах шалгуур үзүүлэлтийн тухай мэдээлэлтэй эсэх, тооцдог эсэх -1,

2- 1.1-ТХЗ хариуцсан хүний нөөц, удирдлага зохион байгуулалт – 2,

- 3- II.2-Албажаагүй байдал – 3,  
 4 - II.3-Байгууллага хоорондын уялдаа холбоо сул – 4,  
 5- II.4-Өгөгдөл мэдээллийн шинж чанараас – 5,  
 6- II.5-Мэдээллийн арга зүйгээс -6,  
 7- II.6-Хөрөнгө санхүүгээс – 7,  
 8- III.-Шалгуур үзүүлэлтийг тооцож гаргах боломжийн тухайд - 8

## 5.2 Сурвалжилгын өгөгдлийн шинжилгээний дүн

Судалгаанд 20 оролцогчийн сурвалжилгын бичвэрийг кодлоход нэг бичвэрт дунджаар 4-6 дэд утга ялгаж тогтоосон ба нийт дээр дурдсан гурван үндсэн утгын хүрээнд, нийт 85 утгуудыг ялган ангиллыг тодорхойлов /Хүснэгт 38-аас харна уу/. Нэг асуултын хүрээнд хариулагдсан хэсгийг нэг сегмент (тухайн сегментэд завсрын тодотгосон богино асуулт мөн хамаарна) гэж үзэн тухайн сегментэд хэдэн утга илэрч буйг кодолсон. Ийнхүү 3 үндсэн утга бүхий категорийн хүрээнд нийт 8 дэд утгыг ангилсан.

### Хүснэгт 38. Сурвалжилгын өгөгдлийн шинжилгээнээс илэрсэн утга

№	Үндсэн категори	Дэд категори	Давтамж
1	Тухайн байгууллагад хамаарах ТХЗ-2030-ын шалгуур үзүүлэлтийн талаарх ойлголт	1. Тухайн байгууллагад хамаарах шалгуур үзүүлэлтийн тухай мэдээлэлтэй эсэх, тооцдог эсэх	9
2	Дутуу шалгуур үзүүлэлтийг тооцоход тулгарч буй хүндрэл	2.ТХЗ хариуцсан хүний нөөц, удирдлага, зохион байгуулалт	20
		3.Албажаагүй байдал	10
		4.Байгууллага хоорондын зохион байгуулалтын уялдаа холбоо, харилцаа сул, үл ойлголцол	14
		5.Өгөгдөл, мэдээллийн шинж чанараас шалтгаалсан	5
		6.Мэдээллийг тооцох арга зүйгээс шалтгаалсан	13
		7.Хөрөнгө санхүүжилтээс шалтгаалсан	4
3	Дутуу ШҮ-ийг тооцон гаргах боломжийн тухайд	8.Байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах	11
<b>НИЙТ</b>	<b>3</b>	<b>8</b>	<b>85</b>

Эх сурвалж: Судалгааны баг

**Эхний үндсэн категори** буюу **“Тухайн байгууллагад хамаарах ТХЗ-2030-ын шалгуур үзүүлэлтийн талаарх ойлголт”** гэсэн мэдээллийг оролцогчдоос сурвалжилж асуусан мэдээлэлд суурилан дүгнэхэд нийт 14 байгууллагын албан хаагчдаас дөрөв нь өөрийн байгууллагаас тооцож гарах үзүүлэлтийн талаар ойлголттой байсан бол үлдсэн 10 нь ямар шалгуур (давтамж 9) үзүүлэлтийн тооцооллыг гаргах ёстой гэдгээ мэдээгүй, энэ тухай ямар нэгэн ойлголтгүй байлаа.

Харин Монгол Улсад тооцохгүй байгаа ТХЗ-ын 102 тооцохгүй байгаа шалгуур үзүүлэлтийн **шалтгааныг** тодруулахдаа **“Шалгуур үзүүлэлтийг тооцоход тулгарч буй хүндрэл”** гэсэн ерөнхий категорийн хүрээнд (давтамжийн тоо 66) сурвалжлан тодорхойллоо. Үүний тулд тухайн байгууллагад ажиллаж буй шалгуур үзүүлэлтийг тооцох ажилд шууд ба шууд бусаар хамаарахуйц үүрэгт ажлыг эрхэлж буй албан хаагчдын ярилцлагад үндэслэн **зургаан үндсэн хүндрэл бэрхшээл** тулгарч байдгийг тодорхойлсныг энэ хэсэгт тусгайлан тайлбарлая.

Үүнд: **нэгдүгээрт, “ТХЗ хариуцсан хүний нөөц, удирдлага, зохион байгуулалт”** гэсэн дэд утга нь хамгийн олон давтамжтай (20) байсан.

Иймээс ч энэ дэд категорит **дөрвөн үндсэн санаа** илэрч байгаа тул тус тусад нь ялгаж, дор тайлбарлаж байна /Хүснэгт 39-өөс харна уу/.

### **Хүснэгт 39. ТХЗ хариуцсан хүний нөөц, удирдлага, зохион байгуулалт дэд утгын хүрээнд илэрсэн утга санаа**

№	Илэрсэн утга	Утгыг илэрхийлэх эшлэл	Оролцогчийн код	Тайлбар
1	Ажил үүрэгт нь ТХЗ-ыг хариуцах үүрэг тодорхойлогдсон эсэх	-“Манай хэлтсийн ахлах мэргэжилтний ажил үүрэгт ТХЗ-той холбоотой заалт байдаг -“ТХЗ-ыг хариуцсан тусгай ажилтан байхгүй”	ТБ-14  <b>ТБ-11</b>	14 ТЗБ-ын 3 байгууллагад ажил үүрэгт нь заасан. 11 байгууллагад ТХЗ-ын хариуцах ажил үүргийн хуваарилалт хийгдээгүй
2	Удирдлага ач холбогдол өгдөггүй, байгууллага дотор уялдаа холбоогүй	“Хоёр яам хоорондоо байтугай яам дотор хоорондоо учраа олохгүй байна. Ажлаа сайн мэдэхгүй байх тохиолдол байх”	(ТБ-6)	



3	Төрийн захиргааны байгууллагад аль ч түвшинд хүний нөөцийн тогтворгүй байдлаас шалтгаалсан ажлын залгамж холбоо сул	“Нөгөө талаас та нар ... яаман дээр ингээд арга зүйг нь мэддэггүй юм байна гээд сургалт явуулаад сургалаа гэж бодъё. Гэтэл тэр ажилтан нэг хоёр жилийн дараа ажлаасаа гараад дараагийнх нь хүн дахиад мэдэхгүй өнгөрдөг. Уг нь төрийн байгууллагын ажилтан төрийн цалин аваад өдрийн 8 цагаар ажиллаад хийсэн үр дүн нь төрийн өмч л байх ёстой, гэтэл тэр ажилтан ажлаасаа гарахдаа хамаг датагаа флаш дээр аваад, компьютероо цэвэрлэж хаяад гараад явчихдаг. Бодит байдал тийм”	ТБ-13	Удирдлагын болон албан хаагчдын аль аль түвшинд хүмүүс нь ойрхон солигддогоос дараагийн хүн дутуу мэдээлэлтэй
4	ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн судалгаа, тооцоог ашигладаггүй	“Шалгуур үзүүлэлтийг тооцоод бодлого гаргагчдад хэрэгтэй мэдээлэл гаргалаа ч хэн ч ашиглахгүй, бодлоготоо ч тусгадаггүй. Бид хөгжил дэвшил гараасай л гэж хийж байгаа ч хэн ч түүнийг ашигладаггүй. Чухалчилж үздэг ч үгүй”	(ТБ- 2)	

Эх сурвалж: Судалгааны баг

Хүснэгт 38-аас харахад, 14 байгууллагаас дөрвөн байгууллагад ТХЗ-ыг хариуцсан **хүний нөөц** байдаг бол бусад байгууллагад нь огт байдаггүй байна. Тухайлбал, ТБ – 5 “Манай яамны хувьд би нэгтгээд явуулдаг. Миний ажлын байрны тодорхойлолтод тогтвортой хөгжлийн зорилт гээд байдаг. Агуулгаар нь ажлын байрны тодорхойлолтод орсон байгаа” хэмээн ярьж байгаа нь дээрх гурван байгууллагад тодорхой ажилтанд ажлынх нь үүрэгт хариуцуулан өгснийг илтгэнэ.

Гэтэл зарим байгууллагад ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг тооцож гаргахад **удирдлагын зүгээс ач холбогдол өгдөггүй, байгууллага дотроо ч хоорондоо уялдаа холбоогүй ажилладаг** болохыг илтгэх зүйлсийг ярьсан. Жишээ нь, ТБ-10 “Манай хэлстийн чиг үүрэгт ТХЗ-ын үүрэг байхгүй учраас тогтмол хийгддэггүй. Тиймээс удирдлагын зүгээс ач холбогдол өгдөггүй гэж бодож байна” хэмээн ярьж байсан бол ТБ-13 дотоод уялдаа холбоогүй байдал бол бүх яамны асуудал болчихоод байгаа тухай илэрхийлж байв.

Түүнчлэн ТХЗ-ын шалгуур үзүүлэлттэй холбоотой хүний нөөц, удирдлага, зохион байгуулалтын өөр нэг асуудал нь **төрийн захиргааны эдгээр байгууллагад аль ч түвшинд хүний нөөцийн тогтворгүй байдал гол шалтгаан** болж байна гэж үзсэн. Зарим оролцогчид удирдлагын түвшин дэх хүний нөөцийн тогтворгүй асуудлыг хөндөж байсан бол зарим нь албан хаагчдын дунд ажлын байрны тогтворгүй байдлыг онцолж байв. Жишээ нь, ТБ – 5 “Нэг газраас албан бичиг ирэхэд манай хяналт шинжилгээ үнэлгээний газраас нэгтгээд явдаг боловч шалгуур үзүүлэлтийн аргачлалын талаар одоогийн удирдлагад мэдээлэл байхгүй. Мөн удирдлагууд ойр ойрхон солигддог” хэмээн тайлбарлаж байв.

Эцэст нь, “ТХЗ хариуцсан хүний нөөц, удирдлага, зохион байгуулалт”-ын тухай нэгэн оролцогчийн дүгнэснээр “**Шалгуур үзүүлэлтийг тооцоод бодлого гаргагчдад хэрэгтэй мэдээлэл гаргалаа ч хэн ч ашиглахгүй, бодлоготоо ч тусгадаггүй.** Бид хөгжил дэвшил гараасай л гэж хийж байгаа ч хэн ч түүнийг ашигладаггүй. Чухалчилж үздэг ч үгүй” (ТБ- 2) гэсэн санаа нь шалгуур үзүүлэлтийн үр дүнг бодлогын түвшинд бодлого боловсруулагчид хэрэглээнд оруулж заншаагүй нь харагдаж байна.

Үүнээс дүгнэж үзэхэд, ТХЗ-ыг тухайн хамаарах байгууллагууд тодорхой ажилтан болон албан тушаалтны үүрэг хариуцлагад багтаан, тооцооллыг гаргаж ажиллуулах, мэдээллийг цуглуулах байгууллагын дотоод уялдаа холбоог хангах зохицуулалтыг бий болговол тооцохгүй байгаа шалгуур үзүүлэлтийг бэлэн болгох нэг нөхцөл бүрдэх боломжтой гэж дүгнэж байна.

**Хоёрдугаарт**, ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг тооцоход тулгарч буй хүндрэлийн бас нэг асуудал нь ТХЗ-ын шалгуур үзүүлэлт тооцох тухай дээд түвшинд “**Албан ёсны шийдвэр гараагүйтэй холбоотой (албажаагүйтэй холбоотой)**” гэж үзжээ. Оролцогчдын үзэж байгаагаар, нэгэнт албан бичиг зохиох газраас ирээгүй тул ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн тооцоо судалгаа хийх үүргийг тэд хүлээхгүй. Энэ дэд утгад нийцэх санааг нийт оролцогчдын тал хувь нь (10) илэрхийлсэн байв. Тухайлбал, сурвалжилга өгсөн оролцогч нарын тайлбарыг дор баримтаар илэрхийлбэл:

(ТБ-1): *Тухайн ШҮ тооцох үзэл баримтлал, үндэслэл, журам, аргачлал нь, тушаал шийдвэр нь гарсан байх ёстой. Тэгвэл мэдээллийн найдвартай байдал илүү сайн болно. Уг нь ийм ийм байгууллагууд гаргавал зохистой гэж зохицуулчихвал давуу тал юм. Тооцоолол хийх эх сурвалжийг нь заагаад өгвөл давуу тал юм. ҮСХ нь энэ тоонуудыг нь жишээ нь, энэ 3 тооцоог Хүрээлэн гарга гээд шийдвэр гаргачихвал тэгээд сануулга тодорхой хугацаанд өгөөд байвал автоматаар гараад байх боломжтой.*

(ТБ-2): *Гараагүй/тооцоогүй байгаа шалгуур үзүүлэлтүүдэд бид албан бичиг явуулаагүй. Үндэсний үзүүлэлт гарч батлагдаж албажаагүй тул бид гараагүй үзүүлэлтүүдийг “тооцоо” гэж нэхэх эрх байхгүй байгаа. Харин гарчих үзүүлэлт байна гэж үзсэн үзүүлэлтүүдэд бид бичиг явуулдаг.*

(ТБ-4): 2018, 2019, 2020 оны 7 дугаар сар хүртэл энэ талаар .... Салбар дундын бодлого зохицуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн холбогдох шалгуур үзүүлэлтийг тодорхойлох ажлын хэсгийн хурал, хэлэлцүүлэг семинарт хамрагдаж саналаа өгч оролцож байсан боловч үзүүлэлтийг хэрхэн, хэзээ, хэн тооцох талаар нэгдсэн чиглэл удирдамж болон албан бичиг ирж байгаагүй.

(ТБ-7): Тооцох ёстой гэж бид нараас тоо нэхэгддэггүй. Яам учраас ҮСХ -ноос үүрэг чиглэл ирэхэд хэцүү байх, гэхдээ ЗГХЭГ-аас бидэнд үүрэг чиглэл болгоод ирүүлбэл болохгүй юм байхгүй байх гэж бодож байна.

(ТБ-10): Ер нь ҮСХ, ЭЗХЯ зэргээс ТХЗ-ын үзүүлэлтийг тооцох тухай чиглэл, зөвлөмж, албан бичиг ирүүлж байгаагүй.

(ТБ-17): Ихэнх нь зохион байгуулалттай холбоотой саад бэрхшээлүүд болон албан бичгүүд явуулж албажуулах хэрэгтэй.

Тооцохгүй байгаа шалгуур үзүүлэлтүүдтэй холбоотой нэг томоохон хүчин зүйл нь төрийн дээд түвшинд ТХЗ-ыг тооц гэсэн албан ёсны шийдвэр гараагүй, дээд түвшний байгууллага албан ёсны бичиг илгээж албажуулахгүй байна гэж дүгнэж байна. Иймд ЭЗХЯ болон ҮСХ нь ТХЗ-ын мэдээллийг бүрдүүлэх гол байгууллагын хувьд өөрсдийн түвшинд тодорхой шийдвэр гаргаж, бусад байгууллагуудтай харилцаж, ТХЗ-ыг тооцохгүй дутуу байгаа шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг нь сайжруулахад өөрсдийн түвшинд шийдэх боломж байна гэж үзэж байна.

**Гуравдугаарт,** ТХЗ-ын шалгуур үзүүлэлт тооцоход **“Байгууллага хоорондын уялдаа холбоо, харилцаа сул ба үл ойлголцол”** гэсэн утга нь хоёр дах давтамж олонтой дэд утга (14) байлаа. Хэдийгээр ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн тооцооллыг ЭЗХЯ, ҮСХ нь голлон хариуцах үүрэг хүлээсэн ч судалгаанд оролцогчдын үзсэнээр ТХЗ-ын шалгуур үзүүлэлт, мэдээллийг тооцож гаргахад статистик тоон мэдээллийн зөрүүтэй байдал болон тухайн мэдээллээр анхан шатанд тоон мэдээлэл гардаггүй зэрэг хүндрэлтэй асуудал байдаг тул төрийн байгууллагуудын хоорондын мэдээллийн түгээлт, тархаалт, мэдээлэл солилцоог хялбарчлах, уялдаа холбоо сайжруулах асуудал чухал **(ТБ-16)** ба энэ төвөгтэй үзүүлэлтийн аргачлалыг хамтдаа боловсруулах тухай санаачилга гарахгүй (ТБ-5) байгаатай холбоотой аж. Тиймээс ч зарим оролцогчид “ҮСХ тийм тийм мэдээллүүдээ өгөөч гэж албан бичиг өгөх ёстой. Тэгвэл яам хариуг нь өгөх боломжтой” (ТБ-1) ба “Гол нь үүнийг яаж тооцоолох болон салбар хоорондын уялдаа холбоо чухал (ТБ-17) болохыг тэмдэглэж байв. Тэдний хэлснээр ҮСХ, ЭЗХЯ-аас мэдээллээр хангадаггүйтэй холбоотой ба НҮБ-ын арга зүйн зөвлөмж, тэдгээрийг тооцох тухай албан бичиг, чиглэл ирдэггүй нь зохион байгуулалтын уялдаагүйг харуулж байна (ТБ-11, ТБ-12) гэж үзсэн. Мөн ЭЗХЯ манлайлаад мэдээллээ солилцож чадвал ойлголтын зөрөөг багасгах боломжтой ба илүү үр дүнтэй болж үзүүлэлтийг аль аль талдаа ойлгож, үзүүлэлтүүдэд зөрөө гарахгүй (ТБ -5) гэж үзсэн.

Дээрх бэрхшээлийг даван туулахад ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг тооцож гаргадаг байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа чухал хүчин зүйл юм гэж дүгнэж байна. Үүнд, байгууллага хоорондоо мэдээллийн түгээлт, нийлүүлэлт, статистик тоон мэдээллийн зөрүүтэй байдлын тухай мэдээлэл солилцох гэх мэтээр хамтран ажиллах тодорхой чиглэлүүдийг тодорхойлж, он, сар, хугацааны хуваарийг гаргаж, тухай бүр албан бичиг хүлээлгүйгээр мэдээллээ нийлүүлж байх зохион байгуулалтыг бий болгох шаардлагатай байна гэж дүгнэж байна.

**Дөрөвдүгээрт,** ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг тооцохгүй байгаа нь **“Өгөгдөл, мэдээллийн шинж чанараас шалтгаалсан”** байх боломжтой гэсэн утга нь давтамж цөөнтэй (5) харагдаж байгаа ч зарим байгууллагын хувьд тэдэнд тулгарч буй асуудлын нэг юм. Тухайлбал, ТБ-2 “Бас тухайн шалгуур үзүүлэлт нь чанарын үзүүлэлт бол тооцоогүй байх шалтгаантай. Чанарын судалгааг бид яаж тооцохыг мэдэхгүй. Боловсролын яамны 12.8.1 тухайн шалгуур үзүүлэлт нь хуулийг судлахаар байгаа чанарын үзүүлэлт. Чанарын үзүүлэлтийг бид тооцож мэдэхгүй тул тооцоогүй. Чанарын үзүүлэлттэй холбоотой шалгуур үзүүлэлтүүдийг тусгай баг гаргаж хийх шаардлагатай” хэмээн бодит байдлаа тайлбарласан. Мөн зарим байгууллагын хувьд зарим үзүүлэлт нь нарийн судалгаа шаардсан, нэлээд их ажил болж байж гаргаж авахаар байгаа нь орлуулах үзүүлэлтийг хийж байсан болон түр хойш нь тавьж байсан тохиолдлууд гардаг байна (ТБ- 5, ТБ-7).

Гуравдугаар шалтгаантайгаар холбоотой дурдсан байгууллага хоорондын хамтын ажиллагааг зохион байгуулах чиглэлд ТХЗ-ыг тооцож гаргах байгууллагуудын өгөгдөл, мэдээллийн шинж чанарын тухай үзүүлэлтийг мөн хамтатган оруулж, түүнд тухайн байгууллага ямар өгөгдөл цуглуулах, нийлүүлэх боломжтойг харилцан ярилцаж, хүндрэлтэй байгаа тохиолдолд аль байгууллагатай хамтран ажиллаж давах туулах боломжтой зөвлөлдөх сувгийг бий болгож ажиллах хэрэгцээ байна гэж дүгнэж байна.

**Тавдугаарт,** ТХЗ-ын шалгуур үзүүлэлт тооцохгүй байгаа хүндрэл бэрхшээлийн бас нэг нь **“Мэдээллийг тооцох арга зүйгээс шалтгаалсан”** гэсэн дэд утгын давтамж 13 байгаа нь нэлээд чухал санаа гэдгийг илтгэж байна. Оролцогчдын санааг шинжилж үзэхэд, тухайн шалгуур үзүүлэлтийг хариуцах төрийн байгууллагуудын үүрэг бүхий албан хаагчдад НҮБ-ын арга зүйн мета өгөгдлийн тухай ойлголт өгөх зорилгоор, сургалт семинар, зохион байгуулах, тодорхой үзүүлэлтийг тооцоолох өгөгдлийг цуглуулахад шаардлагатай тогтолцоо, ажиллах баг бий болгох замаар арга зүйг нь таниулан тайлбарлах үйл ажиллагаа дутагдаж байгаа тухай онцгойлон тэмдэглэжээ (ТБ- 4, ТБ -5, ТБ- 6, ТБ-9, ТБ-11, ТБ-19, ТБ-20). Тухайлбал, ТБ – 5 “Тодорхой судалгааны баг, зөвлөх баг томилоод бидний гаргаж буй үндэсний үзүүлэлт аргачлал нь олон улсын аргачлалтай таарч байна уу зэрэг нарийвчилсан зөв ойлголттой болох хэрэгтэй байна. Тэгэхээр тусгайлан баг гаргах нь зөв болов уу гэж бодож

байна. Миний харж байснаар жишээлбэл томьёоны нэг өгөгдлийг манайх гаргаж чадахгүй бол тэр аргачлалыг ашиглах боломжгүй болдог. Тэгэхээр зарим үзүүлэлтээр тэр аргачлалыг ашиглах боломжгүй” байна гэж хэлснээс харж болно.

Өмнө гуравдугаар шалтгаантай холбоотой дурдсан байгууллага хоорондын хамтын ажиллагааг зохион байгуулах чиглэлд ТХЗ-ыг мэдээллийг тооцох арга зүй гэсэн чухал хүчин зүйлийг мөн хамтатган оруулж, зөвлөлдөх сувгийн хүрээнд НҮБ-ын ТХЗ-ын мета өгөгдлийн арга зүй, аргачлалын тухай сургалт, семинар, хамтын хэлэлцүүлэг хийх боломж байна гэж дүгнэж байна.

**Зургаадугаарт, “Хөрөнгө санхүүжилтээс шалтгаалсан хүндрэл”** тулгардаг тухай дэд утга нь цөөн тооны давтамжтай хэдий ч (4) мөн анхаарал татсан асуудалд зүй ёсоор орж байна. ТХЗ-ын зарим шалгуур үзүүлэлтийг тооцож байснаа зогсонги байдалд орох, тооцож байсан байгууллага нь зарим үзүүлэлтийг хасаж, тооцохгүй болох, хэдийгээр судалж, тооцохоор төлөвлөсөн ч хэрэгжихгүй байх зэрэг асуудлууд нь зөвхөн санхүүжилттэй холбоотой байдаг тухай судалгаанд оролцогчид тэмдэглэсэн (ТБ-3, ТБ-5, ТБ-9, ТБ-19). Учир нь төрийн байгууллагууд НҮБ-ын төслийн хүрээнд НҮБХХ-тэй хамтран судалгаа хийж, тодорхой шалгуур үзүүлэлтийг тооцож, амжилттай хэрэгжүүлж байснаа тухайн төсөл зогсонгуут санхүүжилтгүй болж, үргэлжлүүлдэггүй байна. Жишээ нь, **ТБ-9** “Миний ажлын байрны тодорхойлолтод НҮБХХ-тэй хамтран ТХЗ-ыг нутагшуулах төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах гэсэн чиг үүрэг байдаг, 2022 оны төлөвлөгөөндөө энэ ажлыг төлөвлөсөн. Гэсэн хэдий ч НҮБХХ-ийн санхүүжилтээс шалтгаалж энэ ажил одоогоор зогсонги байгаа” хэмээн ярьж байхад ТБ- 5 “Гэхдээ төсвийн хязгаарлагдмал байдал, зарим тохиолдолд улс төрчийн субъектив байдал, ач холбогдлыг үнэлэхгүй байх зэрэг асуудлуудаас болоод зарим нэг чухал үзүүлэлтүүд хасагдах тохиолдлууд байдаг. Иймэрхүү судалгаанууд бол ихэвчлэн олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр явуулдаг” гэж тайлбарласан.

Хөрөнгө санхүүжилтээс хамаарч ТХЗ-ын судалгаа, тооцоолол хийх боломжгүй байгаа гэсэн асуудлыг гадаадын хөрөнгө оруулалтаас гадна байгууллага хоорондын хамтын ажиллагаагаар шийдэх боломж байгаа эсэхийг судалж үзэх нь нэг гарц байж болно. Жишээлбэл, 16.7.2 шалгуур үзүүлэлтийн тооцооллыг ҮСХ, Удирдлагын академи хоёр байгууллага өөрсдийн хүний нөөц, хөрөнгө, цаг хугацаа, бололцоог хамтатгасны үр дүнд хийлээ.

**Эцэст нь, “Тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлтийг тооцон гаргах боломжийн тухайд”** үндсэн категорит (давтамж 11), **“Байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах”** гэсэн гол санаа илэрсэн. **Тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт”**-ийг үнэхээр тооцон гаргах боломжгүй, эсвэл нөхцөлийг нь хангавал боловсруулах боломж байна уу гэсэн өнцгөөс оролцогчдын ярилцлагыг шинжилж үзвэл дараах дөрвөн чиглэл харагдаж байна.

Үүнд:

- чиглэл чиглэлийн байгууллагууд хамтран ажиллаж, мэдээллээ хуваалцвал тооцох бүрэн боломжтой (ТБ-1, ТБ- 7, ТБ- 6, ТБ-12, ТБ-19)
- дээд түвшинд албан ёсны болгосон тохиолдолд ажил хэрэг болгон хамтран ажиллавал хэрэгжих боломжтой (ТБ – 5)
- төр болон хувийн хэвшил, иргэний оролцоотойгоор хэрэгжүүлэх боломжтой (ТБ-19, ТБ-15)
- ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг тооцох статистик мэдээллийг давхардалгүй болгох, арга зүйн сургалт, зөвлөгөөгөөр хангаж ажиллах (ТБ-16, ТБ-11)

Ийнхүү ТХЗ-2030 -ын тооцож гараагүй байгаа 102 шалгуур үзүүлэлтийн талаарх судалгаанд оролцогчдын санаа бодлыг дээрх 3 үндсэн категори, 8 дэд утга тус бүрийн хүрээнд хэрхэн тайлбарласныг нь авч үзлээ. Учир нь тулгарч буй хүндрэл бэрхшээлийн бодит шалтгааны мөн чанарыг эдгээр судалгаанд оролцогчдын тайлбар тодорхой хэмжээнд илтгэж байна гэж дүгнэж болно.

## ЗУРГААДУГААР БҮЛЭГ. “ТООЦООГҮЙ БОЛОН ДУТУУ ТООЦОЖ БАЙГАА ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭС” КЕЙС БОЛГОЖ СОНГОЖ АВСАН ТХЗ 16.7.2 ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТУРШИЛТ СУДАЛГАА

### 6.1. ТХЗ-ын 16.7.2 кейс шалгуур үзүүлэлтийг туршсан судалгааны өгөгдөл боловсруулалт

Туршилт судалгаагаар судалгаанд оролцогчдын нас, хүйс, үндэс угсаа, боловсролын түвшин, сарын тогтмол орлого, ажил эрхлэлтийн байдал болон эрүүл мэндийн ямар нэг бэрхшээлтэй эсэхийг НҮБ-ын зөвлөмжийн дагуу хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох Вашингтон Группийн 6 асуултын хүрээнд мөн асуусан. НҮБХХ-ийн Ослогийн Засаглалын Төвөөс гаргасан зөвлөмжид тусгагдсан шийдвэр гаргалтын гадаад үр дүнг “шийдвэр гаргалтад олон нийтийг тэгш оролцуулсан, иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй шийдвэр гаргалт” гэсэн хоёр хэмжээсээр хэмжихээр стандартчилагдсан байдаг. Тиймээс энэ удаагийн туршилт судалгаагаар судалгааны ажлын хүрээнд кейс байдлаар судалж байгаа Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлт 16.7.2-ыг судлах онол, үзэл баримтлалыг үндэслэл болгон улс төрчид болон улс төрийн институц шийдвэр гаргахдаа *нэгдүгээрт*, иргэдийг тэгш хамруулан оролцуулж байгаа гэдэгт, *хоёрдугаарт* иргэдийн санал бодол, дуу хоолой тэдний шийдвэр гаргалтад тусгагддаг гэдэгт иргэд өөрсдөө хэр зэрэг итгэл үнэмшилтэй байгааг тэдний санаа бодлоор хэмжсэн болно. Дээрх аргачлалд тулгуурлан туршилтын судалгааны хүрээнд **“олон нийтийг тэгш оролцуулсан шийдвэр гаргалт”, “иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй шийдвэр гаргалт”** гэсэн хоёр хэмжээсийн хүрээнд 2 үндсэн асуулт, түүнийг тодорхойлох 10, судалгаанд оролцогчдын хувийн мэдээллийг оруулаад нийт 10 чиглэлээр асуултыг боловсруулан асууж, тэдний хариултыг нэгтгэн боловсруулж, гол үр дүнг товч байдлаар энд танилцуулсан болно.

Судалгааны баг энэ удаагийн туршилтын судалгааг Сүхбаатар дүүргийн, сонгогдсон хорооны 18 ба түүнээс дээш насны 123 иргэнийг туршилтын судалгаанд оролцуулж, асуулгын аргаар мэдээлэл цуглуулж, боловсруулалт хийж ажилласан болно.

Туршилт судалгааны хүрээнд судалгаанд оролцогчдоос тодруулж асуух үндсэн хоёр асуултыг Ликертийн 5 шкалыг ашиглан “1 – огт үгүй, 2 – маш бага, 3 – заримдаа, 4 – хангалттай, 5 – Хангалттай сайн” гэсэн үзүүлэлтүүдээр үнэлүүлж хариултын **давтамж**, нийт хариултад **эзлэх хувь, дундаж үнэлгээ** тооцсон болно.

Доорх хэсэгт судалгаанд оролцогчдын мэдээллийг нэгтгэн танилцуулж байна.


## Нас

Судалгаанд оролцогчдыг насны бүлгээр харьцуулан үзэхэд 12.6 хувь 18-24, 23.5 хувь нь 25-34, 22.7 хувь нь 35-44, 18.5 хувь нь 45-54, 14.3 хувь нь 55-64, 8.4 хувь 60 ба түүнээс дээш насныхан байлаа.

Харин тэднийг насны бүлгээр нь хоёр асуултад эерэг хариулт өгсөн дунджаар нь харьцуулан үзэхэд 35-44 насныхан хамгийн өндөр буюу 48.2 хувийн эерэг хариултыг өгсөн бол 25-34 насныхан хамгийн бага буюу 25.0 хувийн эерэг хариултыг өгсөн байна байна /Зураг 8/. Энэ нь даруй 23.2 хувийн зөрүүтэй байна. Гэхдээ 18-24 насныхан хоёр асуултад өгсөн эерэг хариулт нь 40 хувь байгаа нь өндөр үзүүлэлт юм. Хамгийн сонирхолтой нь 60-аас дээш насныхан Асуулт 1-д 60 хувийн хамгийн өндөр эерэг хариултыг өгсөн атал Асуулт 1-д хамгийн бага эерэг буюу дөнгөж 10 хувийн санал өгсөн байна. Үүнээс дүгнэж үзэхэд энэ судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар манай төр засаг иргэдийнхээ санаа бодлыг анхааран сонсох боломжийг харьцангуй бүрдүүлсэн хэдий ч тэдний санаа бодол нь төр засгийн шийдвэр гарахад нөлөөлдөг гэж үздэг хүний хувь бага байна.



## Зураг 8. Судалгаанд оролцогчдын нас (хувь)



Эх сурвалж: Судалгааны үр дүн

## Хүйс

Судалгаанд оролцогчдын 35.4 хувийг эрэгтэйчүүд, 64.6 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байсан ба эмэгтэйчүүд 29.2 пунктаар илүү оролцсон байна. Хоёр асуултад хариулсан эерэг дунджийг хүйсээр нь харьцуулж харахад эрэгтэйчүүд 36.3 хувь, эмэгтэйчүүд 34.3 хувь байгаа нь эрэгтэйчүүд нэг пунктээр илүү эерэг хариултыг өгсөн байна /Зураг 9/.

**Зураг 9. Судалгаанд оролцогчдын хүйс (хувь)**




Эх сурвалж: Судалгааны үр дүн

## Үндэс угсаа

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь 93.7 хувь нь халх үндэстэн байсан бол 6.3 хувь нь бусад үндэс угсаатан хамрагджээ. Тухайлбал, 3.2 хувь нь баяд, 1.1 хувь буриад, 1.1 хувь нь казак, 1.1 хувь нь хотгойд байлаа. Тэдгээрийн хоёр асуултад эерэг хариултын дунджийг авч үзэхэд дараах байдалтай байна /Зураг 10/.

**Зураг 10. Хоёр асуултад эерэг хариулт өгсөн оролцогчдын дундаж хувь үндэс, угсаагаар (хувь)**




Эх сурвалж: Судалгааны үр дүн

## Боловсролын түвшин

Судалгаанд оролцогчдын 1.6 хувь сургуульд суралцаагүй, 46.7 хувь нь бүрэн дунд боловсролтой, 6.6 хувь нь тусгай дунд боловсролтой, 45.1 хувь нь дээд боловсролтой иргэд байна. Нийт судалгаанд оролцогчдын 91.8 хувийг бүрэн дунд болон дээд боловсролтой иргэд бүрдүүлсэн байна. Хоёр асуултын эерэг хариултын дунджийг харьцуулахад бүрэн дунд боловсролтой иргэд 41 хувь буюу өндөр хувь, тусгай боловсролтой иргэд дөнгөж 13 хувийн буюу хамгийн бага хувийн хариултыг өгсөн байна. Харин дээд боловсролтой иргэд дунд зэрэг буюу 32 хувийн эерэг хариултыг өгчээ. Энд боловсролгүй иргэдийн оролцоо бага дөнгөж 1.6 хувь байсан тул эерэг хариулт өгсөн нь хувь нь өндөр буюу 100% байлаа /Зураг 11/.

**Зураг 11. Судалгаанд оролцогчдын эерэг хариултын дунджийг боловсролын түвшнээр (хувь)**




Эх сурвалж: Судалгааны үр дүн

## Орлого

Судалгаанд оролцогчдын нэг сарын орлогыг тодруулж асуухад 18.5 хувь 250 мянга – 500 мянга, 42 хувь нь 500 мянга – 1 сая төг, 18.5 хувь нь 1 сая – 1.5 сая төгрөгний орлоготой хэмээн хариулжээ.

### Зураг 12. Судалгаанд оролцогчдын нэг сарын орлого (хувь)




Эх сурвалж: Судалгааны үр дүн

## Ажил эрхлэлтийн байдал

Судалгааны хүрээнд ажил эрхлэлтийн зохих төлөөллийг хангасан бөгөөд тэдний 53.7 хувийг нь цалинтай ажилтай ажиллагсад, 23.6 хувийг хуваариа хөдөлмөр эрхлэгчид, 9.8 хувийг өндөр насны тэтгэвэрт хамрагсад, 0.8 хувийг тэтгэмжид хамрагддаг, 6.5 хувийг оюутан/ сурагч, 5.7 хувийг ажилгүй иргэд бүрдүүлсэн байна. Судалгаанд оролцогчдын хоёр асуултын эерэг хариултын дундаж ажил эрхлэлтээр нь авч харьцуулахад өндөр насны тэтгэвэрт суугаа хүмүүс бусад бүлгийн хүмүүсээс хамгийн өндөр буюу 54 хувийн эерэг хариултыг өгсөн байна. Харин ажилгүй болон хувиараа хөдөлмөр эрхлэгчид хамгийн бага буюу 22 хувь нь эерэг хариулт өгсөн байна /Зураг 13/.

**Зураг 13. Судалгаанд оролцогчдын хоёр асуултын эерэг хариултын дундаж ажил эрхлэлтээр (хувь)**




Эх сурвалж: Судалгааны үр дүн

## 6.2. Туршилт судалгааны гол үр дүн

### Асуулт 1.

Судалгаанд оролцогчдоос манай төр засаг иргэдийнхээ санаа бодлыг анхаарах, сонсох боломжийг хэрэг зэрэг бүрдүүлсэн гэж бодож байгааг асуухад 23.6 хувь нь "Огт үгүй", 35.8 хувь нь "Маш бага", 22.8 хувь нь "Заримдаа", 16.3 хувь нь "хангалттай", 1.6 хувь нь "Хангалттай сайн" гэж хариулсан байна.

**Зураг 14. Төр засаг иргэдийнхээ санаа бодлыг анхаарах сонсох боломжийг бүрдүүлсэн эсэх талаар судалгаанд оролцогчдын үнэлгээ (хувь)**




Эх сурвалж: Судалгааны үр дүн

Дээрх үр дүнгээс үзэхэд судалгаанд оролцогчдын **40.7 хувь нь эергээр** хариулт буюу "заримдаа, хангалттай, хангалттай сайн" гэсэн үнэлгээ өгчээ. 1 – 5 хүртэлх онооны дундаж үнэлгээ **2.37** гарч байна. Энэ нь судалгаанд оролцогчдын дүгнэснээр одоо байгаа тогтолцоо нь **"иргэдийнхээ санаа бодлыг анхааран сонсох боломжоор" дундаас доогуур түвшинд** хангасан гэж үзсэн байна.

### Асуулт 2.

Судалгаанд оролцогчдоос төр засгийн шийдвэрт иргэдийн санаа бодол хэрэг зэрэг нөлөөлдөг гэж бодож байгааг нь асуухад 22 хувь нь "Огт үгүй", 45.5 хувь нь "Маш бага", 26 хувь нь "Заримдаа", 5.7 хувь нь "Хангалттай", 0.8 хувь нь "Хангалттай сайн" гэсэн үнэлгээ өгч хариулжээ.

**Зураг 15. Төр засгийн шийдвэрт иргэдийн санаа бодол хэр зэрэг нөлөөлдөг талаарх судалгаанд оролцогчдын үнэлгээ (хувь)**



Эх сурвалж: Судалгааны үр дүн

Дээрх үр дүнгээс эерэг үнэлгээ өгсөн хариулт буюу “3 буюу заримдаа”, “4 буюу хангалттай”, “5 буюу хангалттай сайн” гэсэн үнэлгээний өгсөн хариултын эзлэх хувийг нэгтгэн үзэхэд 32.5 хувь гарч байна. Тэдний өгсөн үнэлгээний дундаж үнэлгээ **2.18** гарсан нь дунджаасдоогуур дүн гарсан байна. (Хүснэгт 40-өөс дэлгэрүүлж үзнэ үү).

Судалгаанд оролцогчдын 1 – 5 хүртэлх оноогоор үнэлсэн үнэлгээний дундаж үнэлгээг үндсэн 2 асуултаар харьцуулан үзвэл, 1 – 5 хүртэлх онооны дундаж болох 2.5 онооноос доогуур буюу “Маш бага” гэсэн үнэлгээтэй байна.

**Хүснэгт 40. Үндсэн асуултуудын дундаж үнэлгээ, харьцуулалт (Mean)**

Descriptive Statistics					
	N	Mini- mum	Maxi- mum	Mean	Std. Deviation
Манай төр засаг иргэдийн санаа бодлыг анхааран сонсох боломжийг хэр зэрэг бүрдүүлсэн гэж Та бодож байна вэ?	123	1	5	2.37	1.066
Манай төр засгийн шийдвэрт иргэдийн санаа бодол хэр зэрэг нөлөөлдөг гэж Та бодож байна вэ?	123	1	5	2.18	.869
Valid N (listwise)	123				

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлт 16.7.2-ыг тооцох судалгааны дизайнд тусгагдсан аргачлалын дагуу судалгаанд оролцогчдын Үндсэн асуулт 1, 2 –т өгсөн эерэг үнэлгээ, түүний дундаж хувийг тооцож үзэхэд дараах үр дүн гарч байна (Хүснэгт 41-ээс дэлгэрүүлж үзнэ үү).



#### Хүснэгт 41. Үндсэн асуултууд, хэмжих шкал (Ликертийн 5 шкал)

1. Манай төр засаг иргэдийнхээ санаа бодлыг анхааран сонсох боломжийг хэр зэрэг бүрдүүлсэн гэж Та бодож байна вэ?		2. Манай төр засгийн шийдвэрт иргэдийн санаа бодол хэр зэрэг нөлөөлдөг гэж Та бодож байна?	
1- Огт бүрдүүлээгүй	23.6%	1- Огт нөлөөлдөггүй	22.0%
2- Маш бага	35.8%	2- Маш бага	45.5%
3- Заримдаа	22.8%	3- Заримдаа	26.0%
4- Хангалттай	16.3%	4- Хангалттай	5.7%
5- Хангалттай сайн	1.6%	5- Хангалттай сайн	0.8%
Эргээр хариулсан хүний хувь (жишээ нь, 3, 4 болон 5-ыг сонгосон хүмүүс)	40.7%	Эргээр хариулсан хүний хувь (жишээ нь, 3, 4 болон 5-ыг сонгосон хүмүүс)	32.5%
б. Дээрх нэгтгэсэн хоёр хувийн дунджийг тооцвол $(40,7\% + 32,5\%) / 2 = 36,6\%$			

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Дээрх хүснэгтээс үзэхэд **Асуулт 1** буюу “Манай төр засаг иргэдийнхээ санаа бодлыг анхааран сонсох боломжийг хэрэг зэрэг бүрдүүлсэн гэж Та бодож байна вэ?” гэсэн асуултын эерэг хариултын эзлэх хувийн нийлбэр 40.7 хувь, **Асуулт 2** буюу “Манай төр засгийн шийдвэрт иргэдийн санаа бодол хэр зэрэг нөлөөлдөг гэж Та бодож байна?” гэсэн асуултын эерэг хариултын эзлэх хувийн нийлбэр 32.5 хувь байна. Дээрх хоёр асуултын эерэг хариултыг нэгтгэн дунджийг тооцвол  $(40,7\% + 32,5\%) / 2 = 36,6\%$  гарсан байна.

# ДОЛООДУГААР БҮЛЭГ. КЕЙС БОЛГОН СОНГОЖ АВСАН ТХЗ 16.7.2-ЫН ШИЙДВЭР ГАРГАЛТ НЬ ОЛОН НИЙТИЙГ ТЭГШ ОРОЛЦУУЛСАН, ИРГЭДИЙН САНАЛЫГ ТУСГАСАН ҮР ДҮНТЭЙ ГЭДЭГТ ИРГЭД ИТГЭХ САНАА БОДЛЫН ТҮВШИНГ ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ТОГТООХ СУДАЛГАА

Энэ судалгаанд ҮСХ-ны боловсруулсан түүврийн дизайны дагуу Монгол Улсын 5 бүсийн 6000 иргэдээс асуулга авахаар төлөвлөсөн байсан тул судалгаа эхлэхийн өмнө мэдээлэл цуглуулах 10 судлаачдыг өмнө дурдсанаар 2 цагийн сургалтад хамруулсан. Судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2022 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс 9 дүгээр сарын 16-ны өдрийг дуустал өдрүүдэд 10 судлаач утсаар зохион байгуулсан. ҮСХ-ны Нийгмийн статистикийн Өрхөд суурилсан судалгааны хэлтэстэй хамтран хийсэн уг сургалтаар судлаач нь таблет ашиглан өгөгдөл, мэдээлэл цуглуулахдаа программыг хэрхэн ашиглах тухай, мөн ТХЗ 16.7.2 шалгуур үзүүлэлтийн үндсэн концепцыг тайлбарлаж, иргэдээс асуухдаа, юуг анхаарах, хэрхэн асуух, хэрхэн тэмдэглэх талаар зөвлөмж өгч ажилласан. ТХЗ-ын 16.7.2 шалгуур үзүүлэлтийг тооцох мэдээлэл цуглуулахад түүвэрт 2021 оны ӨНЭЗС-нд хамрагдсан өрхийн гишүүд хамрагдсан. Утсаар асуулга авах явцад утасны дуудлагад хариу өгөхгүй, утсаа авахгүй, утас нь холбогдохгүй зэрэг тохиолдлууд нэлээд гарч байсан тул судалгаанд 3000 нөөц өрхийг нэмснээр нийт 9105 хүнтэй дуудлага хийж 3-5 удаа холбогдох оролдлого хийснээс 4325 хүн тухайн 2 асуултад хариулт өгсөн. Хариултыг ӨНЭЗС-ны өгөгдөлтэй холбож үр дүнг насанд хүрсэн хүн амд тархаан тооцсон ба түүврийн хүн ам зүйн ерөнхий статистикийг дараах Хүснэгт 42-т харуулж байна.

## Хүснэгт 42. Түүвэрт хамрагдсан оролцогчдын хүн ам зүйн статистик

Үзүүлэлт		МД	Тооцооны утга	Ажиглалтын утга	Хувь	Стандарт алдаа	95 хувийн итгэмжлэгдэх магадлал	
							Доод	Дээд
А		1						
<b>Бүгд</b>		2	2,096,244	4,325	100.0			
Хүйс	Эрэгтэй	3	1,010,100	1,988	48.2	0.846	46.53	49.85
	Эмэгтэй	4	1,086,144	2,337	51.8	0.846	50.15	53.47
Насны бүлэг	18-24	5	307,095	494	14.7	0.674	13.38	16.02
	25-34	6	529,186	886	25.2	0.888	23.54	27.03
	35-44	7	480,166	1,016	22.9	0.787	21.40	24.49
	45-54	8	370,530	885	17.7	0.668	16.40	19.02
	55-64	9	257,612	657	12.3	0.557	11.24	13.42
	65 ба түүнээс дээш	10	151,655	387	7.2	0.429	6.44	8.12

Байршил	Хот	11	1,429,430	2,347	68.2	0.797	66.61	69.73
	Хөдөө	12	666,814	1,978	31.8	0.797	30.27	33.39
Бүсээр	Баруун бүс	13	256,214	598	12.2	1.009	10.38	14.34
	Хангайн бүс	14	389,466	771	18.6	1.215	16.31	21.08
	Төвийн бүс	15	331,711	1,202	15.8	1.023	13.92	17.94
	Зүүн бүс	16	145,141	753	6.9	0.692	5.68	8.41
	Улаанбаатар	17	973,712	1,001	46.5	0.893	44.70	48.21
Орлогын бүлэглэлт	300 000 төгрөг хүртэл	18	5,303	15	0.3	0.084	0.13	0.49
	300 001-500 000	19	58,922	157	2.8	0.308	2.27	3.48
	500 001-700 000	20	111,975	275	5.3	0.396	4.62	6.18
	700 001-900 000	21	159,733	370	7.6	0.496	6.70	8.65
	900 001-1 100 000	22	213,941	497	10.2	0.547	9.18	11.33
	1 100 001-1 600 000	23	541,437	1,117	25.8	0.909	24.09	27.65
	1 600 001-2 100 000	24	402,199	775	19.2	0.804	17.66	20.81
	2 100 001-3 000 000	25	363,039	683	17.3	0.805	15.80	18.95
3 000 001 төгрөгөөс дээш	26	239,695	436	11.4	0.765	10.02	13.02	
Боловсролын түвшин	Боловсролгүй – 1	27	66,411	175	3.2	0.310	2.61	3.84
	Бага – 2	28	72,013	219	3.4	0.274	2.94	4.02
	Суурь – 3	29	300,330	821	14.3	0.613	13.17	15.57
	Бүрэн дунд – 4	30	648,657	1,211	30.9	0.965	29.08	32.87
	Техникийн болон мэргэжлийн – 5	31	161,293	365	7.7	0.540	6.70	8.82
	Тусгай мэргэжлийн дунд – 6	32	129,022	290	6.2	0.480	5.28	7.17
	Дипломын дээд – 7	33	70,398	125	3.4	0.404	2.65	4.25
	Бакалаврын дээд – 8	34	535,270	935	25.5	0.977	23.67	27.50
	Магистр – 9	35	63,156	86	3.0	0.384	2.34	3.87
	Доктор – 10	36	7,011	8	0.3	0.119	0.17	0.67
Боловсролын түвшин хариулаагүй	37	42,683	90	2.0	0.262	1.58	2.62	

Эх сурвалж: ҮСХ, судалгааны баг

Судалгааны үр дүнгээр төр засаг иргэдийнхээ санаа бодлыг анхааран сонсох боломжийг хангалттай бүрдүүлсэн, шийдвэр гаргалтад иргэдийн санаа бодол хангалттай нөлөөлдөг гэж хариулсан хүний нийт дундаж хувь түүвэр олонлогийн тооцоогоор 36.6 хувь, эх олонлогт тархаасан тооцоогоор 35.5 хувь байв /Хүснэгт 43-ыг харна уу/.

### Хүснэгт 43. Үндсэн асуултууд, түүний хэмжилтийн үр дүн


A1. Манай төр засаг иргэдийнхээ санаа бодлыг анхааран сонсох боломжийг хэр зэрэг бүрдүүлсэн гэж Та бодож байна?			A2. Манай төр засгийн шийдвэрт иргэдийн санаа бодол хэр зэрэг нөлөөлдөг гэж Та бодож байна?		
Хариултын хувилбар	Түүвэр олонлог	Эх олонлогт тархаасан	Хариултын хувилбар	Түүвэр олонлог	Эх олонлогт тархаасан
Огт бүрдүүлээгүй (1)	28.5%	31.2%	Огт нөлөөлдөггүй (1)	30.2%	31.0%
Маш бага (2)	24.9%	24.8%	Маш бага (2)	27.7%	28.6%
Дунд зэрэг (3)	28.8%	27.6%	Дунд зэрэг (3)	25.4%	24.6%
Хангалттай (4)	8.4%	8.1%	Хангалттай (4)	8.1%	8.1%
Хангалттай сайн (5)	1.1%	1.1%	Хангалттай сайн (5)	1.2%	1.5%
Мэдэхгүй (6)	3.7%	3.9%	Мэдэхгүй (6)	2.8%	2.9%
Хариулахаас татгалзсан (7)	4.5%	3.2%	Хариулахаас татгалзсан (7)	4.7%	3.4%
Эерэгээр хариулсан хүний хувь [(3), (4), (5)-ыг сонгосон хүмүүс]	38.4%	36.8%	Эерэгээр хариулсан хүний хувь [(3), (4), (5)-ыг сонгосон хүмүүс]	34.7%	34.1%
<b>A1, A2-д эерэгээр хариулсан хүний дундаж хувь</b>	<b>Түүвэр олонлог (38.4%+34.7%) /2=36.6%</b>		<b>Эх олонлогт тархаасан (36.8%+34.1%)/2=35.5%</b>		

Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Асуулт 1, асуулт 2-т эерэг буюу дунд зэрэг, хангалттай, хангалттай сайн гэж хариулсан эх олонлогт тархаасан хүн амын нийт дундаж хувь 35.5 байхад сөрөг буюу огт бүрдүүлээгүй/нөлөөлдөггүй, маш бага гэж хариулсан хүний дундаж хувь 57.8 байна. Өөрөөр хэлбэл, сөрөг хариулсан хүний дундаж хувь эерэг хариулсан хүний дундаж хувиас 22.8 пунктээр илүү байна.

Үүнээс “Манай төр засаг иргэдийнхээ санаа бодлыг анхааран сонсох боломжийг хэр зэрэг бүрдүүлсэн гэж Та бодож байна вэ? (асуулт1)” гэсэн асуултын “Дунд зэрэг”, “Хангалттай”, “Хангалттай сайн” хариултыг эерэг гэж үзэн авч үзэхэд эергээр хариулсан түүвэр олонлог нь 38.4%, харин “огт бүрдүүлээгүй”, “маш бага” гэсэн хариултыг 28.5% нь өгчээ /Зураг 16-г харна уу/.


### Зураг 16. Манай төр засаг иргэдийнхээ санаа бодлыг анхааран сонсох боломжийг хэр зэрэг бүрдүүлсэн гэж Та бодож байна?



Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Түүнчлэн хоёрдугаар асуулт “Манай төр засгийн шийдвэрт иргэдийн санаа бодол хэр зэрэг нөлөөлдөг гэж Та бодож байна? (Асуулт2)” гэсэн асуултын “Дунд зэрэг”, “Хангалттай”, “Хангалттай сайн” гэсэн эерэг хариултыг 34.7%, харин “огт нөлөөлдөггүй”, “маш бага” гэсэн хариултыг сөрөг хариултыг 30.2% өгсөн байна /Зураг 17-г харна уу/.

### Зураг 17. Манай төр засгийн шийдвэрт иргэдийн санаа бодол хэр зэрэг нөлөөлдөг гэж Та бодож байна?



Эх үүсвэр: Судалгааны үр дүн


### Дэлхийн ТХЗ-2030-ын НҮБ-аас санал болгосон зөвлөмжид зааснаар ТХЗ-ын 16.7.2 шалгуур үзүүлэлтийг тооцохдоо

1. хүйсээр
2. насны бүлгээр
3. байршлаар
4. орлогын бүлгээр
5. боловсролын түвшнээр
6. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн
7. бүсийн хувиар илэрхийлэхийг заасны дагуу энэ судалгааны үр дүнг тооцоо.

Иймээс энэ судалгаанд эдгээр **7 үзүүлэлтийг тооцооллын үр дүн нь хоёр үндсэн асуултаараа ЭХ ОЛОНЛОГТ ТАРХААСАН** БАЙДЛААР ямар гарсныг доор тус тусад нь авч үзье. **Үүнд:**

*Нэгдүгээрт*, хүйсийн хувьд, **эерэг** хариулсан эмэгтэйчүүдийн дундаж хувь эрэгтэйчүүдийнхээс 2.6 пунктээр их, сөрөг хариулсан эрэгтэйчүүдийн дундаж хувь эмэгтэйчүүдийнхээс 2.2 пунктээр их байв /Зураг 18 харна уу/.


### Зураг 18. Хоёр хариултын дундаж хувь, хүйсээр



Эх сурвалж: Судалгааны үр дүн

*Хоёрдугаарт*, насны бүлгийн хувьд, асуултуудад 63.2% буюу хамгийн өндөр хувийн сөрөг хариулт өгсөн 25-34 насны залуучуудын дундаж хувь нь эерэг хариулсан энэ насны залуучуудынхаас 32.8 пунктээр илүү байхад 65 ба түүнээс дээш насны ахмад настнуудын 50.3% нь эерэг хариулснаараа хамгийн өндөр эерэг хариултыг өгсөн насны бүлэг байна. Энэ нь тэдний сөрөг хариулсан ахмадуудынхаасаа 9.3 пунктээр илүү байгааг дараах Зураг 19-өөс харж болно.


### Зураг 19. Хоёр хариултын дундаж хувь, насны бүлгээр



Эх сурвалж: Судалгааны үр дүн

Гуравдугаарт, амьдарч буй газар, байршлын хувьд авч үзэхэд, эерэг хариулсан хүний дундаж хувь хөдөөд хотынхоос 9.6 пунктээр илүү байхад сөрөг хариулсан хүний дундаж хувь хотод хөдөөгийнхөөс 8.1 пунктээр илүү байна /Зураг 21/.

### Зураг 20. Хоёр хариултын дундаж хувь, байршлаар




Эх сурвалж: Судалгааны үр дүн



*Дөрөвдүгээрт*, орлогын бүлгээр авч үзэхэд, эерэг хариулсан 300 мянган төгрөг хүртэлх орлоготой хүмүүсийн дундаж хувь 24.7 хувь байгаа нь сөрөг хариулсан хүмүүсийн дундаж хувиас 45.6 пунктээр бага буюу хамгийн бага байна. Харин сөрөг хариулсан 3 сая төгрөгөөс дээш орлоготой хүмүүсийн дундаж хувь 61.9 байгаа нь эерэг хариулсан хүмүүсийн дундаж хувиас 29.0 пунктээр их байна. 500 мянган төгрөгөөс 700 мянган төгрөг хүртэлх орлоготой хүмүүс эерэг хариултыг хамгийн өндөр буюу 43.2%-тай өгсөн бол 300 мянган төгрөг хүртэл орлоготой иргэдийн сөрөг хариулт 70.3% байгаа нь өндөр сөрөг хариулт байна.

**Зураг 21. Хоёр хариултын дундаж хувь, орлогын бүлэглэлээр**



Эх сурвалж: Судалгааны үр дүн

*Тавдугаарт*, боловсролын түвшнээр авч үзэхэд, судалгаанд хамрагдагчдаас докторын зэрэгтэй иргэдийн дөнгөж 11.2% нь эерэг, удаалаад магистрын зэрэгтэй хүмүүсийн 28.4% нь эерэг хариултыг өгсөн байхад бусад боловсролын зэрэгтэй хүмүүсийн хувьд эерэг хариултын хувь харьцангуй өндөр буюу 30%-с дээш байна. Ялангуяа Зураг 23-аас харахад бага боловсролтой иргэдийн эерэг хариулт 46.1% байгаа нь хамгийн өндөр байна. Магистрын зэрэгтэй иргэдийн 64.4% нь сөрөг хариулт өгсөн бага боловсролтой иргэдийн сөрөг хариулт 49.5% буюу хамгийн бага хувьтай сөрөг хариулт байна. Гэтэл докторын түвшний зэрэгтэй иргэд Мэдэхгүй/Хариулаагүй гэсэн хариултыг 48.4% өгсөн нь хамгийн өндөр байна.

## Зураг 22. Хоёр хариултын дундаж хувь, боловсролын түвшнээр



Эх сурвалж: Судалгааны үр дүн


**Зургаадугаарт,** хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд авч үзэхэд, хөгжлийн бэрхшээлийн статистикийн чиглэлээр ажилладаг НҮБ-ын Статистикийн хэлтсийн дэргэдэх Вашингтон бүлгийн<sup>41</sup> боловсруулсан арга зүйг 2016 оноос эхлэн ашиглан, хүн амын хөгжлийн бэрхшээлийн тархалтыг судалж байна. Вашингтон бүлэг нь хөгжлийн бэрхшээлийн хэмжигдэхүүнийг хүн амын үйлдлийн чадварын хүндрэлийг тодорхойлох богино болон өргөтгөсөн багц асуултуудыг боловсруулж, харах, сонсох, алхах, танин мэдэх, өөртөө анхаарал, халамж тавих, харилцан мэдээлэл солилцох гэсэн 6 багц үйлдлийн хувьд хүндрэлийг тодорхойлох бөгөөд “бэрхшээлгүй”, “бага зэрэг бэрхшээлтэй”, “маш их бэрхшээлтэй”, “огт чадахгүй” гэсэн 4 төрлийн хариулттай юм. Вашингтон бүлгийн стандартын дагуу дээрх 6 үйлдлийн дор

<sup>41</sup> Вашингтон бүлгийн асуулгыг ҮСХ-ноос баталсан орчуулга болон тус байгууллагын арга зүй, нэр томъёогоор хийлээ.

хаяж нэг үйлдлийн хувьд “маш их бэрхшээлтэй” эсвэл “огт чадахгүй” гэж хариулсан хүнийг үйлдлийн чадварын хүндрэлтэй гэж тодорхойлж авч үзэхийг зөвлөмж болгосон байдаг.

Энэ арга зүйн дагуу гаргасан үр дүнгийн эх олонлогт тархаасан тооцоогоор хүн амын 97.4 хувь нь үйлдлийн чадварын хүндрэлгүй, 2.9 хувь нь үйлдлийн чадварын хүндрэлтэй байна. Мөн түүвэр олонлогийн тооцоогоор хүн амын 96.4 хувь үйлдлийн чадварын хүндрэлгүй байхад 3.6 хувь нь үйлдлийн аль нэг чадварын хүндрэлтэй гарчээ /Зураг 24/.

### Зураг 23. Судалгаанд хамрагдсан хүн амын эзлэх хувь, хөгжлийн бэрхшээлийн байдлаар




Эх сурвалж: Судалгааны үр дүн

Эх олонлогт тархаасан тооцоогоор үйлдлийн чадварын хүндрэлтэй гэж тодорхойлогдсон хүн амын 39.0 хувь нь “Манай төр, засаг иргэдийнхээ санаа бодлыг анхааран сонсох боломжийг хангалттай бүрдүүлсэн”, “Манай төр засгийн шийдвэрт иргэдийн санаа бодол хангалттай нөлөөлдөг” гэж, 48.7 хувь нь сөрөг хариулт өгчээ.

Харин үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амын талаас илүү хувь нь “Манай төр, засаг иргэдийнхээ санаа бодлыг анхааран сонсох боломжийг огт бүрдүүлээгүй”, “Манай төр засгийн шийдвэрт иргэдийн санаа бодол огт нөлөөлдөггүй” гэж хариулсан байна /Зураг 25/.


### Зураг 24. Хоёр хариултын дундаж хувь, үйлдлийн чадварын хүндрэлээр



Эх сурвалж: Судалгааны үр дүн

Алхах үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын хувьд дунджаар 82.9 хувь нь асуулт 1, асуулт 2-т сөрөг хариулт өгсөн байхад энэ чадварын хүндрэлгүй хүн амын хувьд дунджаар 57.8 хувь сөрөг, 35.5 хувь нь эерэг хариулжээ, Харин 6.7 хувь нь мэдэхгүй/хариулахаас татгалзсан байв /Зураг 26/.


**Зураг 25. Хоёр хариултын дундаж хувь, үйлдлийн чадварын хүндрэлийн төрлөөр**



Эх сурвалж: Судалгааны үр дүн

**Эцэст нь, долдугаарт,** бүсийн хувьд, баруун бүсэд амьдарч буй хоёр хүн тутмын нэг (хамгийн их буюу 48.2 хувь) нь, Улаанбаатарт амьдарч буй гурван хүн тутмын нэг (33.9 хувь буюу хамгийн бага) нь тус тус эерэг хариулжээ. Төвийн бүсийн хувьд сөрөг хариулсан хүний дундаж хувь Улаанбаатараас 2.2 пунктээр бага байв. Зүүн бүсийн хувьд улсын дундажтай ижил байна /Зураг 27/.

### Зураг 26. Хоёр хариултын дундаж бүсээр



Эх сурвалж: Судалгааны үр дүн

## НАЙМДУГААР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ, САНАЛ

НҮБ-аас санаачилсан олон улсын шалгуур үзүүлэлтүүдийг 2016 оноос хойш дэлхий нийтээр хэрэгжүүлэхээр олон улсын өмнө үүрэг хүлээж, нэгдсэн улс орнуудын нэг нь Монгол Улс билээ. ЗГХЭГ-ын захиалгат судалгааны сэдвийн хүрээнд томьёологдон ирсэн *дутуу шалгуур үзүүлэлт боловсруулах* гэсэн ойлголтыг дараах байдлаар тодорхойлон судалгааны бүхий л шатанд баримталсан. Үүнд, Монгол Улсын *хөгжлийн бодлогын үзэл баримтлалд* тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн тухай ойлголт, *үр дүнд суурилсан менежментийн* өнцгөөс **шалгуур үзүүлэлт боловсруулах нь** дан ганц шалгуур үзүүлэлтийг нэрийг томьёолох тухай асуудал биш түүнийг хэмжих арга зүй, аргачлалын бүрдэл хэсгүүдийг бүрэн тодорхойлох тухай асуудал гэж үзсэн. Энэ үзэл баримтлалын хүрээнд ТХЗ-2030-ын зорилтуудыг хянах шалгуур үзүүлэлт, түүний мэдээллийн эх сурвалж (үүсвэр), мэдээллээ цуглуулах аргачлал, өгөгдөл/утгын шинж, мэдээллийн давтамж зэрэг хэмжилтийн арга зүйн ойлголтуудыг бүрэн биш тодорхойлсон, эсвэл тодорхойлоогүй дутуу орхигдуулсан байхыг ойлгож, **энэхүү судалгаанд ТХЗ-ын Монгол Улсын тодорхойлсон шалгуур үзүүлэлтийг хэмжих арга зүй, аргачлал, бүрдэл хэсэг нь НҮБ-ын тодорхойлсонтой харьцуулж үзэхэд ялгаатай байгаа тохиолдолд “тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт”** гэсэн **ангилалд хамааруулан тооцсон** болно. Учир нь манай улс дэлхийн ТХЗ-ыг нутагшуулахдаа үнэхээр хэрэгжүүлэх боломжгүй аргачлал гэж үзсэн бол түүний үндэслэлийг ул суурьтай, нарийн боловсруулж, Монголд тохирох байдлаар нутагшуулах боломж нь нээлттэй. Гэхдээ НҮБ-ын боловсруулсан мета өгөгдлийн арга зүй, аргачлалыг манай нөхцөлд шууд ашиглаж, тооцох боломж бүрэн байгаа тохиолдолд нь түүнийг нь баримталбал олон улсад харьцуулагдах нөхцөл бүрдэнэ гэж үзлээ. Үүний тулд олон улсын болон Монгол Улсын шалгуур үзүүлэлтийг хэмжих аргачлалын **хувьд ямар ялгаа байна вэ гэдгийг харьцуулж авч үзэх хэрэгцээ** гарсан. Иймээс одоо **тооцож байгаа 133 шалгуур үзүүлэлтээс яагаад, юунаас шалтгаалан заримыг нь орлуулах, ойролцоо утга бүхий шалгуур үзүүлэлтээр хэмжиж байгааг шинжилсэн.** Үүний тод жишээ нь ТХЗ-16.7.2 гэсэн шалгуур үзүүлэлт байлаа. 16.7.2 нь өнөөгийн байдлаар тооцож байгаа шалгуур үзүүлэлтийн ангилалд байгаа ч тус судалгаанд дээрх үзэл баримтлалаар **энэ шалгуур үзүүлэлтийг “тооцоогүй болон дутуу тооцож байгаа” гэж үзэн тусгайлан кейс болгон судлахаар шийдсэн.** Учир нь 16.7.2 шалгуур үзүүлэлтийг НҮБ-ын боловсруулсан мета өгөгдлийн арга зүй, аргачлалын дагуу манай нөхцөлд шууд ашиглаж, тооцох боломж бүрэн байгааг **Удиртгал** бүлэгт тайлбарласан.

Харин **Монгол Улсад тооцох боломжгүй 102 шалгуур үзүүлэлтийг яагаад тооцож болохгүй байгааг ҮСХ болон ЭЗХЯ тус тусдаа өөрсдийн тайлбар, шалтгааныг гаргасан байдаг тул энэ судалгаанд тухайн шалгуур үзүүлэлт хамаарах төрийн байгууллагуудаас сурвалжилж асуух хэрэгцээ гарсан.** Учир нь Монгол Улсын хувьд мэдээлэл гарах боломжгүй байгаагаас шалтгаалан тухайн шалгуур үзүүлэлтийн **суурь түвшин нь** гарах боломжгүй байна гэсэн үг. Энэ үүднээс тус судалгаа нь хоёр хэсгээс бүтсэн. Үүнд:

1. Монгол Улсад ТХЗ-ыг хянах шалгуур үзүүлэлтүүдийн арга зүй, аргачлал, бүрдэл хэсгийг харьцуулах тойм судалгааг хийсэн. Үүнээс:

- тооцож байгаа 133 үзүүлэлтийг Харьцуулсан тойм шинжилгээгээр,
- тооцоогүй байгаа 102 –ыг сурвалжилгын аргаар шинжилсэн ба нийт **235** шалгуур үзүүлэлтийг **хамруулсан**.

2. Эдгээрээс **“тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт”** -ийн ангилалд багтах ТХЗ 16.7.2 шалгуур үзүүлэлтийг кейс болгон судлахдаа 2 үе шаттай судалгаа хийв. Үүнд:


- Туршилт судалгааг Сүхбаатар дүүрэгт
- Үндэсний хэмжээний судалгааг ҮСХ-той хамтран Монгол Улсын хэмжээнд 5 бүс нутгийг хамруулан гүйцэтгэсэн.

Судалгааны эхний хоёр асуултад хариулт авахаар чанарын судалгааг гүйцэтгэсэн ба гурав дахь асуултын хүрээнд тоон тодорхойлох судалгааг хийлээ. Ингээд дээрх гурван асуултын хүрээнд гарсан үр дүнд суурилан дараах дүгнэлтийг хийж байна.

**Нэгдүгээрт,** манай улс ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг өөрийн оронд хэрэгжүүлж буй явцыг судлахын тулд *юуны түрүүнд*, “НҮБ-ын боловсруулсан шалгуур үзүүлэлтийг хэмжих арга зүй, аргачлалаас Монгол Улсын тооцож байгаа шалгуур үзүүлэлтийн хэмжих арга зүй, аргачлалд ямар ялгаа байна вэ?” гэсэн асуултыг дэвшүүлэн судалгааг харьцуулсан тойм шинжилгээ хийсний дүнд дараах дүгнэлтийг хийж байна.

Монгол Улсын ҮСХ-ноос тодорхойлсон ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг хэмжих аргачлал нь НҮБ-аас боловсруулсан арга зүйгээс ялгаатай нийт 33 шалгуур үзүүлэлт тодорхойлогдлоо (Зураг 27-оос харна уу).

## Зураг 27. Харьцуулалтын шинжилгээний үр дүн



Эх сурвалж: Судалгааны үр дүн

Зурагт үзүүлснийг тус тусад нь авч дүгнэвэл:

1. НҮБ-ын зүгээс 2022 оны 6 дугаар сарын 09-ний байдлаар нийт 248 шалгуур үзүүлэлт тодорхойлсон. Өнөөдрийн байдлаар ТХЗ-ын үзүүлэлтүүдийг Түвшин 1 (Tier I), Түвшин 2 (Tier II) гэж хуваан, Түвшин 1-ийн шалгуур үзүүлэлт гэдэгт концепц нь тодорхойлогдсон, олон улсын түвшинд батлагдсан арга зүй, стандарттай ба улс орнууд мэдээллээ доод тал нь 50% нь байнга нийлүүлдэг, харин Түвшин 2-т байгаа шалгуур үзүүлэлт гэдэг нь концепц нь тодорхойлогдсон, олон улсын түвшинд арга зүй болон стандарт нь батлагдсан боловч улс орнуудаас мэдээлэл нь тогтмол нийлүүлэгдэхгүй байгааг, эсвэл аргачлал, стандартыг туршиж байгаа шалгуур үзүүлэлтийг хамааруулсан. Үүнээс Түвшин 1 (Tier I)-д 144 шалгуур үзүүлэлт, Түвшин 2 (Tier II)-т 99 шалгуур үзүүлэлт, Түвшин 1 болон Түвшин 2-т хоёуланд нь нэгэн зэрэг харьяалагдаж байгаа 2 шалгуур үзүүлэлт, тухайн үзүүлэлт болон эх сурвалжаасаа хамааран Түвшин 1 эсвэл Түвшин 2-т хамаарах 2 үзүүлэлт, Түвшин нь тодорхойлогдоогүй хүлээгдэж байгаа 1 шалгуур үзүүлэлт байна.
2. Үүний дагуу Монгол Улсад одоогийн байдлаар ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг өөрийн оронд нутагшуулж буй байдлаас үндэслэн “тооцож байгаа” 133 шалгуур үзүүлэлт /нэг шалгуур үзүүлэлтийн аргачлал гарсан ч тооцоогүй байгаа/, “тооцох боломжгүй байгаа” 102 шалгуур үзүүлэлт, “хамааралгүй” 13 шалгуур үзүүлэлт байгаа буюу үндсэндээ Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлсэн 132, хэрэгжүүлээгүй 103 шалгуур үзүүлэлт байна.



Энд “хамааралгүй 13” шалгуур үзүүлэлт ороогүй болно.

3. Монгол Улс дэлхийн ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн 53.2% (=132/248)-ийг тооцож байгаа боловч манай улсын ҮСХ-ноос нийт 133 шалгуур үзүүлэлтийн хэмжилт хийх арга зүйг боловсруулснаас тооцож байгаа 132 үзүүлэлт, тооцох боломжгүй байгаа 1 үзүүлэлт багтаж байна. Эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг хэмжих арга зүйг НҮБ-аас боловсруулсан мета дататай харьцуулсан тойм шинжилгээгээр шинжлэхэд **33 шалгуур үзүүлэлтийг хэмжих аргачлал нь 24.8% (=33/133)-ийн ялгаатай байна.** Өөрөөр хэлбэл, шалгуур үзүүлэлтийн хэмжилт хийх аргачлалыг харьцуулсан нийт 133 шалгуур үзүүлэлт байгаагаас 100 шалгуур үзүүлэлт нь НҮБ-ын ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн орчуулгын агуулга бүрэн нийцсэн, тооцох арга зүй нь олон улсын аргачлалтай тохирч байгаа бол үлдсэн 33 буюу 24.8% (=33/133) нь шалгуур үзүүлэлтийн хувьд олон улсын тооцох аргачлал болон орчуулгын агуулгаас зөрүүтэй байна. Иймээс **энэ судалгаанд эдгээр 33 шалгуур үзүүлэлт, мөн тооцох боломжгүй байгаа 102<sup>42</sup> шалгуур үзүүлэлтүүдийг, нийт 135 шалгуур үзүүлэлтийг Монгол Улсын хувьд “тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт” гэж үзлээ.**

Энэхүү “тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт” -ийн ангилалд багтах **33 шалгуур үзүүлэлтийн** 3 шалгуур үзүүлэлтийн аргачлалыг нь Монгол Улсын ҮСХ-ноос хэмжилт хийх аргачлалыг нь боловсруулаагүй, 4 шалгуур үзүүлэлтийн хувьд Монгол хэлнээ хөрвүүлэхдээ нэрний агуулгыг нь бага зэрэг зөрүүтэй орчуулсан боловч хэмжилт хийх арга зүй нь НҮБ-ын аргачлалтай яг тохирч байгаа болно. Үлдсэн 26 шалгуур үзүүлэлтийн хувьд шалгуур үзүүлэлтийн хэмжилт хийх арга зүй нь олон улсын аргачлалаас зөрүүтэй байна. **Эдгээр 33 шалгуур үзүүлэлтээс нэг шалгуур үзүүлэлт буюу 16.7.2 шалгуур үзүүлэлтийг Үндэсний хэмжээнд НҮБ-ын мета өгөгдөлд өгсөн аргачлалаар судалж, үр дүнг гаргасан нь “тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт”-ээс нэг шалгуур үзүүлэлтийн суурь түвшний ерөнхий хандлага тодорхойлогдож, 32 шалгуур үзүүлэлт үлдлээ гэж дүгнэж байна.**

*Хоёрдугаарт,* “ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн бэлэн байдлыг хангах зорилгоор холбогдох төрийн байгууллагуудад 2016 оноос хойш хариуцуулсан боловч өнөөг хүртэл “тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт” буурахгүй байгаагийн шалтгаан нь юутай холбоотой байна вэ?” гэсэн судалгааны асуултын хүрээнд ТХЗ-ын Монгол Улсад гарахгүй байгаа буюу тооцоогүй байгаа 102 шалгуур үзүүлэлтүүдийн шалтгааныг тодруулахаар бүтэцлэгдсэн сурвалжилгаар шалгуур үзүүлэлт нь гараагүй байгаа гэдэгт хамаарах төрийн 14 байгууллагын (ЭЗХЯ, ҮСХ-ноос тодорхойлсноор 26-29 байгууллагад хамаарч байна) зорилтот түүврээр хамруулсан 20 ТЗАХ-

<sup>42</sup> Тооцох боломжгүй байгаа 103 шалгуур үзүүлэлт байгаа боловч үүний нэг шалгуур үзүүлэлт нь ҮСХ-ноос хэмжилт хийх арга зүйг боловсруулсан 133 шалгуур үзүүлэлтэд давхар тоологдсон тул нийт 102 шалгуур үзүүлэлтийг тооцох боломжгүй байгаа хэмээн тайлбарлав.

тай ярилцлаа. Эдгээр оролцогчид нь тухайн байгууллагад *ТХЗ-ын* шалгуур үзүүлэлтийг тооцох ажилд шууд ба шууд бусаар хамаарахуйц үүргийг хүлээсэн *байх магадлалтай гэж үзсэн статистик судалгаа хариуцсан, хяналт, шинжилгээ үнэлгээ, төрийн захиргаа, бодлого төлөвлөлт, санхүү бодлого, төсөв* зэрэг чиглэлээр ажиллаж буй албан хаагчид байсан ба судалгааны ёс зүйн зарчмыг баримтлан нэр ус, албан тушаал, байгууллагын нэршлийг кодлон ярилцсан. Монгол Улсад ТХЗ-ын 102 тооцохгүй байгаа шалгуур үзүүлэлтийн шалтгааныг тодруулахдаа **“Шалгуур үзүүлэлтийг тооцоход тулгарч буй хүндрэл”** гэсэн ерөнхий категорийн хүрээнд (давтамжийн тоо 66) ярилцахад **6 төрлийн үндсэн шалтгаан/хүндрэл бэрхшээл тулгарч** байдгийг тодорхойлсон. Өмнө нь ҮСХ болон ЭЗХЯ-наас гаргах боломжгүй байгаа 102 шалгуур үзүүлэлтэд шинжилгээ үнэлгээ хийж, тодорхой шалтгааныг тайлбарласан байдаг. Тухайлбал, ҮСХ-ны үнэлгээгээр *“Мэдээллийн эх үүсвэр хангалтгүй. Мэдээллийн эх үүсвэр, арга зүй тодорхойгүй. Туршилтаар түүвэр судалгаа хийгдсэн боловч үр дүн хэт өндөр зөрүүтэй гарсан тул нягтлах, хэлэлцэх шаардлагатай. Өрхөд суурилсан судалгааг бий болгох, одоо зохион байгуулж байгаа судалгааны асуулгад нэмэлт хийж мэдээллийн эх үүсвэрийг бий болгох, Одоогийн байгаа нь жижиг түүвэр дээр үндэслэсэн урьдчилсан тооцоолол, дараагийн ӨНЭЗС-аар мэдээлэл цуглуулж бүрэн тооцно. Туршилт тооцоолол 2018 оны мэдээлэл дээр хийгдсэн. Тооцох боломжийг судалж байна. Тооцооллыг сайжруулах шаардлагатай”* гэсэн 20-иод төрлийн шалтгааныг тоочсон байдаг. Харин ЭЗХЯ-наас *“1-мэдээлэл бэлэн, 2-бэлэн байгаа мэдээлэлд нэмэлт тооцоолол хийж гаргах, 3-гарах боломжтой боловч үзүүлэлтийг нарийвчлан задлах үүднээс мэдээллийн эх үүсвэрийг бий болгох, 4-мэдээллийн эх үүсвэрийг шинээр бий болгох”* гэсэн 4 төрлөөр ангилж, 2-4-р ангилалд багтах нь **“тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт”** гэж тооцогдохоор байгаа. Гэхдээ ҮСХ болон ЭЗХЯ-ны аль аль нь нэгдмэл байдлаар шалтгааныг тайлбарлаагүй, зөрүүтэй байгаа нь тэдний шалтгааныг ангилсан тайлбараас харж болно. Иймээс энэ судалгаанд тооцож гарахгүй байгаа 102 шалгуур үзүүлэлт яг юунаас болоод буйг тухайн байгууллагын хариуцаж буй хүмүүстэй нь ярилцсанаар бодит шалтгаан тодорхой түвшинд илрэх магадлалтай гэж үзсэн.

Ингээд дүгнэхэд,

1. **“ТХЗ хариуцсан хүний нөөц, удирдлага, зохион байгуулалт”**-аас шалтгаалсан бэрхшээл хамгийн олон давтамжтай (20) илэрсэн дэд утга ба дотроо 4 үндсэн санааг агуулж байсан.

- Ажил үүрэгт нь ТХЗ-ыг хариуцах үүрэг тодорхойлогдсон эсэх дээр *14 ТЗБ-ын 3 байгууллагад ажил үүрэгт нь заасан. 11 байгууллагад ТХЗ-ын хариуцах ажил үүргийн хуваарилалт хийгдээгүй.*
- Удирдлага ач холбогдол өгдөггүй, байгууллага дотор уялдаа холбоогүй.
- Төрийн захиргааны байгууллагад аль ч түвшинд хүний нөөцийн тогтворгүй байдлаас шалтгаалсан ажлын залгамж холбоо сул тул

өмнөх хүн юу хийж байсныг дараагийн ирсэн хүн мэддэггүй.

- ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн судалгаа, тооцоог удирдах ажилтнууд ашигладаггүй.

2. **“Албан ёсны шийдвэр гараагүйтэй холбоотой (албажаагүйтэй холбоотой)”** (10) гэж үзсэн. Жишээ нь: (ТБ-7)- *“Тооцох ёстой гэж бид нараас тоо нэхэгддэггүй. Яам учраас ҮСХ-ноос үүрэг чиглэл ирэхэд хэцүү байх, гэхдээ ЗГХЭГ-аас бидэнд үүрэг чиглэл болгоод ирүүлбэл болохгүй юм байхгүй байх гэж бодож байна”.*

3. **“Байгууллагууд хоорондоо уялдаа холбоо, харилцаа сул ба үл ойлголцол”** (14) ихтэй тул хамтарч ажиллаж гарах тооцооллыг гаргахад хүндрэлтэй.

4. **“Өгөгдөл, мэдээллийн шинж чанараас шалтгаалсан”** (5) хүндрэл байдаг. Жишээ нь, ТБ-2 – *“тухайн шалгуур үзүүлэлт нь чанарын үзүүлэлт бол тооцоогүй байх шалтгаантай. Чанарын судалгааг бид яаж тооцохыг мэдэхгүй.”*

5. **“Мэдээллийг тооцох арга зүйгээс шалтгаалсан”** (13) бэрхшээл бас нэг шалтгаан болж байна. ТБ5: *“Тодорхой судалгааны баг, зөвлөх баг томилоод бидний гаргаж буй үндэсний үзүүлэлт аргачлал нь олон улсын аргачлалтай таарч байна уу зэрэг нарийвчилсан зөв ойлголттой болох хэрэгтэй байна”.*

- 6. **“Хөрөнгө санхүүжилтээс шалтгаалсан хүндрэл”** тулгардаг (4) гэж үзсэн.

Дээрх хүндрэл бэрхшээлийн шалтгааныг тодруулснаас гадна ер нь **“тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлтийг тооцон гаргах боломж байгаа”** (давтамж 11) эсэхийг тодотгоход *“Байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах” чухал гэсэн гол санаа илэрсэн. Дүгнэж үзэхэд:*

- чиглэл чиглэлийн байгууллагууд хамтран ажиллаж, мэдээллээ хуваалцвал тооцох бүрэн боломжтой (ТБ-1, ТБ- 7, ТБ- 6, ТБ-12, ТБ-19)
- дээд түвшинд ТХЗ-ыг хариуцан судалж, тооцох тухай албан ёсны шийдвэр гарсан тохиолдолд ажил хэрэг болж, хамтран ажиллаж хэрэгжих боломжтой (ТБ – 5)
- төр болон хувийн хэвшил, иргэний оролцоотойгоор хэрэгжүүлэх боломжтой (ТБ-19, ТБ-15)
- ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг тооцох статистик мэдээллийг давхардалгүй болгох, арга зүйн сургалт, зөвлөгөөгөөр хангаж ажиллах (ТБ-16, ТБ-11) нь чухал байна.

Иймд тулгарч буй хүндрэл бэрхшээлийн бодит шалтгааны мөн чанарыг эдгээр судалгаанд оролцогчдын тайлбар тодорхой хэмжээнд илтгэж байна гэж дүгнэж болно.

**Гуравдугаарт, “тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт”**- ээс кейс болгож сонгож авсан ТХЗ 16.7.2-ын хувьд, “Олон нийтэд хамаарах бүх түвшний шийдвэр гаргалт нь олон нийтийг тэгш оролцуулсан, иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй байдаг гэдэгт Монгол Улсын хүн амын итгэх хувь нь хүйсээр, насны бүлгээр, байршлаар, хөгжлийн бэрхшээлтэй хүн амаар,

боловсролын түвшин, орлогын бүлгээр хэд байна вэ?” гэсэн судалгааны асуултын хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна. Юуны өмнө, төрийн байгууллагууд хамтран ажиллаж, судалгаа, шинжилгээг хамтран хийснээр ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг НҮБ-ын мета өгөгдөлд зөвлөсөн аргачлалын дагуу тооцох боломжтойг бидний судалгааны кейс болгож сонгож авсан 16.7.2 шалгуур үзүүлэлтийн судалгаа харууллаа. НҮБ-ын санал болгосон **16.7.2-ын арга зүйг Монгол Улсад шууд ашиглаж, тооцох боломжтой ба улмаар олон улсын хэмжээнд зөвлөсөн арга зүйг баримталснаар суурь тооцооллыг гаргаж ирэхээс гадна дэлхий нийтэд харьцуулагдах нөхцөл байдал бүрдэж байгаа** юм. Иймээс Удирдлагын академийн судлаачид энэ арга зүйгээр ҮСХ-той хамтран ажиллаж, Монгол Улсад **энэ шалгуур үзүүлэлтийн суурь түвшинг дэлхийн олон оронд туршигдсан олон улсын аргачлалаар тодорхойллоо гэж дүгнэж болохоор байна.** Судалгааны үндсэн үр дүнгээс харахад *тогтолцооны хариу үйлдлийн чадварыг илэрхийлэх шийдвэр гаргалтын гадаад үр дүн* нь түүвэрт хамрагдсан 4325 хүний хувьд хоёр асуултад **эергээр хариулсан хүний дундаж 36.6%**, эх олонлогт тархаасан дүнгээр үзвэл **35.5%**-тай байна. Эндээс дүгнэхэд үндэсний түвшинд түүврийн ажиглалтын утга **36.6%**-ийн дүнтэй гарсан нь судалгааны багийнхны өмнө нь Сүхбаатар дүүрэгт хийсэн туршилт судалгааны **36.6%**-тай ижил байгаа нь тус судалгааны найдвартай байдлыг илтгэж буйн нэг илрэл гэж үзэж байна.

### САНАЛ ЗӨВЛӨМЖ

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод НҮБ-аас дэвшүүлсэн нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийн бодлого тусгалаа нэгэнт олсон билээ. НҮБ-аас боловсруулж гаргасан нийт 248 шалгуур үзүүлэлтийн 132-ийг нь Монгол Улсад тооцож байна. “Алсын хараа-2050” бодлогын баримт бичгээс түлхүүр үгүүдээр нэг бүрчлэн хайлт хийхэд ТХЗ-ын 248 шалгуур үзүүлэлтийн 95 нь буюу 38.3%<sup>43</sup> нь “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигтэй шууд уялдаа холбоотой байна. Иймд дэлхийн ТХЗ-ыг хэрэгжүүлнэ гэдэг нь Монгол Улсын урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэх нэг арга зам болох нь харагдаж байгаа тул дээрх ерөнхий дүгнэлтэд үндэслэн шийдэл болгоход хувь нэмэр оруулах зорилгоор **4 чиглэлээр** дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна.

**Нэгдүгээрт,** өнөөдрийн байдлаар тооцож байгаа 133 шалгуур үзүүлэлтэд харьцуулсан тойм шинжилгээний дүнд 33 шалгуур үзүүлэлт НҮБ-ын мета өгөгдлийн зөвлөмжөөс ялгаатай байгаа нь энэ судалгаагаар тогтоогдлоо. Иймээс ТХЗ-ын эдгээр дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлтүүдийн суурь түвшинг тодорхойлохын тулд хамаарах төрийн захиргааны байгууллагууд өөрсдөө дахин нягталж, НҮБ-ын аргачлалын дагуу судлах боломжтой

<sup>43</sup> Монгол Улсын “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигтэй шууд уялдаа холбоотой гэж тооцогдсон 95 үзүүлэлтийг НҮБ-аас гаргасан 248 шалгуур үзүүлэлтэд харьцуулж хувиар илэрхийлсэн.

гэж үзвэл санаачилга гарган, хамтран ажиллавал энэ зорилтууд биелэх боломжтойг бидний хийсэн 16.7.2 шалгуур үзүүлэлтийн судалгааны жишээ харууллаа. Хэрэв НҮБ-ын аргачлалыг дагах боломжгүй гэдэг үндэслэлийг нь ул суурьтай тогтоовол, манай улсын нөхцөл байдалд тохирсон аргачлалыг боловсруулахад **байгууллага хоорондын хамтын ажиллагааны зохион байгуулалтыг тодорхой болгох** нь чухал юм.

Учир нь тооцоогүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлт тус бүрийг судлахад олон салбарын мэргэжлийн хүний нөөц, мэдлэг, мэдээлэл, цаг хугацаа, хөрөнгө мөнгө, шаардагдах нь тодорхой билээ. Жишээ нь, "3.9.2. Баталгаагүй ундны ус, эрүүл ахуйн шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжаар нөхцөлдсөн нас баралтын түвшин (10 000 хүнд ногдох)" гэх мэт үзүүлэлтүүдийн мэдээллийн эх үүсвэрийг гаргахад дээр дурдсан цаг хугацаа, хөрөнгө мөнгө, мэргэжлийн хүний нөөц шаардагдана. Гэхдээ нэг зүйл нь маш тодорхой юм. Энэ нь улс орны хөгжлийн зорилгыг тодорхой чиглэлээр тодорхой түвшинд хүргэнэ гэж тодорхойлохын тулд тухайн шалгуур үзүүлэлт тус бүрээр **нэгдүгээрт**, ямар арга зүйгээр, яаж, хэн мэдээллээ цуглуулахаа тодруулж, **хоёрдугаарт**, тухайн арга зүйгээр судалгаа хийж **эхний түвшингээ тодорхойлсноор дараагийн хүрэх түвшингээ тодорхойлох шаардлага** гарч ирнэ.

Иймээс ЭЗХЯ болон ҮСХ нь ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг тооцож гаргадаг байгууллага хоорондын мэдээллийн түгээлт, нийлүүлэлт, статистик тоон мэдээллийн зөрүүтэй байдлын тухай мэдээлэл солилцох гэх мэтээр **хамтран ажиллах тодорхой чиглэлүүдийг тодорхойлж, он, сар, хугацааны хуваарийг гаргаж, тухай бүр албан бичиг хүлээлгүйгээр мэдээллээ нийлүүлж байх зохион байгуулалтыг бий болгож, ТХЗ-ыг тооцож гаргах байгууллагуудын өгөгдөл, мэдээллийн шинж чанар, тухайн байгууллага ямар өгөгдөл цуглуулах, нийлүүлэх боломжтойг харилцан ярилцаж, хүндрэлтэй байгаа тохиолдолд аль байгууллагатай хамтран ажиллаж даван туулах боломжийг хайх зөвлөлдөх сувгийг** бий болгож ажиллавал үр дүнтэй гэж үзэж байна. Ингэснээр ТХЗ-ыг тухайн хамаарах байгууллагууд дотроо тодорхой ажилтан болон албан тушаалтны үүрэг хариуцлагад багтаан /судалгаагаар 14 байгууллагаас 4 байгууллагад ийм үүрэг хариуцлагатай ажилтан байгаа нь тогтоогдсон/, тооцооллыг гаргаж ажиллуулах, мэдээллийг цуглуулах байгууллагын дотоод уялдаа холбоог хангах зохицуулалтыг бий болгох нөхцөл бүрдэх болно.

**Хоёрдугаарт**, нэгэнт манай улс дэлхийн ТХЗ-ыг хэрэгжүүлэх үүргийг олон улсын өмнө хүлээж, НҮБ-аас зохион байгуулж байгаа ТХЗ-ын асуудлыг хэлэлцдэг хурал чуулганд оролцож сайн дурын илтгэл хэлэлцүүлдэг, одоо 2021 оны Үндэсний илтгэлийг бичих тухай зарлаад байгаа энэ нөхцөлд хамаарах байгууллагууд, тухайлбал, **ЭЗХЯ, ҮСХ нь хамтран албан ёсны шийдвэрийг** төрийн байгууллага, их дээд сургууль, судалгаа шинжилгээний байгууллага, бусад хамаарах хувийн болоод төрийн бус байгууллагуудад өөрсдийн зүгээс

хүргүүлж, эхний нөхцөлийг бүрдүүлэх боломж байна гэж үзэж байна. Хэдийгээр НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудыг хэрэгжсэн цагаас нь эхлэн манайд хариуцаж гаргадаг байгууллага, институцийн бүтэц бүрэлдэн тогтоогүй байгаа, энэ нь сайн дурын гэсэн тодотголтой байгаа ч Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдаатай тул хөгжлийн хүрэх түвшинг тодорхойлохын тулд суурь түвшнээ мэдэх хэрэгцээ байна. Иймээс ЭЗХЯ болон ҮСХ нь ТХЗ-ын мэдээллийг бүрдүүлэх гол байгууллагын хувьд өөрсдийн түвшинд тодорхой шийдвэр гаргаж, бусад байгууллагуудтай харилцаж, ТХЗ-ыг тооцохгүй болон дутуу тооцож байгаа шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг сайжруулах боломж байна гэж үзэж байна. Ингэж байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулснаар тулгарах хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдэх гарц буй болно. Жишээлбэл, 16.7.2 шалгуур үзүүлэлтийн тооцооллыг ҮСХ, Удирдлагын академи хоёр байгууллага өөрсдийн хүний нөөц, хөрөнгө, цаг хугацаа, боллоцгоог хамтатгасны үр дүнд хийлээ.

**Гуравдугаарт,** тооцохгүй байгаа 102 шалгуур үзүүлэлтийн тухай оролцогчдын өгсөн санал зөвлөмжид үндэслэн санал болгоход ТХЗ-ын эдгээр шалгуур үзүүлэлтийн чиглэлээр судалгаа хийх, мэдээлэл цуглуулах, агуулгыг нь харилцан ярилцаж ойлгуулах **сургалт, семинарыг хамаарах албан хаагч, хүмүүсийн дунд зохион байгуулж,** хамтран ажиллуулах шаардлага байна. Жишээ нь, манай Удирдлагын академи шиг сургалт, судалгаа эрхэлсэн байгууллагатай тодорхой шалгуур үзүүлэлтийн мэдээллийн эх үүсвэрийг бий болгох чиглэлээр хамтран судалгаа хийж, эсвэл сургалт явуулах боломж байна. Мөн хамаарах байгууллагуудаас сургалтад оролцсон иргэдийн ажил солигдвол тухайн мэдээлэл алдагдахгүй, орхигдохгүй байлгахаар хэрхэн зохицуулах зөвлөмж гаргаж хүргүүлэх, ЭЗХЯ, ҮСХ-ноос хамаарах байгууллагуудтай хамтран дээрх семинар, сургалт, хэлэлцүүлгийг хийж, аль байгууллага, аль чиглэлээр мэдээлэл цуглуулах, судлах боломжтойг зөвлөн чиглүүлэх хэрэгтэйг энэ судалгаа харууллаа. Энэ нь **байгууллага хоорондын хамтын ажиллагааг зохион байгуулах хүрээнд** НҮБ-ын ТХЗ-ын мета өгөгдлийн арга зүй, аргачлалын тухай сургалт, семинар, хамтын хэлэлцүүлэг хийх тухай асуудал юм.

**Дөрөвдүгээрт,** нэгэнт ТХЗ-ын 16.7.2 шалгуур үзүүлэлтийн **суурь түвшин** эхний байдлаар түүврийн хувьд 36.6%, эх олонлогт тооцсоноор 35.5% гэсэн ерөнхий хандлага нь тогтоогдсон тохиолдолд **зорилтот түвшинг хэрхэн тодорхойлж,** уг түвшинг сайжруулахын тулд төрийн бодлого, үйл ажиллагааг **“Олон нийтийг тэгш оролцуулсан шийдвэр гаргалт”, “Иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй шийдвэр гаргалт”**-ын чиглэлд сайжруулах хэрэгцээ байгааг гол үүрэг бүхий ЭЗХЯ нь, мөн ҮСХ нь бодлогын түвшинд Засгийн газарт санал болгож ажиллах боломж байна.

Түүнчлэн дэлхийн ТХЗ-2030-ын НҮБ-аас санал болгосон зөвлөмжид зааснаар ТХЗ-ын 16.7.2 шалгуур үзүүлэлтийг тооцохдоо

1. хүйсээр
2. насны бүлгээр
3. байршлаар
4. орлогын бүлгээр
5. боловсролын түвшнээр
6. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн
7. бүсийн хувиар илэрхийлэхийг заасны дагуу задаргааг хийж энэ судалгааны үр дүнг эх олонлогт тархаан тооцлоо.

Судалгааны дүнгээс харахад **шийдвэр гаргалтын гадаад үр дүнг** хэмжиж буй **"Олон нийтийг тэгш оролцуулсан шийдвэр гаргалт", "Иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй шийдвэр гаргалт"**-ын талаарх иргэдийн санаа бодлыг авч үзэхэд дараах задаргаанууд илүү анхаарал татлаа. Үүнд:

- хүйсийн хувьд авч үзэхэд эмэгтэйчүүдийн 36.7% нь, эрэгтэйчүүдийн 34.1% нь эерэг хариулт өгсөн нь эрэгтэйчүүдийнхээс 2.6 пунктээр их байв.
- насны бүлгийн хувьд, 25-34 насны залуучууд 63.2% буюу хамгийн өндөр хувийн сөрөг хариулт өгсөн байхад 65 ба түүнээс дээш насны ахмад настнуудын 50.3% нь эерэг хариулснаараа хамгийн өндөр эерэг хариултыг өгсөн насны бүлэг байна.
- амьдарч буй газар, байршлын хувьд авч үзэхэд, эерэг хариулсан хүний дундаж хувь хөдөөд 42.0% хотод 32.4% байгаа нь хөдөөд хотынхоос 9.6 пунктээр илүү байна.
- боловсролын түвшнээр авч үзэхэд, судалгаанд хамрагдагчдаас докторын зэрэгтэй иргэдийн дөнгөж 11.2% нь эерэг, удаалаад магистрын зэрэгтэй хүмүүсийн 28.4% нь эерэг хариултыг өгсөн байхад бусад боловсролын зэрэгтэй хүмүүсийн хувьд эерэг хариултын хувь харьцангуй өндөр буюу 30%-с дээш байна. Ялангуяа бага боловсролтой иргэдийн эерэг хариулт 46.1% байгаа нь хамгийн өндөр байна.
- орлогын бүлгээр авч үзэхэд, эерэг хариулсан 300 мянган төгрөг хүртэлх орлоготой хүмүүсийн дундаж хувь 24.7 хувь байгаа нь хамгийн бага үзүүлэлт байна. 500 мянган төгрөгөөс 700 мянган төгрөг хүртэлх орлоготой хүмүүс эерэг хариултыг хамгийн өндөр буюу 43.2%-тай өгсөн бол 300 мянган төгрөг хүртэл орлоготой иргэдийн сөрөг хариулт 70.3% байгаа нь өндөр сөрөг хариулт байна.
- Эх олонлогт тархаасан тооцоогоор үйлдлийн чадварын хүндрэлтэй гэж тодорхойлогдсон хүн амын 39.0 хувь нь эерэг хариулсан бол 48.7 хувь нь сөрөг хариулт, үүний дотор Алхах үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын хувьд дунджаар 82.9 хувь нь асуулт 1, асуулт 2-т сөрөг хариулт өгсөн байна.

- бүсийн хувьд, төвийн бүсэд амьдарч буй иргэдийн 63.9 хувь нь, Улаанбаатарт амьдарч буй иргэдийн 66.1 хувь нь сөрөг хариулт өгсөн нь хамгийн өндөр хувьтай байна. Харин баруун бүсэд амьдарч буй иргэд хамгийн өндөр хувийн эерэг хариултыг өгчээ (48.2%).

Судалгааны үр дүнгээс гарсан үзүүлэлтэд үндэслэн, энэ бүлгийн иргэдэд шийдвэр гаргалтын гадаад үр дүн **хэрхэн тусч буйг** харах боломж гарч байгаагаас гадна төрийн бодлого, үйл ажиллагааг **“Олон нийтийг тэгш оролцуулсан шийдвэр гаргалт”, “Иргэдийн саналыг тусгасан үр дүнтэй шийдвэр гаргалт”**-ыг эдгээр бүлгийн иргэдэд чиглүүлэн сайжруулах чиг баримжааг байж болно гэж үзэж байна.

Түүнчлэн **“Олон нийтийг ялгаварлалгүй оролцуулсан шийдвэр гаргалт”** гэсэн ойлголтын хүрээнд цаашид судалгаа хийх боломжтой гэж үзсэн.



## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

### Монгол хэлээр:

Монгол Улсын Үндсэн Хууль. 1992. Улаанбаатар.

Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, 2017. Улаанбаатар

Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, 2020. Улаанбаатар

“Алсын хараа 2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого. Монгол Улсын Засгийн газар. Улаанбаатар. 2020

Монгол Улсын Засгийн газар. 2019, Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт, Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл. Үндэсний хөгжлийн газар, Улаанбаатар

Монгол Улсын Хөгжлийн бодлогын тогтвортой байдал, залгамж чанар, уялдаанд хийсэн шинжилгээ: Тайлан 1. 2018. Үндэсний Хөгжлийн газар, НҮБ, Улаанбаатар

Монгол Улсын Хөгжлийн бодлогын уялдаа холбоонд үнэлгээ хийх, бодлогын хүрэх түвшинг тодорхойлох арга зүй: Тайлан 2. 2018. Үндэсний Хөгжлийн газар, НҮБ, Улаанбаатар

Монгол Улсын дунд хугацааны (2020-2025) Тогтвортой Хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл: Тайлан 3. 2018. Үндэсний Хөгжлийн газар, НҮБ, Улаанбаатар

Монгол Улсын дунд хугацааны (2018-2025) хөгжлийн хүрээ: Тайлан 4. 2018. Үндэсний Хөгжлийн газар, НҮБ, Улаанбаатар

Монгол Улсын Хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийг хийх нийтлэг аргачлал: Тайлан 5. 2018. Үндэсний Хөгжлийн газар, НҮБ, Улаанбаатар

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, 2021, Тогтвортой хөгжлийн зорилгын мэдээлж буй шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал. Улаанбаатар “Ардчилсан засаглал судалгаа”-ны 2017-2020 оны үр дүн. Үндэсний Статистикийн Хороо. Улаанбаатар. 2021

Азийн сан. 2017. Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа. Монгол Улсад ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх нь төсөл.

Ариунзаяа, А., 2019. ҮСХ, Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг дүгнэх, мэдээлэх чиглэлд ҮСХ-ноос хийгдэж буй ажлууд

Баатартогтох, Ц., 2010. Нийгмийн шинжлэх ухааны судалгааны арга зүй. Улаанбаатар.

Батсүх, Ш., Долгоржав, Я., Ганцоож, Б., 2014. Шууд Ардчилал-Иргэдийн оролцоо: Иргэний танхим, Орон нутгийн хөгжлийн сан. Конрад-Аденауэр

Сан, Удирдлагын Академи, Улаанбаатар

Бямбажав, Я., 2007. Бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явц дахь ТББ-ын оролцоо: эрх зүйн орчин ба институтчилал. Нээлттэй Нийгэм Форум. Улаанбаатар

Бямбасүрэн, Я., Доржсүрэн, П., Цэрэнчимэд, О., Намхайдагва, Д., Амарбаясгалан, Д., Төрийн бодлого. 2021. Конрад-Аденауэр Сан, Улаанбаатар  
Долгоржав, Я., 2020. Төрийн захиргааны шинжлэх ухааны үүсэл, хөгжлийн тойм. Улаанбаатар

Долгоржав, Я., 2021. Төрийн Захиргаа: Судалгааны өгүүлэл, нийтлэлүүд. Конрад-Аденауэр Сан, Улаанбаатар

Жон Юл ли, Чад Андерсон. (2012). Төрийн бодлого. Орч. А.Цанжид. Улаанбаатар  
